

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-66

<i>1.Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл</i>	6-57
---	------

<i>2.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэх</i>	57-66
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 26-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Х.Нямбаатар, Ц.Сэргэлэн.

Нэг.Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Д.Сүнжид, Б.Энхболд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн П.Сайнзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор У.Золжаргал, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, мөн газрын Мэдээлэл дүн шинжилгээний газрын хэлтсийн дарга С.Анхбаяр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Харуул хамгаалалтын хэлтсийн дарга Ц.Хишигбаяр, Мөрдөн байцаах албаны дарга Б.Батсуурь, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Багчулуун, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Ганзориг, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Э.Сэргэлэн, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Сүхбат, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга Т.Лхагвадорж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын дарна Д.Отгонжаргал, Дотоод хэргийн их сургуулийн ЭШНХ-ийн захирал С.Гантулга, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал Н.Ариунтариа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын

газрын дарга Б.Батсүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ахлах референт Э.Ганцэцэг, Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга Б.Алтантулга, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Н.Адьяадорж, Хэвлэлийн хүрээлэнгийн ТУЗ-ийн гишүүн Б.Ганзориг, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Хууль, мэргэжлийн ёс зүй хариуцсан дэд ерөнхийлөгч З.Боргилмаа, Монголын сайтын холбооны хяналтын зөвлөлийн дарга Г.Нямтайсанжаа, Монголын телевизүүдийн холбооны тэргүүн А.Баярбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Г.Чингүнжав нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Ахмад настны эрхийн хэрэгжилт” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул танилцуулга хийв.

“Ахмад настны эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга Б.Батсүх, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал Н.Ариунтариа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Дэлгэрсайхан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Ахмад настны эрхийн хэрэгжилт” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдал” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид танилцуулга хийв.

“Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдал” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдал” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд танилцуулга хийв.

“Халдашгүй чөлөөтэй байх эрх” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаан 13 цаг 00 минутад түр завсарлаж, 14 цаг 07 минутад эхлэв.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа танилцуулга хийв.

“Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, Хэвлэлийн хүрээлэнгийн ТУЗ-ын гишүүн Б.Ганзориг, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Хууль, мэргэжлийн ёс зүй хариуцсан дэд ерөнхийлөгч З.Боргилмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт” сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов танилцуулга хийв.

“Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт” сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт” сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг, мөн хэлтсийн ахлах референт Д.Түвшинтөр, референт Р.Нэнсэндэн, ахлах мэргэжилтэн Г.Дэлгэрбаяр, Д.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн П.Сайнзориг, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Батсуурь, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, Улсын Ерөнхий прокурорын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор У.Золжаргал, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга Ч.Нэргүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Г.Чингүнжав нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн хийв.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг сонсов.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл болон Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын санал хураалтыг гар өргөж явуулав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 51 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим 10 цаг 34 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн өнөөдрийн өглөөний амгаланг айлтгая.

Байнгын хорооны 2023 оны 4 сарын 26-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье. Ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна. Адьшаа гишүүн ирсэн байна. Алтанхуяг гишүүн чөлөөтэй. Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Бямбацогт гишүүн ирсэн байна. Ганбат гишүүн томилолттой. Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Мөнхбаатар гишүүн чөлөөтэй. Мөнх-Оргил гишүүн томилолттой. Мөнхцэцэг гишүүн томилолттой. Нямбаатар гишүүн томилолттой. Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Раднаасэд гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Сүхбаатар гишүүн ирсэн байна. Сэргэлэн гишүүн чөлөөтэй. Учрал гишүүн Засгийн газрын хурал хуралдаж байна. Одоо орж ирэх хэрэгтэй байна. Цогтбаатар гишүүн томилолттой. Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хүний эрхийн үндэсний комиссоос 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг илтгэлийн дараах сэдвүүдийг хэлэлцэнэ. Үүнд:

Нэгдүгээрт, Ахмад настны эрхийн хэрэгжилт

Хоёрдугаарт, Улс төрийн хүрэн дэх жендерийн эрх, тэгш байдал

Гуравдугаарт, халдашгүй чөлөөтэй байх эрх

Дөрөвдүгээрт, Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт

Тавдугаарт, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт

Хоёрдугаарт, Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хэрэглэсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа орё ажлын хэсгийг оруулаарай. Учрал гишүүн хүрэлцэн ирсэн байна. Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулж байгаа юм уу?

Хуралдаанд оролцож байгаа. Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлтэй холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хунан Хүний эрхийн үндэсний комиссын дарга, Дондов Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Мөнхзул Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Нарантуяа Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Сүнжид Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Энхболд Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяхишиг Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын дарга, Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн ажлын албаны дарга, Билгүүн Төрийн албаны зөвлөлийн

ажлын албаны дарга, Үнэнтөгс Хүний эрхийн үндэсний комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Өнөржаргал Хүний эрхийн үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга, Ууганбаатар Хүний эрхийн үндэсний комиссын Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн дарга, Баярболд Нийслэлийн Эрүүл мэндийн дарга, Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мандухай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Мөнхбаяр Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга, Батсуурь Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа, Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Ариунтариа Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал, Батсүх Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга, Оюуннасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ахлах референт, Ганцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн референт, Энхбаяр Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Цогтбаатар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга, Ганболд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга, Алтантулга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга, Гэрэлт-Од Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Адъяадорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Одончимэг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хуульч, Ихтамир Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Өнөржаргал Монголын Хуульчдын

холбооны зөвлөлийн гишүүн, хуульч гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Одоо мөн Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Ахмад настны эрхийн хэрэгжилт” сэдвийн талаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Хүрэлбаатарын Мөнхзул танилцуулга хийнэ. Мөнхзул гишүүн 5 номерын микрофоныг өгье.

Х.Мөнхзул: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр Хүний эрхийн үндэсний комисс энэ удаагийн илтгэлээрээ ахмад настны эрхийн асуудлыг авч үзсэн байгаа. Яагаад энэ асуудлыг анхаарлаа хандуулах болсон бэ гэхээр ер нь дэлхийн хүн амын бүхэлдээ насжих хөдөлгөөн эрчимтэй өрнөж байна. Монгол Улсад ч гэсэн хүн амд эзлэх ахмад настны тоо бол өсөх ийм хандлагатай байгаад байгаа. Энэ утгаараа дэлхийн улс орнууд энэ ахмад настны өмнө тулгарч буй тулгамдсан асуудлыг шийдвэрлэх энэ асуудалд улс орнууд онцгой анхаарал хандуулж байна.

Ийм учраас Хүний эрхийн үндэсний комиссоос энэ ахмад настны буюу энэ Улаанбаатар хотын 600 гаруй гэр хорооллын ахмад настныг хамруулсан яг энэ хүний эрхийн нөхцөл байдал нь ямар байна вэ гэдэг ийм судалгааг хийсэн байгаа. Энэ судалгаан дээр үндэслээд энэхүү илтгэлийг бол та бүхэнд танилцуулж байна.

Энэ судалгааны ерөнхий үр дүнгээс харахад ахмад настны эрхийн хэрэгжилт бол хангалтгүй байна гэж үзсэн байгаа. Хүн бүр тэгш эрхтэй. Гэвч насан өндөр боллоо гээд нийгмээс тусгаарлагдах, тэгш эрх, тэгш боломжоо эдэлж чадахгүй байх, аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөж байгаа ийм асуудлууд бол цөөнгүй байна.

Тэгээд ахмадад чиглэсэн төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ маань бас төдийлөн хангалтгүй байна.

Ялангуяа улс орнууд бол ахмадын чиглэлээр урт хугацааны асаргаа буюу нийгмийн халамж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хамтатгасан ийм эрүүл мэндийн болон урт хугацааны энэ цогц үйлчилгээг үзүүлээд ингээд эхэлчихсэн. Тэгтэл манай Монгол Улсад энэ үйлчилгээ төдийлөн хөгжөөгүй, төрөл хүртээмж нь маш хангалтгүй байна. Ийм учраас ахмад настны эрхийн асуудлыг ялангуяа энэ ядууралд өртөхгүйгээр энэ амьдрах энэ нөхцөлийг бий болгох ийм хэрэгцээ, шаардлага үүссэн байна гэж харсан. Ингээд ахмад насны эрхийн асуудлаар онцгой анхаарал хандуулах асуудлуудыг та бүхэнд танилцуулъя.

Ахмад настны энэ өвчлөлийн асуудал онцгой анхаарал хандуулах ийм түвшинд хүрсэн байна. Зүрх судасны өвчлөл гэхэд бол өмнөх оноос 1.9 дахин, хоол боловсруулах замын өвчин гэхэд 2 дахин гээд. Тэгэхээр энэ КОВИД-ын нөлөө эсвэл насны доройтол гэж орохуйц энэ үүссэн нөхцөл байдалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй юм байна гэж харсан. Монгол Улс 2011 онд энэ ахмад настны энэ эрүүл мэндтэй холбоотой үндэсний судалгааг хийж байсан юм байна лээ. Энэ судалгаагаар харахад 80 орчим хувь нь архаг хууч өвчтэй гээд.

Тэгэхээр бид нар бол энэ судалгаагаа ахиж хийгээд яг энэ ахмадуудын асуудал өвчлөлийн энэ асуудал дээр энэ суурь судалгаан дээрээ үндэслээд цаашидаа судалгааны үр дүнд тулгуурласан оновчтой энэ арга хэмжээгээ авах зайлиггүй шаардлагатай байна гэж харж байна.

Нөгөөтээгүүр энэ эрүүл мэндтэй холбоотой нэг асуудал нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал байгаа. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал бол зөвхөн ахмадууд гэхгүй ер нь Монгол хүмүүсийн бас тулгамдаж байгаа нэг асуудал байгаа. Бидний судалгаагаар судалгаанд оролцогч ахмадуудын 64 хувь нь бол ганцаарддаг хэн нэгэнтэй

сэтгэлээ хуваалцах хэрэгцээ байна гэж харсан. Үүнээс улбаатайгаар мэдээж энэ олон жил явж байгаа, ганцаардаж явснаар магадгүй сэтгэл гутралд орох иймэрхүү асуудал байна гэж харж байгаа. Энэ сэтгэцийн өвчлөл 1.5 дахин өмнөх оноос өссөн байх жишээтэй ийм байна. Тэгэхээр энэ дээр маш олон хүчин зүйлүүд бас нөлөөлж байгаа. Ахмад настны дундаж наслалтын нөөс болоод хань ижлээ эрт алддаг, үр хүүхэд нь үл хайхардаг гээд маш олон нийгмээс бас ахмадуудыг үеэ өнгөрөөсөн залуу хүмүүст зайгаа тавьж байдаг гэсэн энэ нийгмийн бас үзэл хандлага тай холбоотойгоор ахмадууд өөрөө өөрсдийгөө бас нийгмээс тусгаарлах би хэрэггүй хүн болсон байна гээд ингэж үзэх ийм саналгууд бас нөлөөлж байна гэж харж байна.

Хоёрдугаарт энэ юу ээлтэй орчин нөхцөл ерөөсөө бүрдээгүй байгаагаас ахмад настнууд хөгжлийн бэрхшээлтэй болох явдал бол нэлээдгүй байна. Бид нарын энэ судалгаагаар харахад бол осол, гэмтэлд өртөж тусламж үйлчилгээ авч байгаа ахмадуудын 62.7 хувь нь бэртэж гэмтэж, унаж гэмтлийг авсан байна.

Тэгэхээр энэ гадаад аюулгүй охинуудад ээлтэй ийм орчин нөхцөл бүрдээгүй байна. Тийм учраас энэ насжилтын үеийн өвчний эдгээр эрсдэлүүдийг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлүүдийг бол үр нөлөөг нь бууруулах арга хэмжээг зайлиггүй авах шаардлагатай байна гэж харсан.

Хоёрдугаарт энэ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртээмжгүй байна гээд. Ахмад настны тухай хуулиар аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум өрхийн нэгдсэн эмнэлэгт кабинетад, сум өрхийн эмнэлэгт ахмадын эмч байна гээд заачихсан. Тэгтэл эдгээрийн хүрэлцээ маш хангалтгүй байна 40-50 хувьтай л байна. Тэгэхээр энэ дээр мэдээж энэ хүртээмжгүй байгаа нь бас энэ нөлөөлж байна гэж харж байна.

Мөн энэ ахмадын чиглэлээр гол үйл ажиллагаа явуулдаг тусламж, үйлчилгээ үзүүлдэг Геронтологийн үндэсний төв гэж байгаа. Энэ Геронтологийн үндэсний төвийн материаллаг ба цөмийн нөөц санхүүжилтийн асуудлаас болоод зарим үйлчилгээ нь жишээлбэл, гэрээр үзүүлэх үйлчилгээ нь зогсонги байдалд орчихсон байна гэх жишээтэй. Тэгэхээр ахмадуудын дунд ингээд судалгаанаасаа харахад энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хамгийн их хүндрэл, бэрхшээл учруулж байгаа асуудал юу вэ гэхээр ерөөсөө оочир дараалал ирэхдээ хүссэн үедээ орны хүрэлцээ багатай гэсэн асуудал. Зан харилцааны доголдол, олон бичиг цаас шаарддаг, эмийн үнэ маш өндөр байна гэсэн энэ асуудал бол ахмадуудыг маш их бухимдуулж байна.

Тэгэхээр энэ Геронтологийн үндэсний төвийн 60 ортой эмнэлгийг 2011 онд шавыг нь тавьсан. Тэгтэл одоо бүтцэд өөрчлөлт орсон гэдгээр одоо хүртэл ингээд барилгын ажил нь гацсан байдалтай байгаа. Тэгэхээр энэ эмнэлгийн цогцолборын асуудлыг яаралтай шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна гэж харсан.

Гуравдугаарт энэ урт хугацааны тусламж, үйлчилгээ өнөөдөр үгүйлэгдэж байна. Дэлхий нийтээр энэ насжилт өндөрсөж буй үед энэ зөвхөн эмнэлгийн тусламж, үйлчилгээгээр төсөөлдөг байсан энэ цаг үе өнгөрч, алдагдсан чадварын нөхөн сэргээх бие даан амьдрах чадварыг нь дээшлүүлэх ийм арга хэмжээ авч байна.

Монгол Улс энэ урт хугацааны тусламж үйлчилгээг үр хүүхдүүд нь нэг асаргааны мөнгө аваад эцэг, эхээ асардаг. Мөн эсвэл нэг асрамжийн газар гэсэн ийм л байдалтай байна. Тэгэхээр цаашид бид нар ахмадын тоо ингээд өсөх хандлагатай байгаа учраас асаргаа шаардлагатай байгаа хүмүүсийн тоо нэмэгдэнэ.

Тийм учраас бид нар энэ асаргааны даатгалын энэ эрх зүйн орчныг яаралтай бий болгож энэ асуудалд анхаарлаа хандуулах цаг болсон байна гэж харж байна.

Хоёрдугаарт ахмадуудын хамгийн бухимдуулж байгаа нэг асуудал бол энэ тэтгэврийн хүрэлцээ наад захын амьдралынхаа хэрэгцээг хангаж чадахгүй байна гэхэд 52.4 хувь нь бол дурдсан байгаа.

Тэгэхээр нийт нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа хүмүүсийн 73.49 хувь нь хамгийн доод тэтгэврийн хэмжээ буюу 500 мянган төгрөгийн тэтгэвэртэй байгаа нь бол амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй бусад эрхүүд хэрэгжих ийм нөхцөл энэ бүрдүүлэхгүй байна гэж харж байна.

Ингээд их тэтгэврийн зөрүүний асуудал бол ахмадыг маш их бухимдуулж байна. Үе үеийн Засгийн газраас энэ тэтгэврийг нэмэгдэг ч гэсэн инфляцтай уялдуулдаггүй, итгэлцүүрийг ашигладаггүйгээс энэ тэтгэврийн зөрүүний асуудал маш их болсон байгаа асуудал байна. Ахмадуудын бас энэ нэг асуудал нь орон сууцын асуудал байгаа. Энэ зорилтот бүлэгт чиглэсэн орон сууцыг Нийслэлийн орон сууцын корпорацаас хэрэгжүүлж байсан боловч энэ нь КОВИД-той холбоотойгоор тасалдсан байна.

Тэгэхээр энэ орон сууцын асуудлыг ойрын жилүүдэд төрөөс бас бодлогоор дэмжиж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Хөдөлмөрлөх эрхийн хүрээнд ер нь энэ судалгаанд оролцогч манай ахмадуудын 51.3 хувь нь бол хөдөлмөрлөх хүсэлтэй байгаа ч гэсэн ахмадуудад тохирсон ажлын байр хомс байгаа.

Тийм учраас бид нар энэ ахмадуудыг ажлын байраар хангаж байгаа энэ аж ахуйн нэгж байгууллагуудаа бас татвар шимтгэлээр

нь дэмжиж ахмадын энэ хөдөлмөр эрхлэлтийг бас нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж бас харж байгаа.

Ялгаварлан гадуурхалтад өртөх асуудал нэлээдгүй бас байна. Судалгаагаар 5 ахмад тутмын 1 нь ялгаварлан гадуурхалтад өртөж байна гэж гарсан байгаа. Ялангуяа хөдөлмөрийн харилцаан дээр насны дээд хязгаарыг нь заагаад ажилд авдаггүй ч гэдэг юм уу. Иймэрхүү байдлаар бас ялгаварлан гадуурхалтад өртөж байна гээд. Энэ дээр бас нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь энэ ахмадуудыг үеэ өнгөрөөсөн, халамж хүсэгчид гэсэн бас энэ нийгмийн хандлагууд бас нөлөөлж байна гэж харж байна.

Энэ хүчирхийллийн асуудал байгаа. Ялангуяа энэ хүчирхийлэлд өртөж байгаа ахмадууд бол цагдаагийн байгууллага дээр бол бүүр амь нас нь аюулд учирсан эсвэл аливаа гэмтэл авсан ч гэдэг юм уу иймэрхүү нөхцөлд хандаж байна. Бусад сэтгэл санааны дарамт, эдийн засгийн хүчирхийлэл, үл хайхрах хүчирхийлэлд бас төдийлөн хандахгүй байна. Цагдаагийн байгууллагад ирж байгаа энэ ахмад настан өртсөн гэх зөрчлийн хэрэг бол өмнөх жилээсээ 34.8-аар нэмэгдсэн байна. Энэ бол зөвхөн цагдаа дээр ирж байгаа тоо. Үүний цаана далд хүчирхийлэлд өртсөн зөндөө хүмүүс хаана, хаашаа хандахаа мэдэхгүй иймэрхүү нөхцөл байдалтай байна.

Хүчирхийлэлд өртөж байгаа ахмадуудыг тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиараа байгаа. Гэвч эрэгтэй ахмад настан амь нас нь аюулд учирсан тохиолдолд хамгаалах байранд өнөөдөр үйлчлэх, хамгаалах байр төрөлжөөгүй учраас үйлчлүүлэх боломж байхгүй байна.

Нөгөө талаар үр хүүхэдтэй гэдэг утгаар нь энэ асрамж, халамжийн байгууллагууд авахгүй, үр хүүхэд нь ганц хүүхэд нь бид нарын судалгаагаар гэхээр

ганц хүүхэд нь архины хамааралтай болчихсон аавыгаа байнга зоддог тэгээд хамгаалах байранд хандахаар хамгаалах байраа авахгүй, асрамжийн газарт нь хандахаар асрамжийн газар нь авахгүй байх жишээтэй иймэрхүү кэйс бид нар бас тохиолдсон. Энэ судалгаа хийхэд.

Хөгжих эрхийн хүрээнд ахмадууд энэ нийгмийн амьдралд оролцох энэ оролцоо бол дундад түвшинд байна. Энэ дээр хувь хүний болон орчны нийгмийн гээд олон хүчин зүйл нөлөөлж байна. Тэгэхээр бид нар цаашидаа энэ ахмадуудын хүний эрхийн асуудлыг сайжруулахын тулд энэ халамж хүртэгчид нийгмийн хөгжилд саад учруулагч гэсэн энэ хэвимэл ойлголтыг халж, нийгмийн амьдралд идэвхтэй хувь нэмрээ оруулагч эрх эдлэгч гэсэн энэ үзэл хандлага руу шилжих, энэ ахмад насны өмнө тулгарч байгаа энэ хүний эрхийн асуудлыг энэ саад бэрхшээлүүдийг арилгах тэгээд залуу үеийн, ахмад үеийн энэ эв нэгдэл энэ үйл ажиллагааг дэмжих ийм шаардлагатай байна. Шаардлага бидний өмнө тулгарсан байна гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Мөнхзул гишүүнд баярлалаа. Ахмад настны эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Миний бие бас асуулт асууна. Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

Ц.Сандаг-Очир: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Өчигдөр, өнөөдөр илтгэл тавьж байгаа Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдэд бас бид бүхэн бас боломжийн хүмүүсийг бас энэ комисст сонгочихсон юм болов уу гэж бас харагдаж байна. Нэгт тайлан илтгэлээ тавьж байгаа байдал эд нараас харахад бас талархалтай байна. Энэ илтгэлүүдийг бас нэлээн цаг хугацаа гаргаж, нэлээд бэлдсэн байна гэдэгт бас талархууштай байна. Тэгээд энэ

сонсголыг анх удаа хийж байгаа бас Байнгын хороон дарга Энхбаяр даргад бас талархал илэрхийлье.

Ер нь Хүний эрхийн үндэсний комисс ингэж тайлан, илтгэлүүдийг олон нийтэд ил болгож ингэж танилцуулж байгаагүй. Анх удаа олон нийтийн оролцоо, олон нийтийн анхааралд хандуулж олон нийтийг мэдэх мэдээллээр хангаж байгаад бас талархалтай байна. Ахмад настны эрхийн талаарх илтгэлийг сонслоо. Хэд хэдэн бас дүгнэлтүүд байна. Ерөнхийдөө бид нарын бүгд л мэдэж байгаа. Мэдээж ахмад настны үйлчилгээ сайнгүй байна, хүртээмжгүй байна, тэтгэврийн зөрүү ялгаатай байна. Мөн эрхийн зөрчлийн асуудал гээд олон асуудлууд амьдрал дээр байгаа нь үнэн. Тодорхой бас тооны ахмадуудын дунд хийсэн судалгаа байгаа юм. Тэгээд энэ бодит дүгнэлтийг харин манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бодлого боловсруулж байгаа яам ер нь юу гэж авч үзэж байгаа вэ? Хүний эрхийн үндэсний комиссоос гаргаж ирсэн энэ хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудал дээр тэгээд та бүхэнд ер нь энэ Хүний эрхийн үндэсний комиссын бид бүхэнд, гишүүдэд тараасан энэ ном байна уу? Энэ оролцогч нарт ер нь энэ мэдээлэл байгаа юу? Урьдчилж та бүхэн энэтэй танилцсан уу. Танилцсан болоод өнөөдөр бас энэ хэлэлцүүлэгт сууж, холбогдох асуултад хариулах гэж ирж байгаа байлгүй дээ гэж.

Тийм учраас мэдээлэлтэй байх ёстой. Ер нь энэ тэтгэврийн зөрүүг арилгах тал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан минь та нар маань юу хийж байна? Энэ өргөн баригдсан байгаа энэ хуулийн төсөлд бас явж байгаа, одоо явж байгаа энэ хуулийн төслөөр энэ тэтгэврийн олон жил яригдсан зөрүүтэй байдал арилах уу, төсөв мөнгөний хүрэлцээ боломж байгаа юу гэдгийг. Ер нь энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань сүүлийн үед сайд нар нь тогтдоггүй олон сайд нар солигдсоноос болж энэ ер нь бодлого ярьдаг, шийдэл гаргадаг энэ

мэргэжилтнүүд ер нь хэр байна вэ? Дандаа тэгээд дарга нарынхаа амыг хардаг, дарга нарынхаа шийдлийг хүлээж байдаг, үүрэг чиглэлийг хараад сууж байдаг улсууд болж байгаа юм чинь. Та нар бол яг яамны мэргэжилтнүүд яг бодлого ярьдаг, шийдэл гаргадаг, тэгээд эцсийн шийдвэрийг нь Улсын Их Хурал, Засгийн газар дээр гаргадаг ийм л ажлын уялдаа чиг үүрэг байх ёстой шүү дээ.

Тэгээд өнөөдөр яг энэ яаманд энэ олон жилийн 20 гаруй жилийн хугацаанд, 30 гаруй жилийн хугацаанд яригдсан энэ тэтгэврийн зөрүүг арилгах асуудал дээр ямар шийдвэр гаргаж, хэн гэдэг мэргэжилтэн ямар бодлого гаргаж ирсэн юм бэ ер нь? Ямар газар нь хариуцдаг юм бэ? Энэ ерөөсөө харагдахгүй тэгээд л улс төрчид, очсон сайд нар өөр өөрсдийн өнгө аясаар ингээд л тааруулаад л нийцүүлээд л явж ирсэн. Гэтэл та бүхэн бол улс төрөөс үл хамаарах төрийн захиргааны албан тушаалтнууд яг бодлого гаргадаг ийм улсууд байх ёстой. Энэ дээр нэгд хариулт өгөөч.

Хоёрт энд бас их чухал чухал дүгнэлтүүд гаргасан байна л даа. Бас яамныхан хариулж өгөөрэй. Ахмад настны тэтгэвэр өвлөгдөхгүй байгаа хэр нь банкнаас авсан зээл нь өвлөгддөг энэ анхаарал хандуулах зайлиггүй асуудал байна л гэж байгаа юм. Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байна вэ? Зээл авсан ахмад бурхны оронд очлоо гэхэд авсан зээл нь үр.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн тодруулж, гүйцээж асууя.

Ц.Сандаг-Очир: Тэгэхээр энэ ахмадуудын маань авсан зээл банкандаа үр хүүхдүүдэд нь, үлдсэн үр хүүхдүүд нь өвлөгдөөд явж байхад нөгөө тэтгэвэр нь бол өвлөгдөхгүй байгаа. Энийг та бүхэн яамныхан маань юу гэж үзэж байна вэ? Орон нутагт ингээд ажиллахаар ахмадуудын хамгийн ингээд гардаг асуудал энэ ахмадын орон сууцын асуудал байна. Гэр оронгүй ахмадууд их байх юм. Тэгээд энэ Нийслэлээс явуулдаг ахмадын

орон сууцын асуудал. Энэ ер нь хэрхэн, яаж олгогддог юм? Ахмад ер нь ямар процедураар хэнд өргөдлөө гаргаад, хэнд хянагдаад, ямар оочир дугаараар авах ёстой юм? Ямар шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой юм? Өнгөрсөн хугацаанд хэдэн ахмад хамрагдаад байна вэ? Одоо оочир дугаар нь хэн дээр байна вэ? Тэр оочир дугаараа хэдэд байна гэдгээ яаж мэдэх вэ? Энэ ер нь шилэн, ил тод болох бололцоотой юу? Эсвэл дарга нарын өнгө үзэмжээр сонгуульд зориулагдсан ийм шийдвэр болж хувирсан уу гэдгийг.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүний асуултад Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэд сайд хариулъя. 8 Номерын микрофон.

С.Зулхар: Байнгын хорооны дарга гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье. Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очирын асуултад хариулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Ахмадын нийгмийн хамгаалал, ахмадын хөгжил, ахмадын жишээ нь идэвхтэй насжилтын чиглэлээрх бодлогыг бид өөрсдийн чиг үүргийн хүрээнд хариуцдаг. Нөгөөтээгүүр салбар дундын шинжтэй бас ажлууд байдаг гэдгийг нь хэлье.

Яамны тухай таны асуусан эхний асуулт болох тэтгэвэртэй холбоотой асуудал дээр ямар бодлого барьж байна вэ гэж. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд бол Нийгмийн даатгалын хуулийг шинэчлэх өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, энэ шинэчлэлийн ажил явагдсан гэж ойлгож болно. Судалгаа хийгдсэн, хуулиуд бас төслүүд бэлэн болж байсан. Одоо хуулийн төсөл эцсийн байдлаар бэлэн болоод Улсын Их Хурлаар хэлэлцэгдэхэд бэлэн болсон байгаа. Энэ цэвэр жишээ нь төрийн захиргааны энэ чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын болон нөгөөтээгүүр энэ чиглэлээр мэргэшсэн судлаачдын бусад иргэдийн санал дээр

тулгуурласан ийм бодлогын баримт бичиг бэлэн болсон гэдгийг л энд хэлээр илэрхийлэх нь зүйтэй.

Таны тухайлан асуусан тэтгэврийн зөрүүтэй холбоотой энэ асуудлыг бол нийгмийн даатгалын багц хуулиар бид 2 янзаар шийдвэрлэх тухайлсан зохицуулалтыг оруулж ирж байгаа. Энэ нэг талаар тогтолцооны шинэчлэл, хоёрдугаарт өөрөө зохицуулалтын шинжтэй юм. Илтгэлцүүрүүдийг бид хамгийн сүүлд 2014 онд баталсан. Өөрөөр хэлбэл тухайн хүний тухайн үед авч байсан цалин, хөлсийг тодорхой хугацааны дараа бол үнэ цэн нь ямар байгаа талаар байгааг тооцож энэтэй уялдсан байдлаар жишээ нь тэтгэврийг нь тогтоодог энэ чиглэл рүү бол манай тогтолцооны шинэчлэл дотор бол маш чухал алхам хийгдэх юм байгаа юм. Ингэх юм бол саяын хэлсэн цалингийнх нь үндэс нь алдагдахгүйгээр тэтгэвэр нь тогтоогддог нэг зохицуулалт хийгдэнэ.

Хоёр дахь зүйл бол тэтгэврийг цаашид нэмэхдээ ямар нэгэн улс төрийн шийдвэрээр биш цэвэр жишээ нь мэргэжлийн түвшинд шийдвэр гаргадаг буюу тухайн жилийн инфляц болон амьжиргааны түвшинтэй уялдсан байдлаар нийгмийн халдлагын тухайлсан бие даасан жишээ нь субъект нь өөрөө шийдвэр гаргаж явах ийм бодлогын зохицуулалтыг энэ хуульд оруулж ирсэн.

Бидний хувьд бол тэтгэврийн зориг арилахтай холбоотойгоор 116 мянган хүний асуудал байгаа юм. Энэтэй холбоотой бол төсвийн хүрээний мэдэгдэл бол эхний байдлаар саналаа өгсөн байж байгаа гэдгийг энд хэлье.

Хоёр дахь асуудал байна. Энэ бол хоёр дахь асуудал бол тэтгэвэр өвлөгдөх үү гэдэг асуудал байна. Энэ тэтгэврийн нийгмийн даатгалын багц хуультай уялдуулсан байдлаар бидний оруулж байгаа гол үндсэн санд бол тэтгэвэр өвлүүлэх. Энэ тэтгэвэр өвлүүлэхдээ гэр

бүлийн 2 гишүүний хэн нэгнийх нь жишээ нь тэтгэвэр бол тухайн гэр бүлийн 1 гишүүнээс орсон үед бол 20-ын 20-д нөгөө жишээ нь, гишүүнийх нь тэтгэврийг нэмэгдүүлэн олгодог ийм шинэчлэлийг бид гол барьж байгаа. Яагаад гэвэл иргэдийн бас тухайн тэтгэвэр авагчийн амьжиргаанд бол хоёулынх нь тэтгэвэр нөлөөлдөг учраас энийг бол бид зөвтэй юм гэдэг үүднээс энэ санал болгосон. Үүнийг бас хэлэлцүүлгийн явцад бол талууд бол дэмжсэн байгаа.

Гурав дахь асуудал бол банк санхүүгийн байгууллагаас ахмадууд маань зээл авдаг, зээл авсантай холбоотойгоор бас амьжиргаанд нь бол энэ нөлөөлдөг. Тэгэхээр энийг бол бид уг нь бол зохицуулалт байсан, журамласан байсан. Өөрөөр хэлбэл тухайн тэтгэвэр авагчид 6 сараас илүү хугацаатайгаар жишээ нь зээл олгохгүй байхаар ингээд зохицуулагдсан байсан. Гэсэн хэдий ч энэ журам маань хүчингүй болсонтой холбоотойгоор бол бас энэ зээлийг 6 сараас илүү хугацаагаар олгож байгаа ийм нөхцөл байдал үүссэн.

3 сарын 16-нд бол бид Монголбанк руу бол сайдын гарын үсэгтэй бичиг явуулсан. Энэ бичгээр бол энэ журмын хүрэн дэх бидний урьд нь оруулж байсан зохицуулалтыг та бүхэн анхаараач нэгдүгээрт, хоёрдугаарт бол тухайн ахмад настанд бол тэтгэврийн зээл олгохдоо амьжиргааных нь түвшинийг нь хангах хэмжээний тэтгэврийг нь үлдээх дээр бас зээлийг нь та бүхэнд тооцож олгож байгаач гэсэн ийм албан бичиг очсон байгаа. Энэ чиглэлээр бид идэвхтэй ажиллаж байгаа. Яагаад гэвэл ахмадууд дээр тэтгэврээс.../минут дуусав./

Б.Энхбаяр: Орон сууцтай холбоотой асуудлаар асуусан. Хэн хариулах уу? Ахмадын орон сууцын хүртээмжтэй холбоотой асуудлыг гараа өргөөд хариулах хүн байна уу? Мөнхзул гишүүн хариулах уу? 5 номерын микрофон.

Х.Мөнхзул: Бид нар энэ орон сууцтай холбоотой асуудал ямар байна вэ гэдгийг Нийслэлд бид нар хандаж бас энэ мэдээллийг авсан байгаа. Нийслэлийн орон сууцын корпорац 2019 оноос энэ нийслэлийн иргэдэд зориулсан зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах, хямд өртөг бүхий энэ Буянт-Ухаа 2 хорооллын төслийг хэрэгжүүлээд ингээд энэтэй холбоотой энэтэй адилтгах бас мэдээ бас хэд хэдэн хөтөлбөрүүдийг бас хэд хэдэн бүсэд хэрэгжүүлэхээр ингээд ажиллаж байсан юм байна лээ. Тэгээд энэ КОВИД-ын улмаас энэ нь эдийн засгийн хүндрэлтэй байдалд ороод хил хаагдсан байдал гээд энэ олон хүчин зүйлээс хамаараад энэ төсөлд нь энэ шалгарсан аж ахуйн нэгж байгууллагууд бол барилгынхаа ажлыг цаашаа хийх боломжгүй болоод ингээд асуудал нь ийм зогсонги байдалтай байгаа.

Тэгэхээр Хүний эрхийн үндэсний комисст ирж байгаа өргөдөл гомдлын бас дийлэнх нь энэ орон сууцын асуудал байдаг. Тэгээд энэ ахмадын холбоо он гарч дамжуулаад бид нар тэнэ бас энэ орон сууцын асуудлыг бас энэ онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна гэдэг асуудлыг бас гаргасан байгаа.

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Би Багануур дүүргийн иргэн Нямсүрэн, Доржсүрэн гэсэн 2 иргэний асуултыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яамнаас асууя. Энэ хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор. Үйлдвэрийн газар ажиллаж байгаад мэргэжлээс шалтгаалах өвчнөөр ингээд групп тогтоолгодог, хөдөлмөрийн чадвараа 70 хувь, 80 хувь, 60 хувь алддаг. Энэ улсууд ингээд халамжийн сангаас ингээд тэтгэврээ аваад мэргэжлээс шалтгаалах группээ аваад тогтоолгоод явдаг. Тэтгэврийн насанд хүрэхээр тэтгэвэр тогтоолгох асуудал үүсдэг. Тэтгэвэр одоо авч байгаа группээс нь

бага тогтоолгож байгаа юм. Бага тогтоогдож байгаа.

Тэгэхээр нөгөө энэ хүний эрхийн чиглэлээрээ бас эрх зүй нь дордоод, группээс нь тэтгэвэр нь бага тогтоогдож байна гэдэг гомдол байна. Энийг цаашидаа тэр эрх зүйг нь дордуулахгүй байхаар группэд гарч байгаа улсуудыг тэтгэвэрт гарахад нь одоо группээс н багагүй байхаар ийм.../минут дуусав./

Б.Энхбаяр: Хэн хариулах вэ? Энэ чинь Батцогт дарга хариулах юм уу? Нэрээ даатгалын асуудал байна шүү дээ. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга Батцогт дарга 9 номерын микрофонд хариулъя.

Б.Батсүх: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Группээс тэтгэвэр авч байгаа иргэн өндөр насны тэтгэвэрт ишилжих тохиолдолд групп нь арай өндөр, тэтгэвэр тогтоолгож байгаа тэр тэтгэвэр нь арай бага байх тохиолдол гардаг. Яагаад гэхээр энэ тухайн үеүдэд Засгийн газрын нэмэгдлүүд энэ тэр ороод явахаар арай өндөр тэтгэвэр нь аваад явж байдаг. Тэтгэврээ тогтоолгохоор тухайн Засгийн газрын нэмэгдлүүд нь орохгүйгээр шинээр тухайн үеийн цалингаас нь холбогдох хувиар бодоод ингээд тогтоохоор бага болчихдог ийм тохиолдол байгаа.

Одоогийн хууль дээр ямар зохицуулалт байгаа вэ гэхээр нэг сангаас 2 төрлийн тэтгэвэр авах эрх үүссэн тохиолдолд аль өндрөө сонгох эрх нь тухайн иргэнд байгаа.

Б.Энхбаяр: Би 2 асуулт асууя. Нэгдүгээрт бид нар энэ ахмад настны эрхийн асуудлыг ер нь ийм тухайлж ер нь анхаарч ярьж байгаагүй. Ингээд тайлан илтгэлийг сая Сандаг-Очир гишүүн хэлж байна. Тайлан, илтгэл бас нэлээн дэлгэрэнгүй бас гарсан байна. Энэ дотор ахмадуудын ганцаардлын асуудлыг бас тухайлан хөндсөн байна. Судалгаа хийж бас ярилцлагын хэсгээс бас бичсэн байна.

Жишээлбэл тайлангийн 423 дугаар хуудсан дээр Хан-Уул дүүргийн ахмад настантай хийсэн ярилцлагаас, Ач зээгээ хараад ямар ч завгүй байдаг. Зуны улиралд зарим нэг ногоон мод тарьдаг. Олуулаа сайхан тоглоод, халуун савтай цайгаа уугаад эсвэл эрүүл мэндийнхээ талаар зөвлөгөө авдаг, хоорондоо ярилцдаг чөлөөт цагаа өнгөрүүлэх газар байдаггүй. Тэр тусмаа гэр хороололд нийтийг хамарсан үйл ажиллагаа, үйлчилгээ байхгүй.

Баянзүрх дүүргийн ахмад настантай хийсэн ярилцлагаас, Манайх алслагдсан зайтай гэр хороололд байрлалтай болохоор нийгмийн үйл ажиллагаанд оролцох, өөрийгөө хөгжүүлж чаддаггүй. Гэрээсээ ч цухуйж чадахгүй хөштөлөө хэвтэж байна. Өвлийн хүйтэнд гарвал халтираад уначихна гэж айгаад хөдөлж ч чаддаггүй. Зуны цагт л амралт сувилалд явдаг.

Сонгинохайрхан дүүргийн ахмад настантай хийсэн ярилцлагаас, Би гурван хүүхэдтэй, нэг охиныдоо байдаг. Тэд нар маань ажил ихтэй дээр нь өөр өөрсдийн амьдралтай болохоор бараг уулзаж чадахгүй, хааяа нэг утсаар ярьдаг. Үнэндээ их ганцаарддаг. Муу өвгөн маань байсан бол ингэхгүй байх гэж боддог. Хааяа найз нөхөдтэйгөө утсаар ярьж сэтгэлээ хуваалцдаг. Ядаж байхад гэр хороололд гаръя гэхээр гарах ч газар байхгүй өдөржингөө хашаандаа торойгоод ганцаараа сууж байна.

Өрхийн эмчтэй хийсэн ярилцлагаас, Эм бичүүлэх гэж ирсэн ахмад настнууд маш их ярьдаг. Яриаг нь сонсохоор маш дуртай байдаг. Тэгэхээр ярилцдаг, сонсож өгдөг үйлчилгээ дутмаг, ганцаардсан байдал ажиглагддаг. Гэр хороололд хашаандаа гарах ч газаргүй өдрийг өнгөрүүлдэг талаараа их ярьдаг гэсэн ийм зүйлийг хэлсэн байгаа юм.

Тэгэхээр энэ ганцаардлын асуудлыг энэ бид хүн ёсны асуудал л даа.

Энэ нэг яамны гэх шиг энэ хүн болгоны л хамаатай. Аав ээжийгээ, ах эгчийгээ, хөршийгөө, эргэн тойронд ажиллаж байгаа тэр ахмадуудыгаа бас бид их ойлгож, нийтээрээ ярилцаж, ойлгож, тусалж дэмжиж ингэж л байх ёстой юм шиг. Хүүхэд байхад чинь бид нарт бол энэ ахмадуудыгаа хүндлэх, сандал ширээ тавьж өгөх, туслах, хүнд юм өргөөд явж байвал тэрийг нь өргөж авч тусалдаг байх гэж л зааж, сургаж хүмүүжүүлдэг л байсан. Тэгээд хүн гэдгээр нь бас ингэж ойлгодоггүй их ганцаардуулдаг юм байна даа гэсэн ийм зүйл энэ дүгнэлтийг уншаад л төрөөд л байж байна.

Тэгээд энэ бол би яг асуулт гэж хэлэхэд хаашаа юм. Хүн болгон л дор бүрнээ нэг бодоосой. Аав маань яаж байгаа бол, эмээ маань яаж байгаа бол гээд нэг залгачих, нэг биеийг нь асуучих, нэг санаа тавьчих ийм л юм хүн болгонд нэг санаж сэрээсэй гэсэн ийм зүйл энэ тайлан итгэлээс уншаад бас бодогдож байна.

Өнгөрсөн онд энэ хүчирхийлэлд өртсөн ахмадуудын тоо 34 хувиар нэмэгдсэн гэж. Энэ илрүүлэлт нэмэгдээд ийм өндөр өсөлт гараад байна уу? Ахмад настны хүчирхийлэл яагаад бас ийм огцом өсөлттэй ямар шалтгаан хүчин зүйл бас энд их нөлөөлж байна? Энэ дээр би төр талаас биш би энэ бас төрийн бус байгууллагуудаасаа бас асуумаар санагдаад явчихлаа. Та хэд маань энэ дээр ер нь бас энийг юу гэж бодож байгаа бол? Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс чинь Ариунтуяа захирал ирсэн байна.

Тэгэхээр Ариунтуяа захирлаас би бас нэг асуугаад санал бодлыг нь асуумаар байна. Хэдэн номерын микрофон дээр, та 12 номерын микрофон дээр цаашаа шилжээд суучих. Энэ дээр бас Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв бол маш олон жилийн туршилагатай хүмүүс ирдэг, тэр ганцаардалтай холбоотой асуудал дээр ч гэсэн та бүхэн маань ер нь юу гэж энийг

оношилж дүгнэж, юу хийх хэрэгтэй байна? Төр ер нь юу хийх хэрэгтэй байна, бодлогоо юунд анхааруулах хэрэгтэй байна, та бүхэн маань энэ дээр ямар бодолтой байна гэсэн ийм асуулт байна. 12 номерын микрофоныг эхнээс нь өгчхөөрэй.

Н.Ариунтариа: Баярлалаа. Юуны өмнө энэ ахмадын асуудлыг, хүний эрхийн асуудлыг хөндөж Хүний эрхийн үндэсний комиссын тайланг толилуулж байгаа Хүний эрхийн үндэсний комиссын хамт олонд бас талархал илэрхийлье. Энэ асуудал бол бид нар нэг талаас нь харж болохгүй асуудал юм байгаа юм. Бид нар аягүй олон жил яг энэ гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр ажиллалаа. Бид нарт ерөөсөө яг тийм нэгдсэн яг хүний эрхийг хамгаалах нэгдсэн тийм бодлого байдаггүй юм байна. Хүүхдийн эрхээ яаж хамгаалах юм, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого байхгүй, стратеги байхгүй энэнээсээ болоод бид нар яаж байна вэ гэхээр зэрэг дандаа хэсэг бус, тал талд ингэж ажиллаад үр дүнгүй тэгээд төсөв мөнгө нь болохоор зэрэг хүрэлцэхгүй ийм байдалд хүрч байна.

Манай Хүчирхийллийн эсрэг үндэсний төвд жилдээ 2000 гаруй хүн үйлчилгээнд хамрагддаг. 20-22 онд нийтдээ 8092 хүн хандсанаас 690 нь ахмад настан байж байгаа юм. 55-аас дээш насны хүмүүс байж байгаа. Эд нарын хувьд ихэнх нь нөгөө сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, зарим нь ингээд бие махбодын хүчирхийлэлд өртөж ирж байна. Энэ сүүлийн үед ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай байгаад байна л даа.

Тэгэхээр бид нар яах вэ гэхээр хүн байх гэдэг юмаа бид нар хаячихсан байгаа байхгүй юу. Хүүхэд байхаас нь авхуулаад л хүн гэдэг чинь ямар байх ёстой юм. Ахмад настанг хүндлэх, найз нөхдөө хүндлэх, өөрийгөө хүндлэх, эргэн тойрныхонтойгоо эв зүйгээр харьцах гээд энэ ур чадварууд өнөөдөр байхгүй

болчихсон. Ерөөсөө л эдийн засаг бид нар ярьдаг, хүнээ ерөөсөө орхичихсон байгаа байхгүй юу. Энэ нь эргээд хор уршиг нь яаж гарч байна вэ гэхээр өнөөдөр энэ ахмад настны энэ эсрэг хүчирхийлэлтэй бас холбогдож гарч ирж байгаа энэ бол үр дагавар байхгүй юу.

Тэгэхээр бид нар энийг бид нар үндсээр нь өөрчлөхийн тулд бид нар шалтгаан нөхцөлөө маш сайн тодорхойлох хэрэгтэй байна. Одоо Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөл гээд байж байна манай улсад. Тэгээд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлууд гээд байдаг, хүүхэд хамгаалалттай холбоотой гээд ингээд дандаа нөгөө салангид яваад байгаа байхгүй юу. Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүл гээд эд нарыг бид нар нэгдсэн бодлогоор л хангах ёстой. Тэгж байж энэ бодлого хооронд нь уялдуулж байж хаана нь ямар бодлогуудаа хэрэгжүүлэх юм, боловсролын салбартаа бид нар яг юуг анхаарах юм хүнээ хөгжүүлэх, төлөвшүүлэхийн тулд, хэвлэл мэдээллийн салбар нь энийгээ дэмжиж яаж оролцож ирэх юм.

Дээрээс нь яг ингээд хүчирхийлэлд өртлөө гэхэд тэр дуудлага, мэдээллүүдийг яаж хүлээж авах юм. Өнөөдөр сонсголын бэрхшээлтэй хүнд дуудлага мэдээлэл өгөх ямар ч боломж байхгүй. Цагдаагийн шуурхай удирдлага мэдээллийн төвд. Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чинь энэ тоон дотор орж ирэхгүй байгаа шүү. Энэ ахмадуудын тоон дотор ч гэсэн орж ирээгүй байж байгаа гэдгийг бас бид нар анхаарах ёстой.

Тэгэхээр зэрэг ядаж л нэг дэд бүтцээсээ авхуулаад, боловсролын системээсээ авхуулаад, хэвлэл мэдээллээсээ авхуулаад бид нар хүний эрхэд суурилсан энэ хандлагуудыг төлөвшүүлэх хэрэгтэй байна. Тэгэхгүй болохоор ерөөсөө л бид нар эдийн засаг гэж яриад байдаг, хүнээ хаячихсан тэгээд ахмадуудын хувьд үнэхээр хэцүү

шүү дээ. Тэгээд эрэгтэй хүн хүчирхийлэлд өртөөд ирэхэд өнөөдөр хамгаалах байр байхгүй, манайх хамгаалах байрандаа авахгүй. Ахмадуудыг бол ялгаварлан гадуурхана ихэнх хамгаалах байрууд авахгүй. Манайх бол авдаг.

Гэхдээ яадаг вэ гэхээр хүүхэд, эмэгтэйчүүдэд байрлуулахад асуудал үүснэ. Тэгэхээр зэрэг нөгөө төрөлжүүлсэн энэ хамгаалах байруудыг төрөлжүүлж байгуулах эрхтэй болно. Тэгээд ингээд гэр бүлийнхээ гишүүдийн хүчирхийлэлд өртсөн ахмадуудыг асрамжийн газар өгье гэхээр авдаггүй, үр хүүхэд нь байж байна тийм ээ тэгэхээр зэрэг манайх авахгүй гэж байгаа юм. Тэгээд орон гэрийн асуудлууд гарч ирнэ. Энэ болгоныг цогцоор нь шийдэхгүй бол хэд хоног хамгаалах байранд байрлуулаад юм уу, 1 удаагийн зөвлөгөөгөөр хэзээ ч энэ асуудал засагдахгүй. Тэгэхээрээ бид нар яах вэ гэхээр ул үндэстэй нь л ажиллах хэрэгтэй байна. Үндэс суурьтай нь л ажиллах хэрэгтэй байна. Энэ бол зөвхөн Хүний эрхийн үндэсний комиссын байгууллагын чиг үүрэг дотор хамааралтай асуудалд бол биш. Энийг хөндлөнгийн энэ хяналтуудад тавиад ингэж асуудлыг гаргаж ирж байгаа нь маш сайн. Илүү бид нар гүнзгийрүүлж энэ асуудлуудыг, асуудлын гүн рүү нь орж ажиллах хэрэгтэй байна.

Тэгэхгүй болохоор үнэхээр хэлбэрдээд байгаа байхгүй юу. Мөнгө байна уу байна ингээд юу яахаар зэрэг, манай байгууллага гэхэд л хүүхэд хамгааллын зардлаас 1 төгрөг ч аваагүй. Манай байгууллага өнөөдөр түр хамгаалах байр санхүүжилтгүй байж байгаа байхгүй юу. Бодит үнэн.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Ахмад настны эрхийн асуудлаар тайлантай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Тийм ээ зүгээр олон бэрхшээл, хүндрэл зовлонгууд бол байгаа. Тэгээд бүгдийг нь нэг амьсгаагаар гэдэг юм уу, олон жил хуримтлагдсан асуудлыг шийдээж чадахгүй л дээ. Ахмадууд бол төр засгаас нэг их олон юм нэхээд гуйгаад, хүсээд байдаггүй. Ганц юм нь энэ тэтгэврийн тогтолцоогоо шинэчлээд өгөөч, энэ цалингийн зөрөөг шинэчлээд өгөөч, ойртуулаад өгөөч, шударга байлгаж өгөөч. 2000 оноос өмнөх цалин авч байсан цалин тэтгэвэр өнөөдөр яаж, хэрхэн яаж үнэлэгдэх юм, тооцогдох юм? Тухайн үед яг ажил ижил ажил хийж байсан улсуудын 2000 оноос өмнөх болон хойших хүмүүсийн цалингийн зөрүүний л асуудлыг яриад байгаа шүү дээ. Энийг эхний ээлжид энэ нийгмийн даатгалын багц хуулиараа яг хэрхэн яаж шийдээж байна? Би бас олигтой хариулт авч чадсангүй. Тэгээд хэдэн төгрөг төсөвлөж байгаа юм? Энэний зөрөөг арилгахад хэдэн төгрөг төсөв нь хэрэгтэй юм? Их Хуралд хэдийг оруулж ирэхээр, Сангийн яаманд хэдийг өгөхөөр чадахгүй гээд ингээд чулуудаад байгаа юм? Тоо судалгаагаа гаргачихгүй юм. Хэчнээн 300 гаруй мянган ахмадуудаас чинь хэдэн хүн нь энэ тэтгэврийн зөрөөнд хамрагдах юм? Ингээд тоо баримттай тодорхой юмнуудыг бас яривал сайн байна.

Тийм учраас би энэ эхний ээлжид ахмадуудын тэтгэврийн асуудал тэгээд энэ орон сууцын асуудал 2 дээр л Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам холбогдох газруудтайгаа ярьж хэлэлцээж энэ тодорхой шийдвэр гаргаж, өөрчлөлт гаргавал ер нь бас нэг их олон юм хүсэхгүй байгаа даа ахмадууд. Энэ 2 дээр ахиц дэвшил гаргаад, өөрчлөөд шинэчлээд өгөөч л гэж хүсэж байгаа. Тийм учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яаман би энэ тал дээр илүү санаачилгатай ажиллаач, Хүний эрхийн үндэсний комисс бол асуудлыг гаргаад иржээ, бодитой байдлыг гаргаад иржээ. Гагцхүү хэн хийх юм гэхээр салбарын яам л хийх ёстой шүү дээ. Бодлогоо барьж хийх ёстой шүү дээ. Төрийн бус

байгууллагуудын уялдаа холбоо, төсөв мөнгөний асуудал, хүрэлцээ хангамжийн асуудал гээд ингээд олон юмнуудтайгаа нийцүүлж уялдуулж хийх л асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бас идэвхтэй, санаачилгатай ажиллаасай л гэж хүсэж байна даа. Өөр хэлэх юм алга.

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүн үг хэлье.

Б.Дэлгэрсайхан: Та бүгдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Тэгээд Хүний эрхийн комиссын гаргасан энэ тайлан, дүгнэлтийн мөрөөр уул нь ажил болгомоор байгаа юм. Бас нэлээн сайн тайлан, судалгаа, ярилцлага, бас нэлээн бодитой юм хийсэн байна. Тийм учраас ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яам энийг ажил болгоод, жишээлбэл аймаг, орон нутагт халамжийн газраараа дамжуулаад ч юм уу, аймаг, сум, багийн дарга нар хүмүүсээ сайн мэддэг юм шүү дээ угаасаа. Орон нутагт энэ их тийм амар шүү дээ. Багийн дарга нар халамж бүгдээрээ тэр хэн хаана байдаг уу, ганцаараа байдаг уу, хүүхдийндээ байдаг уу гээд бүгдийг нь мэддэг учраас саяын энэ Сандаг-Очир гишүүний хэлдгээр жоохон ажил болгоод, энэ судалгааг нь улам нарийн хийгээд тэгээд ингэж гаргамаар байгаа юм. Мэдээж мөнгөний асуудлыг яаманд байгаа төсөв ч хүрэхгүй. Энэ цалин, тэтгэвэр ч гэсэн нэг их яам шийдээд байх нь ч юу л бол. Их Хурлын л шийдэх асуудал.

Тэгэхлээр бид бас энэ дээр ойлголттой болж аваад тэгээд та бүгд энэ цалин, тэтгэврийн зөрүү ялангуяа энэ цалин тэтгэврийг нэмэхдээ нэг алдаа байна. Ингээд доод талын тэтгэвэр, дээд талын хэмжээ 2-ыг жоохон ойртуулъя гэхлээр ингээд процентлоод бүгдийг нь нэмчихлээр зэрэг дээд талынх нь угаасаа хэмжээ нь өндөр учраас улам дээшээ явчхаад байх юм.

Тийм учраас ерөөсөө дахиад дараа энэ тэтгэвэр нэмнэ гэж оруулж ирэхдээ зөвхөн доод талыг нь жоохон нэмэх

талаар оруулж ирвэл яадаг юм бол? Тэрийг нэг бодооч. Тэгэхгүй ингээд дээд талынх нь нэмэхлээр зэрэг ингээд, тэгээд асуухлаар энэ ингээд адилхан процентоороо ингээд нэмэгдэж байгаа юм гээд ингэхлээр зэрэг өнөө зөрүү чинь бүүр талийгаад алга болчихоод байгаа юм. Тэгээд ч тийм мөнгөнийх нь даац хэмжээ бас Засгийн газарт байхгүй нь ойлгомжтой учраас энийг бас бодолцооч.

Тэгэхгүй бол энэ хүүхдийн мөнгө шиг юм болчих вий гэж бодоод байгаа байхгүй юу. Хүүхдийн мөнгийг хэрэндээ уул нь ингээд боломжийн хэсэгт өгөхгүй 9 хувийг нь өгөхгүй байя гэхэд л ямар их гал гарч байна харж байгаа шүү дээ. Тийм учраас хэмжээг нь тодорхой нэг түвшинд бариад нийтээр нь өгчихсөн бол өнөөдөр энэ хэрүүл маргаан гарахгүй байх байсан байхгүй юу. Өнөө бид чинь бол мөнгө нь хэмжээтэй, авах хүмүүс нь ингээд эрх яриад ингээд уурлаад, бухимдаад байхлаар бас буруутгах ямар ч арга байхгүй. Тэгээд бидний савны хэмжээ л ийм юм чинь яах юм?

Тийм учраас энэ дараагийн энэ ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань энэ цалин, тэтгэврийн зөрөөг гаргахдаа зөвхөн доод хэмжээг нь л нэмж оруулж ирэхээр бас бодолцооч та нар. Энийг зөвлөмөөр байна. Тэгээд мэдээж дээд юугаар авч байгаа улсууд нь цөөхөн шүү дээ ер нь. Нэлээн өндөр авч байгаанууд нь бас эзлэх хувь нь цөөхөн шүү дээ. Тэгээд энийг бас бодолцоорой гэдгийг бас давхар хэлье.

Тэгэхлээр зэрэг саяын энэ Хүний эрхийн комиссын хийсэн ажлын мөрөөр энэ хөдөө орон нутаг, аймаг сумын багийн дарга нар тэгээд энэ аймаг орон нутагт байгаа энэ халамжийн газраар дамжуулаад бас энэ судалгааг улам нарийсгаад ингээд явбал бас болохгүй юм байхгүй гэдгийг бас хэлмээр байна.

Ер нь аймаг болгон нэг юутай болмоор юм шиг байна лээ. Өнөө ахмадын сувилал юу гэдэг билээ? Нэг ахмад байгаад байдаг чинь нөгөө Төв

аймгийн юуг чинь юу гэж нэрлэдэг билээ? Асрамжийн газар, асрамжийн газар тийм. Энэ Дорноговь аймагт 1 байдаг юм, шинээр барьж байгаа юм. Тэгээд говийн бүсийн ахмадууд авна гэхлээр ингээд багтаж шингэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг нь өнөө аймаг орон нутгийнхан нь дургүйцээд бид нар ингээд орж чадахгүй байхад хаа байсан өөр аймгаас ирлээ гээд. Авахгүй байх ямар ч арга байхгүй юм билээ бас. Тэгэхлээр энийг аймаг бүрд нь байгуулаад, тэгээд энийг тэр барууны тэр нэг соёл байна шүү дээ тэтгэврийнх нь мөнгийг аваад тэрийг нь санхүүжүүлээд, бололцоотой айл хунар нь, хүүхэд шуухад нь сар бүр мөнгийг нь төлөөд ийм нэг жоохон барууны тийм хэв маяг руу ганцаардлаас нь гаргах тэр хэв маяг руу нь явуулах ямар арга зам байдаг юм? Тэрийг бас бодмоор юм билээ.

Тэрнээс биш ингээд л төр ингээд асрамжийн газар гэж байгуулаад л зүгээр тэжээгээд байдаг тийм сонин газар юм байна лээ шүү дээ. Тэгээд тэнд нь хэн явдаг вэ гэхлээр бас ч яг нарийн очоод үзвэл.../минут дуусав./

Б.Энхбаяр: Ахмад настны эрхийн хэрэгжилттэй холбоотой Хүний эрхийн үндэсний комиссын бас тайланг сонслоо. Ер нь 20, 30 жилийн өмнө чинь манай дундаж наслалт 60, 61, 2-той л байсан. Одоо чинь 10 жилээр бид ахичхаад байгаа байхгүй юу. 71, 2-той. 20, 30 жилийн өмнө энэ 50 настай хүн гэдэг ер нь их ахмад тийм ээ бараг л 50 насны ой найр байдаг байсан шүү дээ. Одоо 50 насны найр хийдэг юм ер нь байхгүй болчихсон шүү дээ. Тэр чинь бүүр бараг залуу хүн чи юу энэ найр хийгээд байгаа юм гэдэг байдал руу орчихсон байхгүй юу.

Тэгэхээр энэ дундаж наслалт бас энэ сүүлийн 20, 30 жилийн хугацаанд манайх чинь бас нэлээн нэмэгдэж байгаатай холбоотой нэг талаасаа. Нөгөө талаасаа бас энэ цэргийн тэтгэвэрт маш их эрт гаргаж байгаа шүү дээ. Цэргийн тэтгэвэрт аягүй эрт гаргаж байгаа. Тэгээд 40 гарантаа

ингээд тэтгэврийн хүн болчихоод байгаа байхгүй юу. Тэр чинь юу идэр залуу хүн шүү дээ 40 гарантай. Тэгээд энэ асуудлыг бас нэлээн тийм бодлогын хүрээнд, энэ нийгмийн даатгалын хууль, халамжийн хууль, энэ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг их анхаарч ажил хөдөлмөр эрхлэх энэ бас чадвартай ахмадуудынхаа хүч нөөц бололцоог ашиглах энэ талаас нь цогц ер нь анхаарах шаардлагатай. Тэгээд нийгмийн сая Дэлгэрсайхан гишүүн хэллээд байна шүү дээ. Тэр асрамжийн газар гэдэг чинь зүгээр хооллоод, ундлаад амьд сэрүүн байлгах газар биш байхгүй юу. Гол нь хооронд нь нөхөрлөөд, танилцаад тэр ганцаардал тэр юмнуудыг тайлуулах тэр. Энэ чинь хүн шүү дээ.

Тийм учраас энэ орчин нөхцөлийг нь ер нь бид нар цоо шинээр авч үзмээр юм байна лээ. Бүүр ийм гоё орчинд, чөлөөт цагаа өнгөрөөдөг, сайхан танилцдаг, тэндээ бүүр үерхдэг ийм бүүр тийм таатай орчинд байх ёстой юм байна лээ шүү дээ ер нь бид ахмадуудыгаа. Тэгээд л бараг хоол унд өгөөд л байж байгаад л амьд сэрүүн байлгаж байгаад л бараг л их юм ухааны юм боддог ийм хандлага, ийм үзэл юмнуудыг ер нь бүгдээрээ энэ толгойноосоо авч хаях ёстой юм байна лээ. Бүүр ингээд толгойноосоо авч, бие биеийгээ хайрладаг ийм л асуудлыг авч үзэх ёстой юм байна. Энэ асуудлыг бас чуулганы нэгдсэн хуралдаан дээр орж танилцуулна гэсэн бодолтой байгаа шүү. Ер нь нийтийн анхааралд оруулна гэсэн ийм бодолтой байгаа шүү.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо дараагийн сэдэв Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн улс төрийн хүрээн дэх “Жендерийн эрх тэгш байдал” сэдвийн талаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Дугарын Сүнжид танилцуулна. 3 номерын микрофон.

Д.Сүнжид: Энд хуран цугласан та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Хүний эрхийн үндэсний комиссоос 2 жил тутамдаа Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар хэсэгчилсэн буюу бүтэн үнэлгээ хийж Улсын Их Хуралд тайлагнах үүрэг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд өнгөрсөн удаа 8 энэ удаагийн үүнээс 2010 оны Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль баталснаас хойш 5 удаагийн илтгэлийг хэлэлцүүлсэн байна.

Энэ удаагийн сэдвээр зөвхөн улс төрийн шийдвэр гаргах түвшинд энэ жендерийн эрх тэгш байдал ямар байгаа талаар дэд сэдвийн хүрээнд авч үзэж байгаа. Шалтгаан нь дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг жендерийн эрх тэгш байдлын энд жендерийн ялгаатай байдлын индекс дурдсанаар эрүүл мэндийн болон боловсролын, эдийн засгийн оролцооны түвшин 50-ас дээш хувьтай явдаг эрүүл мэндийг хангалттай сайн гэж үнэлэгддэг бол хамгийн муу үзүүлэлттэй байдаг нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны үзүүлэлт байдаг. Энэ нь өнгөрсөн онд бас сүүлийн 2 жилийг харьцуулах юм бол ухарсан үзүүлэлттэй. Ингээд 113 дугаар байранд явж байгаа.

Ийм учраас энэ сэдвийг сонгож Социологийн боловсрол төвөөр 517 шийдвэр гаргах түвшний нам, Улсын Их Хуралд суудал авсан намууд Улсын Их Хуралд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй ийм судалгаа хийлгэсэн байгаа. Энэ 5 аймгийг оролцуулсан бүс нутгийн хэрэгжилтийг хангахыг хичээсэн. Энэний үр дүнд тулгуурлаад энэ сэдвийг танилцуулж байна.

Энэ хүрээнд анхаарах асуудал юу байна вэ гэхээр бид нар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, 6 дугаар зүйлд заасан хориглох заалт, 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээ, 8 дугаар зүйлд заасан улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх жендерийн эрх тэгш

байдлын баталгаа, 10 дугаар зүйлд заасан төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа, 11 дүгээр зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгаа гэдгийг авч үзэхээр квотын хувийг бид нар заахад 10 жил болж байна. Одоо 12 дахь жилдээ орж байна.

Гэвч энэнээс үзэхээр бид нар Улсын Их Хурлын түвшинд 17 хувь гэдэг квотыг 17 хувийн суудлыг эмэгтэйчүүд авсан байна. Нэр дэвшүүлэхдээ 20 хувийг Сонгуулийн тухай хуульд заасан квотыг нэр дэвшүүлдэг. Энэ нь 23-аас 20 хувиас илүү нэр дэвшиж байсан ийм түүх байхгүй юм байна. Нэр дэвших квот 20 хувийгаа ер нь бол хангаад тэгээд энэ нэр дэвшүүлдгээс 17 хувийн төлөөллийг Улсын Их Хуралд бид нар эмэгтэй нэр дэвшигч байсан төлөөлөлтэй. Дүүргийн түвшинд энэ нь 17 хувь, аймаг, нийслэлийн түвшинд, сумдын түвшинд энэ нь арай их буюу 29 хувийн ийм байдалтайгаар харагддаг юм байна.

Өөрөөр хэлэх юм бол эндээс үзэхээр яамны сайд, дүүргийн Иргэдийн хурал, дүүргийн Засаг даргын орлогчоос бусад түвшинд сая хэлээд байгаа тэр 15, 20, 25, 30 гээд энэ квотын асуудал бүрэн хэрэгжиж байгаагүй. Бүрэн хэрэгжиж байсан түүхгүй ийм байдалтай байна. Тэгээд энэ сая Хэмнэлтийн тухай хууль гараад жишээлэх юм бол Засаг даргын орлогч нар, дэд дарга нарыг цомхотгосон. Тэгэхэд 4 аймгийн эмэгтэй Засаг даргын орлогчийг бас цомхотгосон байна. Өөрөөр хэлэх юм бол эмэгтэй албан тушаалд шашиж байгаа улс төрийн албан тушаалтнууд хамгийн түрүүн энэ хуульд хамрагдах, цомхотгох, чөлөөлөгдөх ийм эрсдэлтэй байдаг гэдгийг нь уул нь энэ дүгнэлтэд бас хийсэн.

Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдлын энэ хуулийн хэрэгжилтийг харахаар хамгийн гол саад болж байгаа асуудлууд юу байдаг вэ гэдэг эмэгтэй нэр дэвшигчид өөрсдөө Иргэдийн хурлын төлөөлөгч нар эмэгтэй,

намуудын төлөөлөл эд нараас хэлж байгаа гол үндэслэлийн нэг нь энэ санхүүжилттэй холбоотой асуудлыг номер нэгд дурддаг. Энэ дээр хэдийгээр хуваарилан заагаагүй боловч дэнчин гэдэг асуудлыг намдаа бид нар өгөх ёстой байдаг. Тэгээд 1 хүнд зориулсан зардал бол 40 сая орчим болдог гэдгийг хэлээд байгаа.

Ийм учраас эмэгтэйчүүд ямар эмэгтэйчүүд нэр дэвшиж байна вэ гэвэл нэгдүгээрт хувийн хэвшилд ажилладаг бизнесийн төлөөлөл эсвэл улс төрийн тогтолцоонд ажилладаг ийм 2 төрлийн эмэгтэйчүүдийг нэр дэвших боломжийг сонгуулийн тогтолцоотой холбоотой, санхүүжилтийн асуудалтай холбоотойгоор гарч ирдэг юм байна.

Дараагийн асуудал нь улс төрийн намын намууд 2 жил тутамдаа тайлангаа хүргүүлэх ёстой. Тэгээд энэ 8.2-т заасан энэ заалтыг хэрэгжүүлж байгаагүй. 2022 онд 3 намаас Жендерийн үндэсний хороонд анх удаа тайлангаа хүргүүлж байна гээд. Энийг Хүний эрхийн үндэсний комиссоос хариуцлагатай холбоотой дүгнэж байна. Өөрөөр хэлэх юм бол Жендерийн эрх тэгш жин тэгш байдлыг хангах тухай хуульд материаллаг эрх үүргийг заасан зохицуулалтыг заасан боловч хариуцлага яах нь тодорхойгүй иш татсан байдлаар орхигдуулсан учраас энэ дээр бас хариуцлага байхгүйгээс үүргийг хэрэгжүүлэхгүй явдаг үүргээ хэрэгжүүлээгүйн төлөө ямар нэгэн тийм арга хэмжээ авдаггүй ийм үзэгдэл байна гэдгийг дүгнэсэн.

Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хуулийн 65.2-т заасан, Жендерийн эрх тэгш жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4-д зааснаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай тайланг бас Хүний эрхийн үндэсний комисстой нэгэн адил Улсын Их Хурлаар хэлэлцэж дүгнэлт гаргуулж байх ёстой боловч энэ үүргээ яг хэрэгжүүлж байгаагүй байна гэдгийг тэмдэглэж байгаа.

Тийм учраас энэ нийтдээ 81 хуульд бол жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай энэ асуудлыг улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, боловсролын соёлын гээд бүх хүрээгээр нь заасан боловчиг тодорхой нэг асуудал бол механизм, санхүүжилт гэдэг дээр очиж хэрэгжилтийн байдал нь дутмаг байна, сул байна гэдэг асуудал гардаг учраас энэ дээр нь энийг хууль тогтоомжид нийцүүлэх хэрэгтэй байна гэдэг саналыг өгч байгаа.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд улс төрийн бүтцэд ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй 25 хувь нь ийм асуудал байдаг гэж хэлж байгаа юм байна лээ. 75 хувь нь ийм асуудал байдаггүй гэж.

Намын хувьд ер нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсээ яаж дэмждэг юм бэ гэхээр 60-аас дээш хувьтай 60, 70, 65 хувьтайгаар энэ Улсын Их Хурал судлалтай намуудын төлөөлөл манай бол эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн ялгаа гаргадаггүй адилхан дэмжих бодлого баримталдаг гэдгээ хэлж байна. Нийт 36 намаас яг дүрэмдээ заасан юм уу гээд аваад үзэхээр тэн дээр 3 намыг дүрэмдээ тодорхой бүтцийн түвшиндээ энэ Улс төрийн намын тухай хуульд заасан болон Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд заасан энэ квотыг хангаж ажилладаг юм байна гэсэн дүгнэлт ирж байгаа. Үлдсэн 33 нам дээр ямар нэг дүгнэлт хийх бололцоогүй байна гэдэг ийм дүгнэлтээ хийсэн.

Тэгэхээр ер нь энэ хэдийгээр 25 хувь гээд тэгэхээр энэ ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, намын бүтцийн түвшин нь бага мэт боловч энэ хүмүүсээс тодорхой эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхаж байгаа байдал, үндэслэл энэ талаараа гомдол гаргасан уу гэж асуухаар энэ нь цаашидаа мэдлэг, чадвар, ойлголт тийм ч хангалттай биш юм байна. Бид нар хангалттай мэдлэг

өгдөггүй юм байна гэж гарч ирж байгаа учраас энэ талаар чадавхжуулах ажил хэрэгтэй байна гэдгийг бас дүгнэж байгаа.

Өмнө нь Иргэдийн хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн төлөөллөөс асуухад ихэнх нь, ихэнх хүмүүс нь өөрсдийнхөө эрхийг ямар нэг байдлаар сонгогчдын зүгээс дайралт, гүтгэлэгт өртдөг, нэр төр эмзэг байдаг хамт сонгуульд нэр дэвших гэж байгаа өрсөлдөөний зүгээс бас өрсөлдөх явдалд, шударга бусаар өрсөлдөх явдалд гардаг гэдэг энэ тэр асуудлыг хөндөж байгаа боловч гомдол гаргасан хувь харьцангуй бага байдаг юм билээ.

Тийм учраас энэ гомдол, мэдээллийг сонгогчдын боловсролтой ч анхаарах хэрэгтэй байна. Хэвлэл мэдээллээр мэдээлж байгаа байдалдаа ч гэсэн бас анхаарах хэрэгтэй байна. Түүнээс гадна намын бүтцийн түвшинд ч гэсэн анхаарах хэрэгтэй байна гэдгийг хэлж байгаа юм. Ингээд ямар саналуудыг өгч байгаа вэ гэхээр юун түрүүн энэ хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагыг тусгах асуудлыг ярина.

Хоёрдугаарт квотыг нэмэгдүүлье. 50, 50 болгоё гэдэг ийм саналыг өгч байгаа юм. Яагаад гэвэл КОЙКА гээд олон улсын Өмнөд Солонгос Солонгос Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Улсын Их Хурлын гишүүн ахлаад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих энэ төсөл хэрэгжүүлж байгаа. Энэ хүрээнд хийсэн сүүлийн 2 жилийн судалгаагаар хэлээд байгаа нь өмнө нь байсан 30 хувийн квот, сүүлд 20 хувийн гэж оруулсан квот чинь үүргээ гүйцэтгэчихжээ гэж дүгнээд байна. Үүнээс цааши хэдүүлээ Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7.2.2, 7.2.3-д хэлээд байгаа тусгай арга хэмжээ гээч зүйлээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тул квотыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай хорооны 10 дугаар илтгэл Засгийн газраас өнгөрсөн 2022 онд

хэлэлцүүлсэн 6 сард. Энэ хорооноос өгсөн зөвлөмжийн нэг нь бас энэ квотыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн зорилго тавьсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүх харилцаанд оролцох энэ манлайллыг дэмжих үүргээ Засгийн газраас бас хэрэгжүүлэхийг цохон тэмдэглэсэн.

Дараагийн асуудал нь улс төрийн шийдвэр гаргах түвшин ярихаар улс төрийн намын бүтэц, дотоодын институт, бүтцийн тогтолцоо ярихгүй бол болдоггүй. Тийм учраас энэнтэй холбоотой болохоор намын бүтэц тогтолцоо нь эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр, тусгай арга хэмжээ хэрэгтэй байна. Энэ талаар тодорхой арга хэмжээ аваач, жендерийн аудит хийх бас тухай асуудлыг тусгайлан хөндөвч гэдгийг дүгнэж байгаа. Хуулиудад энэ хариуцлага, зөрчлийн асуудал. Зөрчил гарлаа гэж бодоход материаллаг хуульд заачихсан тэр эрх, үүргийг зөрчихөөр ямар хариуцлага хүлээх вэ гэдэг асуудлыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангаж өгөх талаар асуудлыг тусгаач гэдэг саналыг оруулсан.

Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуульд ялангуяа энэ эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих эсвэл намтай холбоотой, тухайн хувь хүнтэй холбоотой ямар дэмжлэг арга хэрэгсэл байж болох вэ энэ дэмжлэгийг авна уу гэдэг асуудлыг хүсэж байгаа.

Түүнээс гадна сонгогчдын боловсрол, хэвлэл мэдээллийн эмэгтэйчүүдийн талаар хэвмэл ойлголтыг эвдэхдээ эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн талаар аль аль ишлэл бол эвдэх талаар бас тодорхой арга хэмжээ аваач гэж зөвлөж байгаа учир нь эрэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг дэмжих хандлага бол эмэгтэйчүүд эмэгтэйчүүд дэмжих хандлагаас 10 хувиар илүү байдаг юм юм байна лээ. Тэгээд энэ нь юутай холбоотой вэ гэхээр бид нарын бий болгосон дүр төрх өөрөө хэн бэ, эмэгтэй нэр дэвшигч гэхээр бид

нар төгс төгөлдөр ийм дүр төрийг бас хэтэрхий үзүүлээд байна уу, тодорхой энэ хэвлэл мэдээлэл, цахим, олон нийтийн сүлжээнд эмэгтэй нэр дэвшигчдийн талаар гарч байгаа мэдээллийг үзэхээр хэтэрхий сөрөг буюу хувь хүний гадаад төрх, өнгө үзэмж, хийж байсан ажилтай холбоотой.

Өөрөөр хэлэх юм бол тэр ур чадвар, мэдлэг гэдэгтэй хийсэн нь илүү өөр байдалтай нь холбоотойгоор эмэгтэй хүнийг дайрах, доромжлох, гүтгэх ийм зарим тодорхой ийм нэр томъёог бүүр хэрэглэх энэ асуудал хэт сөрөг, сөрөг ийм нэр томъёо хэрэглэх доромжлох асуудал бол байдаг юм байна гэдгийг нь дүгнэсэн байгаа учраас сонгогчдынхоо боловсролыг бас анхаарах ёстой юм байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр бас сэтгүүлчдийн боловсрол дээр нь анхаарах ёстой юм байна гэдэг энэ асуултуудыг зөвлөмж болгох саналаар өгсөн.

Анхаарал тавьсанд баярлалаа. Асуулт байвал хариулъя.

Б.Энхбаяр: Улс төрийн хүрээнд жендерийн эрх тэгш байдалтай холбоотой Хүний эрхийн үндэсний комиссын тайлантай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр манай Монгол Улс жендерийн тэгш байдал дээр маш онцгой ханддаг ялангуяа улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог илүү нэмэгдүүлэх тал дээр байнга дэвшил гаргаж явж байгаа. Тэгэхээр эмэгтэйчүүд төрд байснаар илүү энэ төрийн гаргаж байгаа шийдвэр мөн түүнчлэн төрийн үйл ажиллагаанд оролцож байгаа оролцоо нь илүү шударга тогтвортой байх. Ийм тал дээр илүү давуу талыг авчирч байгаа гэж үзэж байгаа.

Гэхдээ, гэвч харамсалтай нь өнөөдөр төрийг төлөөлж байгаа

эмэгтэйчүүдийн яг тэр манлайлал нь бас хангалттай түвшинд сонгогдож гарч ирсэн хүмүүс ажиллаж чадахгүй шүүмжлэлд өртөх ийм зүйлүүд маш их байгаад байна.

Тэгэхээр улс төрийн 2 том нам бол Ардчилсан нам, Монгол Ардын нам бол хоорондоо өрсөлдөх замаар жендерийн хувь хэмжээг нэмэгдүүлэх өөрөөр хэлбэл, өнгөрсөн сонгуулиар Сонгуулийн хуулиар 20 хувийн мандатыг олгож байсан бол одоо Монгол Ардын нам энэ Сонгуулийн хууль нь 30 хувь, Ардчилсан нам 40 хувь гэх зэргээр энэ жендерийнхээ оролцоог нэмэгдүүлж оруулж ирдэг. Тэгэхээр энэ дээр гол асуудал бол яг ингээд жагсаалт дотор пропорциональ систем яваад жагсаалтын ард эмэгтэйчүүдийг зогсооно. Тийм учраас чи ер нь нэлээн олон эмэгтэйчүүдийг жагсаалтад зогсоочихлоор заавал тойрог дэвших эмэгтэйчүүд тодорхой хүчтэй манлайлал бүхий хэдхэн эмэгтэйчүүд гарч ийм юм руу л дөхөөд байна л даа.

Тийм учраас энэ яг энэ улс төрийн жендерийн илүү сайн түвшинд явах тэр бололцоог ямар тохиолдол, өөрөөр хэлбэл, энэ жагсаалтын хойгуур эмэгтэйчүүдийг жагсаах замаар энэ тоонд нь хүргэх биш, илүү яаж тойрог дээр хүчтэй лидер эмэгтэй гаргаж ирэх вэ гэдэг тал дээр ямар зүйлийг хийвэл илүү үр дүнтэй вэ гэсэн ийм асуулт байна.

Б.Энхбаяр: Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Сүнжид 3 номерын микрофон.

Д.Сүнжид: Манай энэ сэдвийн хүрээнд бас хөндөгдөж л байгаа юм л даа. Эмэгтэйчүүдтэй ярилцлага хийхээр нэр дэвшиж байсан. Тэгэхээр хэлээд байгаа нь бид нарын эрсдэлтэй байдаг асуудал нь намаас намын дэмжлэг л гэж байна. Намын дэмжлэг, санхүүгийн дэмжлэг, тэгээд олон нийтийн ойлголт, хандлага гээд 3 юман дээр төвлөрөөд өгөх юм бол бид нар энэ дээр ажиллаж чадна гэж үзээд байгаа юм.

Тэгээд жишээлбэл яах вэ өмнө нь гарч байсан туршлагаудаас яриад байгаа юм л даа. Жишээлэх юм бол хүчтэй тойрогт нөгөө намынхаа хүчтэй өрсөлдөгчид албаар эмэгтэй хүнийг тулгаж өгдөг гэж бас дурдсан байгаа юм тээ. Тэгэхээр ингээд ийм маягаар юу гэдэг юм, жагсаалт юм уу, мажоритар тогтолцоо юу, пропорциональ тогтолцоо юу гэдгээс алинаас нь үл хамаараад намын дэмжлэг чухал юм билээ. Намын дэмжлэг чухал байхын тулд тухайн хувь намын даргаас хамааралгүй байхын тулд дүрэмдээ энэ бүхнийгээ зохицуулсан байх нь зүйтэй байна л гэдэг зөвлөмжийг Хүний эрхийн үндэсний комиссоос өгч байгаа юм.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2016 оны сонгууль бол жишээ нь манай нам эв нэгдэлгүй байсан учраас ард түмэнд үнэ тавиад ерөнхийдөө хуугаараа ялагдсан. 20 оны сонгууль 2 намын лидерийн хоорондын л өрсөлдөөн болсон. Өөрөөр хэлбэл хэт өндөр рейтингтэй Хүрэлсүх, хэт адгийн рейтингтэй Эрдэнээ хоёрын хооронд. Энэнээс болоод манай нам ялагдсан. Тэгээд энэ дотор яасан бэ гэх дээр маш их олон эмэгтэйчүүд 20 оны сонгуулиар орж ирсэн. 20 оны сонгуулиар орж ирсэн. тэгээд өнөөдөр энэ 20 оны сонгуулиар орж ирсэн Ардчилсан намаас бусад намын эмэгтэйчүүд бас нэг жосоохон эмэгтэйчүүдийн тэр хүлээлтэд хүрч чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр 24 оны сонгууль Монгол Ардын намын энэ байж байгаа царай ийм тохиолдолд бол эмэгтэйчүүд.../минут дуусав./

Б.Энхбаяр: Би ч уг нь асуулт асуухгүй гэж бодож байсан. Пүрэвдорж гишүүн асуух сэдэл төрүүлсэн. Нам ярилаа л даа. Мэдээж улс төр дэх жендерийн эрх тэгш байдлын асуудал бас хөндөгдөж байна. Тэгэхээр энэ шийдвэр гаргах түвшинд мэдээж

эмэгтэйчүүдийн оролцоо алхам алхмаар бас нэмэгдэж байна. Парламент ганцхан эмэгтэй гишүүнтэй байсан түүх байгаа шүү бас. Бүүр ганцхан 76-гийн бүүр ганцхан ийм түүхтэй. Энэ тоо бол би нэмэгдэж цаашаа улам нэмэгдэнэ гэдэгтээ огтхон ч эргэлздэггүй. Монгол Ардын нам эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх дээр улс төрийн манлайллыг үзүүлж байгаа. 2020 онд жишээлбэл Хүний эрхийн үндэсний комиссыг нээлттэй сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлж томилох энэ зарчмыг эхлээд нутагшуулсан. Одоо энд сууж байгаа Хүний эрхийн үндэсний комиссын 6 гишүүний 4 нь эмэгтэй байгаа. Энэ төрийн өндөр албан тушаалтнууд. Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг мөн нээлттэй сонгон шалгаруулах чиглэлээр Шүүхийн хуулийг гаргасан. Парламентаас нээлттэй сонгон шалгаруулж томилох 5 гишүүний 4 нь эмэгтэй нэр дэвшигч ялж гарч ирж байсан.

Тэгээд би энийг зүгээр юу гэж харсан гэхээр тэгш, шударга өрсөлдөх яг боломж олговол эмэгтэйчүүд өөрсдөө гараад ирчих юм байна угаасаа. Энэ боломжийг л бүрдүүлэх ёстой юм байна. Ерөөсөө шударга ингээд өрсөлдөх тэр боломжийг олгох ёстой юм байна гэдгийг би яг эндээс бас их олж харж байсан. Яг шударга өрсөлдвөл угаасаа ингээд чадлаараа, хүчээрээ ингээд туршлагаараа гараад ирэх юм байна лээ.

Тийм учраас энэ боломж нөхцөлийг бүрдүүлэх дээр манлайлж байгаа. Тэгэхдээ өөрсдөө хоорондоо өрсөлдөө гээд бас зүгээр суухгүй байгаа. Хэрвээ анзаарах юм бол манай намын дарга Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд тавих дээр улс төрийн урьд хожид байгаагүй манлайллыг үзүүлж байгаа юм. Анх удаа эмэгтэй Засаг дарга тавьж байна. Аймгууд дээр анх удаа шүү дээ энэ чинь. Нэр дэвшүүлэлт дээр анхаарч байна. Одоо ингээд сайд, дэд сайд,

Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар гэдэг дээр бас боловсролтой, залуу гэлгүйгээр бас ийм боломжийг, энэ манлайллыг үзүүлэх дээр бас нэлээн лийд хийж манлайлал үзүүлж ажиглаж байгаа. Энэ нь Ардчилсан намд ч гэсэн нөлөөлнө.

Яагаад гэхээр Ардчилсан нам эндээс хоцрохыг хүсэхгүй шүү дээ. Нөгөө Ардын нам нь ийм прогрессив манлайлал үзүүлээд эхлэхээр Ардчилсан нам бас сая хэлсэнчлэн нөгөө Эрдэнэ даргатайгаа адгийн болоод сууж байж байх болохгүй болчихож байгаа байхгүй юу хүчээр. Тэр утгаараа энэ бүхэлдээ бол энэ бас улс төрийн намуудын шударга зүйл дээр бас манай нам, манай намын дарга бас манлайлж ингэж бас ажиллаж байгаа гэдгийг бас цохон тэмдэглэе.

Ингээд “Улс төрийн хүрээнд гэх жендерийн эрх тэгш байдал” сэдвээр асуулт асууж дууслаа. Хэлэлцэж байгаа асуул асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн үг хэлбэ.

Ц.Сандаг-Очир:

Гишүүд

боломжийг ашиглаж улс төр хийхгүй. Би бол эмэгтэйчүүдийг дэмжиж байгаа юм. Жендерийн асуудал ярихаар молигддуулав л гэх гэж байгаа юм. Энэ улс төрийн намынхан сая хэд хоногийн өмнө бөөн гар хөлийн үсэг зураад л, гэрээ байгуулаад л, квотыг нэмэгдүүллээ гээд л байгаа юм. Квотыг нэмэгдүүлэх гэдэг юм уу, гэрээ байгуулах нэг хэрэг. Эцсийн үр дүндээ эцсийн гүйцэтгэл байхгүй юу. Энэ 76 дотор 76-гийн 30 хувь нь гэдэг юм уу 20 орчим эмэгтэйчүүд орж ирж эцсийн гүйцэтгэлээрээ улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо сайжирсан байна гэдгийг нь л харах ёстой юм. Тэрнээс тэр нэр дэвшүүлэлтэд 30 байна уу, 40 байна уу тэр бол хамаагүй.

Яагаад гэхээр түрүүн тэр Сүнжид гишүүнийг хэлсэн тэр яг адилхан эмэгтэйчүүд их ямар ч манлайлагч эмэгтэйчүүд байсан гэсэн аваачаад тэр

орон нутагтаа гэдэг юм уу „масс танигдсан том улс төрчдөө тулгаад хаячхаж байгаа байхгүй юу. Ингээд шударга, тэгш өрсөлдөх тэр бололцоо, боломжийг нь хаагаад олон сайхан манлайлагч эмэгтэйчүүдийн ... гаргаж байна.

Хэрвээ ийм байдлаараа энэ саяын гэрээ юмнууд явбал эмэгтэйчүүд ахиад л молигоддуулна. Хэрвээ жинхэнэ утгаараа хүсэж байгаа гэвэл эмэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй нь өрсөлдүүлэх тэр тогтолцоо юмаа сонгуулийн хуульдаа оруулж өгвөл жинхэнэ утгаараа жендерийн асуудал яригдах юм.

Тийм учраас одоогийн байгаа байдлаараа ингээд нэг гэрээ байгуулаад квот яахаар манай эмэгтэйчүүд нэлээн баярлаад байх шиг байгаа юм. Ороод ирчих юм байна гэж. Үгүй шүү. Эцсийн үр дүндээ гүйцэтгэл нь, хамгийн чухал нь үр дүн энд орж ирсэн нь хэд вэ гэдгээр нь хэмжигдэх ёстой юм.

Тийм учраас эмэгтэйчүүд минь энэ улс төрийн намуудад молигоддуулчав гэж би хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. “Улс төрийн хүрэн дэх жендерийн эрх тэгш байдал” сэдвийг хэлэлцэж дууслаа.

Одоо Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний энэ дараагийн байдлын 22 дахь илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх”-ийн сэдвийн талаарх танилцуулгыг сонсох гэж байна. Энэнээс хойших сэдвүүд явах гэж байгаа учраас холбогдох албан тушаалтнууд нь үлдээд бусад албан тушаалтнууд нь бас явж байж болно. Одоо бол Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй холбоотойгоор Хүний үндэсний эрхийн үндэсний комисс, Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын төлөөллүүд үлдээд, мөрдөх байгууллагын Шүүхийн ерөнхий зөвлөл үлдээд бусад саяын хэлсэн Хөдөлмөр, нийгмийн

хамгаалал, эрүүл мэнд энэ байгууллагын төлөөллүүд явж болж байна. Тийм сэтгүүлчид бас байж болно.

Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх”-ийн сэдвийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд танилцуулна. 7 номерын микрофон.

Б.Энхболд: Эрхэм Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангаж, хамгаалах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөрдөн шалгах болон шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах алба хаагчдын мэддэг хандлагыг дээшлүүлэх чиглэлээр төрийн бодлогын хувьд анхаарч ирсний үр дүнд эерэг сайн өөрчлөлтүүд олон гарсныг юуны өмнө онцлон тэмдэглэж байна.

Энэ удаагийн комиссын илтгэлд хөндсөн асуудлын үр дүнд цаашид сайжруулах талаар комиссын дараах дүгнэлт, саналтыг танилцуулж байна.

1.Сэжигтний шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагааны талаар.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах 2 төрлийг хуульчилсан байна. Судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд жилд 65 мянга орчим хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагаас 1.6 буюу 900 орчим хүнийг баривчлан шалгадаг статистик байна. Сүүлийн 3 жилийн байдлаар шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа нь нийт баривчлах ажиллагааны 98-99 хувийг эзэлж байгаа нь Нэгдсэн Үндэстний байгууллагын дур зоргоор

саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлттэй нийцэж байна гэж үзэж байна.

Гэвч ийнхүү баривчилсан тохиолдол бүрийг хүний эрхийн зөрчил хяналтын гадуур хийгдсэн хууль бус ажиллагаа гэж үзэхгүй бөгөөд зохих хэмжээнд прокурорын хяналт шүүхийн зөвшөөрлөөр хэрэгжсэн байна. Харин уг ажиллагаа шүүхийн хяналтад бүрэн ороогүй, прокурор сэжигтнийг баривчилсан тогтоолыг шүүхэд нэн даруй хүргүүлнэ. Шүүх уг тогтоолыг 24 цагийн дотор шийдвэрлэнэ гэсэн хуулийн заалт хэрэгжилт хангалтгүй байгаагаас хүнийг хууль бус дур мэдэн баривчлах эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж дүгнэсэн.

Тухайлбал 2020 онд 793 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 50.1 хувь буюу 398-ыг, 2021 онд 809 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 41.2 хувь буюу 334, 2022 онд 1075 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас 33.1 хувь буюу 355 сэжигтний тогтоолыг шүүхэд хүргүүлэхгүйгээр 48 цагийн хугацаатайгаар баривчилсан байна.

Хүний эрхийн үндэсний комиссын дүгнэлтээр нийт баривчлах арга хэмжээний 73 орчим хувь нь шүүхийн хяналтад орохгүй байна гэж дүгнэсэн. Шүүхийн хяналтыг тасралтгүй байлгах нэг хэлбэр нь шүүх прокуророос ирүүлсэн баривчлах тогтоолын үндэслэлийг тухай бүр шуурхай хянаж шийдвэрлэдэг байх явдал юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах чиг үүргийн болон прокурорын байгууллага 24 цагийн горимоор ажилладаг бол төв орон нутгийн хэмжээнд шүүх ийм горимоор ажиллаж жигдрээгүй, хууль, эрх зүйн орчин тодорхойгүй байдлаас шалтгаалан ажлын бус цаг эс үгүй бол амралтын өдрүүдэд сэжигтнийг баривчилсан тогтоолыг хянуулахад хүндрэл учирдаг нөхцөл байдал илэрч байна.

Үүнтэй холбоотойгоор олон нийтийн дунд сэжигтнийг баривчлах ажиллагааг ажлын бус өдөр ялангуяа баасан гарагт эс үгүй бол ажлын бус цагаар хийдэг гэх шүүмжлэл түгээмэл гарсан. Хүний эрхийн үндэсний комиссын судалгаагаар сүүлийн 3 жилийн байдлаар шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан нийт сэжигтний 587 буюу 68.7 хувийг ажлын өдөр, 207 буюу 23.9 хувийг 7 хоногийн амралтын өдрүүдэд баривчилсан бол үүнээс 9.3 хувийг баасан гарагт баривчилсан байна.

Дээрх судалгаанаас үзэхэд лхагва гарагт баривчилсан тохиолдол хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа хамгийн бага үзүүлэлттэй байгаа тохиолдол нь баасан гараг байна гэж дүгнэсэн. Гэсэн хэдий ч баасан гарагт баривчилсан тохиолдолд шүүхийн хяналтад орохгүй байх хувь хэмжээ өндөр байгааг анхаарах нь зүйтэй. Баасан гарагт баривчлагдсан сэжигтний шүүхийн хяналтгүйгээр 48 цаг саатуулах тохиолдол 65.3 хувь, 48 цагаас илүү хугацаагаар саатуулсан тохиолдол 9 хувь байгаа бол тэдний 91 хувийг прокурор баривчлах байрны дарга сулласан байна.

Мөн ажлын өдөр эс үгүй бол ажлын бус цагаар баривчилсан хэдий ч тогтоолыг шүүхэд нэн даруй хүргүүлэхгүй байх явдал цөөнгүй байгааг мөн анхаарах шаардлагатай байна.

2.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар.

Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх нийтлэг журам тухайн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь хүний эрхийг зөрчих эрсдэлтэй байдал үүсэх нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Монгол Улс жилд дунджаар 2592 хүн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч байна. Энэ нь нийт яллагдагчдын 8.3 хувьд нь цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авдаг бөгөөд 100 яллагдагч тутмын 8 нь энэ арга хэмжээг хэрэглэдэг байна.

Мөн хорих ял шийтгүүлсэн нийт хоригдлын 24.3 хувь нь шүүхийн өмнөх шатанд цагдан хоригддог гэсэн үзүүлэлт гарч байгаа юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 3-д шүүхийн өмнөх шатанд хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй гэж заасан. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бол цагдан хорих нийтлэг үндэслэл журмыг бол тодорхой хэмжээнд зохицуулж өгсөн. Энэ зохицуулалтуудыг илүү нарийвчлан хуульчлах шаардлагатай гэж үзэж байгаа. Тухайлбал, Улсын Их Хурлаас 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн тусгай ангид 94 зүйл хэсэгт хорих ял огт оногдуулахгүй байхаар хуульчилсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу цагдан хорих үндэслэлд эдгээр хэргүүд бол мөн хамаарч байна.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаарх үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн ээдрээ төвөгтэй байдал гэсэн ойлголтуудыг хуульчилсан нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлахад тавигддаг шаардлагыг хэт өргөжүүлсэн шинжтэй зохицуулалт гэж дүгнэсэн.

Энэ нь мөрдөн шалгах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтан, өмгөөлөгчдийн дунд явуулсан судалгааны дүнгээр ч тодорхой харагдаж байна. Цагдан хорих таслан сэргэх арга хэмжээ эцсийн арга хэмжээ болох болгож хэрэглэх боломжийг бүрдүүлээгүйгээс уг арга хэмжээг эхний байдлаар хэрэглэх хандлага түгээмэл байгааг анхаарах нь зүйтэй.

Шүүхийн судалгаанаас үзэхэд сүүлийн 5 жилийн байдлаар таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар шүүхэд ирүүлж байгаа саналын 89.2 хувь нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, 10.1 хувь нь хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ,

0.7 хувьд нь тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх арга хэмжээ байгааг анхаарах нь зүйтэй.

Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг үр дүнтэй явагддаггүй. Шүүх мэтгэлцээнд үндэслэн хөндлөнгийн шийдвэр гаргадаг эсэх нь эргэлзээтэй. Өмгөөлөгчийн оролцохоо хангалтгүй байгааг мөн комиссын судалгаагаар тогтоосон. Тухайлбал шүүхийн хэлэлцүүлэг мэтгэлцээний үндсэн дээр явагдахгүй, нотлох баримтыг ил тод хэлэлцдэггүй, цагдан хорих арга хэмжээ авагдаж байгаа хүний өмгөөлүүлэх эрхийг бүрэн хангахгүй байгааг залруулах шаардлагатай гэж үзсэн. Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгчийн оролцоо туйлын хангалтгүй байдаг талаар судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 72.1 хувь нь дурдсан бол, шүүхийн хэлэлцүүлэгт цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хамаарах нотлох баримтыг нээлттэй хэлэлцдэг байхыг судалгаанд оролцсон шүүгчид 100. Хувь, прокуроруудын 78.4 хувь, мөрдөгчдийн 72.2 хувь, өмгөөлөгчдийн 72.1 хувь нь тус тус дэмжсэн байна.

Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний үндсэн хугацааг нэг сар гэж тогтоосон нь өсвөр насны хүнд нийтлэг байдлаар үйлчилж байгааг мөн залруулах шаардлагатай гэж дүгнэсэн. Түүнчлэн шүүхийн шатад цагдан хоригдож байгаа, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл хугацаа тоолох журмыг нарийвчлан зохицуулаагүй нь хүний эрхийн зөрчил үүсгэж байна гэж дүгнэсэн.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас батлан гаргасан хүний эрхийн холбогдох баримт бичгүүдэд баривчлагдсан буюу цагдан хоригдсон хүн бүр гэсэн нэр томъёог хэрэглэсэн байхад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

яллагдагчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар зохицуулсан бөгөөд шүүхийн шатад хэргээ шийдвэрлүүлэхээр хүлээж байгаа шүүгдэгчийн хувьд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх процессыг нарийвчлан хуульчлаагүй, хугацаатай болох талаар яллагдагчид баримтлах хэм хэмжээг хэрэглэхгүй байгаагаас шалтгаалж хэргээ богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх, суллагдах эрх зөрчигдөхөд хүрэгдэж хүрч байна.

Судалгаанаас үзэхэд 42 сар цагдан хоригдсон тохиолдол ч гарч байгаа бөгөөд энэ талаар Хүний эрхийн үндэсний комисст ирэх гомдол нэмэгдсээр байгааг анхаарах нь зүйтэй.

Бүх насаар хорих болон ганцаарчлан хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар.

Монгол Улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 2 дугаар протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэчлэн найруулж цаазаар авах ялыг халж тодорхой төрлийн гэмт хэрэгт бүх насаар хорих ял оногдуулж болохоор хуульчилсан нь дэвшилттэй зохицуулалт гэж дүгнэж байна.

Гэвч Эрүүгийн хуульд заасан бүх насаар хорих ялын агуулга, дэглэмийг бүрэн тодорхойлоогүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял эдлүүлэх дэглэм дэглэмийн онцлог, зохион байгуулалт, сургалт, хөдөлмөрийн харилцаа, тэдэнтэй ажиллах алба хаагчийн хөдөлмөрийн харилцаа зэргийг бүрэн тусгаагүйгээс гадна бүх насаар хорих ял эдэлж байгаа хоригдлын эрхийг хангах талаар одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна гэж.

Мөн Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн ялын бодлогын шинэчлэлд хүнийг тусгайлсан дэглэм бүхий байранд ганцаарчлан

хорьдог баривчлах ялыг халсан боловч ганцаарчлан хорих ял эдлүүлэх шийтгэл өнөөг хүртэл байсаар байгааг хүний эрхийн зөрчил гэж дүгнэлээ. Хорих ял эдлүүлэх дэглэмийн зэрэглэл хүндрүүлэн ганцаарчлан хорих арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналаар прокурор шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль олон улсын эрх зүйгээр баталгаажуулсан хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлахад тавигдах үндэслэл шалгуурт нийцэхгүй юм.

4.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаар.

Эрүүгийн хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх явцад хүний эрх зөрчигдөх явдал түгээмэл байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл хэт цаг үеэсээ хоцорсон сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчийг урьдчилан тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах, сэтгэцийн өвчтэй хүнд холбогдох хэргийг шийдвэрлэхэд өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадлагын арга хэмжээг үргэлжлүүлэх, сунгах, зогсоох, эмнэлгийн төрөл, дэглэм, эмчлэгдсэн боловч ар гэрийнхэн нь хүлээж авахаас татгалзсан хүнийг нийгэмд гаргах талаарх эрх зүйн орчин тодорхой бус байсаар байна.

5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх бүхий албан тушаалтнаас хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлаж саатуулах арга хэмжээ авах эрх олгогдсон түүнийг хэрэгжүүлэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй нь дур мэдэн саатуулах эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж дүгнэсэн.

Иймээс дараах хэдэн саналыг танилцуулж байна.

Нэгдүгээрт. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн цогц байдлаар шийдвэрлэх нь зүйтэй. Ингэхдээ сэжигтнийг баривчлах ажиллагааг шүүхийн хяналтад бүрэн оруулах үүднээс таслан сэргийлэх арга хэмжээ авах зөвшөөрлийн шүүхийн тогтолцоог судлан үзэх. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан үндэслэлийг баривчилсан тохиолдолд баривчлаад шүүхэд мэдэгдээгүй тохиолдолд нөхөж мэдэгдэх тогтолцоог холбогдох хууль тогтоомжид тусгах.

Хоёрдугаарт цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ, нийтлэг журам, хорих үндсэн болон сунгах хугацаа өсвөр насны яллагдагчийг цагдан хорих тусгай журам цагдан хорих үндэслэлд хамаарах хэт ерөнхий болон өргөжүүлсэн зохицуулалт, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна.

3. Бүх насаар хорих ялыг бие даасан ялын төрөл болгон хуульчлах, энэ төрлийн ял эдлүүлэх дэглэм зохион байгуулж сургалт, хөдөлмөрийн стандартыг шинээр тогтоох шаардлагатай бөгөөд зэрэглэл дээшлүүлэн хүндрүүлэн хорьж байгаа явдлыг таслан зогсоох шаардлагатай.

5. Эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл эрх зүйн зохицуулалтыг хүний эрхийн зарчмын хэмжээнд нийцүүлэн цогц байдлаар нь шинэчлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүнийг эрүүжүүлэх, саатуулах болон бусад албадан арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах, шүүх, прокурорын хяналтыг өргөжүүлэх, мөн шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчид

хүний алдашгүй чөлөөтэй байх эрх, хууль бус дур мэдэн баривчлах хүний эрхийн зөрчил болох талаарх сургалтыг тогтмол зохион байгуулж, хүний эрхийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх шаардлагатай байна гэсэн саналыг танилцуулж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Б.Энхбаяр: Энхболд гишүүнд баярлалаа. Халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудлыг хэлэлцэж байгаатай холбоотойгоор оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Чинбат Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баянжаргал Улсын ерөнхий прокурорын туслах прокурор Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Золжаргал Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор Энхтөр Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, хурандаа, Анхбаяр Тагнуулын ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээний газрын дарга, хурандаа, Жаргалбаатар Авилагтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, Нэргүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга, хурандаа, Хишигбаяр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Харуул хамгаалалтын хэлтсийн дарга, хурандаа, Батсуурь Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа, Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Сэргэлэн Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, цагдаагийн хошууч, Сүхбат Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөний бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Лхагвадорж

Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Отгонжаргал Нийслэлийн цагдаагийн газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын дарга, цагдаагийн хурандаа, Гантулга дотоод хэргийн их сургуулийн , ямар салбар сургууль гэж байгаа юм бол? Эрүүгийн л юм шиг байна. Салбар сургуулийн захирал байна. Цагдаагийн дэд хурандаа, Ганзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Халдашгүй чөлөөтэй байх эрхийн тайлантай холбоотой асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Хүний эрхийн хорооноос гарч байгаа дүгнэлтийн дагуу маш их олон 98 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад байна гэдэг энэ зүйлийн учир шалтгаан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.2-т заалтаас болоод л ерөөсөө өөрөөр хэлбэл хойшлуулдаггүй тохиолдолд баривчлах энэ заалтын дагуу баривчлаад байгаа юм л даа.

Тэгэхдээ энэ дээр нийтдээ 2022 онд 867 хүн баривчилсны 448-ыг нь үргэлжлүүлэн шүүхийн шийдвэр гаргаад хориод явсан байна. Тал нь тэр үргэлжлүүлэн хоригдоогүй гэсэн үг. Тэгээд энэ хэрээр ерөөсөө тэр хүмүүс хүнийг аваачиж хэлмэгдүүлж байна л гэсэн үг байхгүй юу.

Тийм учраас энэ 2016 онд энэ Эрүүгийн Тэмүүжиний хууль дээр энэ заалт ерөөсөө байгаагүй юм. Тэгээд 16 онд буцаагаад татаад явсан. Буцаж орж ирэхдээ энэ заалт орж ирээд тэгээд тэр нь болохоор шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах тэр бүх л тийм агуулгыг өөртөө шингээчихсэн, тэгээд дээрээс нь мөрдөгч нь дур зоргоороо аашлах,

дуртай хүнээ баривчлах ийм боломжийг олгосон ийм заалт оруулж ирснээс болоод л ерөөсөө энэ хүний эрхийн зөрчил маш их явагдаж байгаа.

Тийм учраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тэр 31.5.1.2 дахь заалтыг энэ хуулиас хасах ёстой. Тэгж байж энэ хүний эрхийн нөхцөл байдал чинь хамаагүй дээ дээшилж, тэр шүүхийн шийдвэргүй баривчилдаг тэгээд энэ дэлхий даяар муу нэр зүүдэг энэ зүйлээсээ л сална гэж үзэж байгаа. Тэгээд энэ талаар ямар хасах талаар ямар бодолтой байгаа юм?

Хоёрдугаарт нь бас нэг энэ шүүхийн шийдвэргүй хүмүүсийг торгоод, баривчлаад байгаа нэг зүйл миний өргөн барьчихсан бас нэг хууль байгаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.1-д бусдын нэр хүндэд халдах гэдэг заалтын дагуу өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдана гэж тэгэнгүүт албан тушаалтан өргөдөл гаргангуут нь нэг удаа 50 мянгаар торгоод, дараачийн удаа 500 мянгаар торгоод 3 дахь удаа нь шууд баривчлаад явчхаж байгаа юм.

Тэгээд энэ чинь ерөөсөө прокурорын хяналтгүй, шүүхийн шийдвэргүй яваад байгаа. Тэгээд яах вэ сүүлд нь ингээд нэгтгэж авчраад прокурорууддаа хянуулаад ингээд л явж байгаа л даа. Тэгээд буцаагаад түүнийгээ Зөрчлийн хуулийн 5.9-өөр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн гээд ингээд торгоод явуулаад байдаг. Энэ чинь бас нийтдээ 300 гаруй иргэнийг торгосон, баривчилсан ийм шийдвэр болчихоод байгаа.

Тийм учраас энэ 2 дээр ялангуяа Хууль зүйн Сайнзориг хариулна биз. Хууль зүйн сайд энэ дээр энэ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн тэр асуудлыг чинь засна гэсэн. Хамгийн гол нь тэр 31.5.1.2 дахь заалтыг нь сүүлийн 1.2 дахь заалт хэсгийг яаж энэ чинь хамгийн гол асуудал хамгийн хүнийг баривчилж байгаа шүүхийн

шийдвэргүй баривчилчихаад тэгээд явж байгаад тал нь үргэлжлүүлээд гэмт хэрэг энэ тэр нь янз янзын юм болдог юм уу шүүхийн шийдвэр гардаг. Талыг нь тэгээд л ерөөсөө суллаад явуулж байна гэдэг чинь яаж байна? Тэнд маш тийм ноцтой хүний эрхийн зөрчил гарч байна гэсэн үг байхгүй юу даа тэгээд. Энийг л энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас хасах нь хамгийн чухал байгаа. Тэгээд энэ дээр ямар Хууль зүйн яам ямар бодлого баримталж байгаа юм? Дээрээс нь тэр Гэмт хэрэг зөрчлөөс сэр урьдчилан сэргийлэх тухай хууль дээр?

Б.Энхбаяр: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг дарга, 11 номерын микрофонд хариулъя.

П.Сайнзориг: Гишүүний асуултад хариулъя. 2 асуулт асуулаа. Сүүлийнхээс нь эхлээд хариулъя. Монгол Улсын Засгийн газраас Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барьсан. Уг хууль дээр бас хэт ерөнхий байдлаар зөрчлийн шинжийг тодорхойлж бас үүнд нь тодорхой хэмжээний шийтгэл оногдуулж байгаа байдлыг засаж залруулах ажлыг бас нэлээдгүй хийж байгаа. Өөрөөр хэлэх юм бол зөрчилд тооцох энэ үйлдлийг гэмт хэрэгтэй давхцахгүй байх нөгөө талдаа бүх иргэдийн эсрэг, эрх эрх зүйн эсрэг гэдэг юм уу жижгээр би хаалт дотор хэлж байгаа тодорхой хэмжээний дор нь бас залруулж болох энэ үйлдлүүдийг зөрчилд тооцохгүй, шийтгэл оногдуулахгүй байх чиглэлд бас Зөрчлийн хуулийн гол шинэчлэл явж байгаа.

Үүн дээр Гэмт хэрэг, зөрчлийн тухай хуульд заасан иргэний гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй гэдэг дээр хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх гэсэн энэ үүргээ биелүүлээгүйн улмаас торгож байгаа, шийтгэж байгаа энэ байдлыг бид нар бүрэн халж байгаа. Өөрөөр хэлэх юм бол тодорхой үр дагавартай энэ үйлдлүүдэд хариуцлага оногдуулах ийм чиглэл

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг уг нь Улсын Их Хурлаар өргөн барьсан, хэлэлцэх эсэхийг шийдчихсэн. Байнгын хороон дээр ажлын хэсэг гарч хэлэлцэнэ гэсэн ийм ойлголттой бай байгаа. Таны бас өргөн барьсан хуультай ерөнхийдөө агуулга ижил гэж бас ойлгож болно. Нэгтгээд явахад Засгийн газар буюу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас татгалзах зүйл байхгүй.

Нөгөөтээгүүр шүүхийн зөвшөөрөлгүйгээр гэдэг зүйлүүдийг баривчлах асуудал байгаа. Тэгэхээр бид хэд энэ дээр бас нэг зүйлийг бас тодотгож авч үзэх нь зөв байгаа. Ер нь бас хяналтгүйгээр баривчилж байгаа зүйл байхгүй. Доор хаяж прокурорын хяналттайгаар тодорхой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр баривчилж байгаа.

Хойшлуулиггүй тохиолдол гэдгийг та онц онцгой харж байна. Хойшлуулиггүй тохиолдол гэдэг бол хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр болон эд мөрийн баримтыг устгах, зөвөөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа тохиолдолд хойшлуулиггүй тохиолдол гэж шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилж байгаа юм. Яах вэ зүгээр зарим агуулга нэлээн өргөн гэж бас судлаачид ярьдаг.

Ялангуяа хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах гэдгийг бас яг бодитой бас тогтоосон уу, үгүй юү гэдэг юм уу яг тодорхой яг фактууд бий юү гэдэг дээр эргэлзээтэй байгаа. Өмнөх хуулийг бол нэлээн ахиц авчирсан. Мэдээж 72 цагаар баривчилдгийг 48 цаг болгосон хар баасан гараг гэдэг зүйл байхгүй.

Хоёрдугаарт завдах гэдэг юм уу, ингэхийг, тэгэхийг гэдэг ийм юу гэдэг юм, эргэлзээтэй байдлаар байснуудыг нэлээн үйлдлийг дуусгасан байх тээ. Ялангуяа оргохыг, зайлахыг завдсан, зайлахаар

тийзээ захиалчихсан ч байдаг юм уу ийм тодорхой яг бас нөхцөл байдлуудыг илүү их заасан.

Өнөөдөр бол нөхцөл байдал би яах вэ, сүүлийн жилээс л хариулъя. Оны эхний 3 сарын байдлаар жишээ нь 2022 оны статистикийг ярьчихъя. 22 оны статистикаар 59235 хэргийг шалгасан байгаа юм. Үүнд бол яах вэ энэ нийт гэмт хэргийн 1.3 хувь дээр нь баривчлах цаашилаад таслан сэргийлэх арга хэмжээг авсан байж байгаа. Үүн дээр хэд хэдэн бас эрх зүйн зохицуулалтыг сайжруулж өгч байж бас энэ явдлаас гарах юм байна гэж үзэж байгаа.

Нэгдүгээрт бид хэд бол шүүхийг 24, 7-гоор яг прокурортой адилхан жижгүүрийн прокурор ажиллуулж болж байгаа бол бас шүүх дээр бас жижгүүрийн шүүх ажиллуулах зайлиггүй шаардлага байна.

Хоёрдугаарт бас яг тодорхой хэмжээний хойшлуулиггүй үе буюу газар дээр нь гэмт хэрэг үйлдэж байхад нь баривчилчихаад ирэхэд бас прокурорын хэргийн дугаар өгдөггүй ийм байдал бас байна. Прокурорын ачаалалтай холбоотой асуудал байгаа.

Тэгэхээр энэ прокурорын орон тоо болоод цаашидаа бас энэ хэргийн дугаар өгөх асуудлыг бас цахимаар өгч болох уу, үгүй юү гэдэг асуудлыг бас хуульчлах зайлиггүй шаардлага байна.

Хоёрдугаарт нэн тэргүүнд түрүүн бас Хүний эрхийн комиссын гишүүн Энхболдын хэлж байгаа шиг таслан сэргийлэх арга хэмжээн дундаа цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авахгүй байх асуудлыг бас илүү их тодруулж өгье.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүний асуултад Энхболд гишүүн Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн бас нэмж хариулъя. 7 номерын микрофон.

Б.Энхболд: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хоёрт хууль тогтоомжтой холбоотой асуудлыг Сайнзориг дарга бас нэлээн тодорхой хариуллаа гэж бодож байна. Хойшлуулиггүй ажиллагаа гэдэг бол энэтэй холбоотой практик дээр бас зайлиггүй хийгдэх ийм ажиллагаанууд бол комиссын хяналт шалгалтын явцад бол бас зайлиггүй ийм тохиолдол байхыг үгүйсгэхгүй юм байна лээ.

Гэхдээ тэр хүний амь нас, эд хөрөнгө гэдэг асуудал ялангуяа эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй гэдэг үндэслэлээр бол бас баривчилсан тохиолдлууд бол их өндөр хувьтай байгаа нийт баривчилгааны бол ерөнхийдөө 57.5 хувь нь яг энэ үндэслэлээр яваад байгаа учраас Хүний эрхийн үндэсний комисс энэ хойшлуулиггүй тохиолдол гэдгээ бол илүү нарийвчилж өөр өөрөөр хэрэглэж, тайлбарлах боломжгүй байдлаар хуульчлах ийм саналыг бол өгч байгаа.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яах вэ энэ 2016 онд энэ заалт байхгүйгээр Тэмүүжиний хуульд батлагдчихаад тэгээд соёрхож амжаагүй л буцсан юм л даа. Тэгэхэд бол хамаагүй илүү хүний эрхийн нөхцөл байдал илүү сайжирна л гэж үзэж байсан. Тэгээд харамсалтай нь юм болгоныг барьж хорих, хэлмэгдүүлэх ийм бодлоготой уулаасаа угийн 30-аад онд 30 хэдэн мянган хүн буудаад алчихсан энэ нам бол энэ дээрээ тэгээд л ингээд хатуу байна л даа. Тэгээд Сайнзоригийн ярьж байгаагаар бол заавал хорих гээд л тэгээд шүүхийн тэр жижгүүрийн шүүгч гаргана гээд л үзээд байна шүү дээ. Тэгээд тэр хүмүүсийн чинь тал тал нь хоригдолгүй цаашаа явчихсан байна гэдэг чинь заавал хорих шаардлага байхгүй магадлал нь бас.../минут дуусав./

Б.Энхбаяр: Үг хэлчихлээ. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Та бүгдийн энэ өдрийн мэндийг айлтгая. Монгол Улс 30-аад онд энэ Гэндэн, Дэмидийн хэрэг, баруунтан, зүүнтний хэрэг, Японы тагнуулын хэрэг, хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг гээд баахан иргэдээ ингээд эх орноосоо урвасан урвагч гээд ард түмнээрээ жигшүүлж байгаад энэ Бөмбөгөр ногоон театр дээр хурал хийж байгаад Шар хаданд аваачаад буудчихсан ийм тохиолдол байгаа. Олон мянган иргэнээ. Энэ шарласан хавтаст хэргийн бэх нь хатаагүй байгаа. Тэгвэл одоо ингээд бид нар чинь хэдэн сая хүнтэй билээ? 3-хан сая хүнтэй ард түмэн тэтгэврийн насны хүн тэн дотор хэд байна, хөдөлмөрийн чадваргүй хүн хэд байна, насанд хүргээгүй хүүхэд хэд байна, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэд байна, асрамжид байдаг хүмүүс хэд байна? Дээр нь ажилгүй иргэн хэд байна, нийгмийн идэвхтэй ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн чинь хэд нь гадаадад хөдөлмөр эрхлэх гээд явчихсан байна.

Тэгээд нийгмийн идэвхтэй энэ хэдэн хэсэг дээрээ ингээд нэг ЖДУ, концесс, Боловсролын сан, Хөгжлийн банк, Нүүрсний гээд нэг баахан бүлэг хулгайч нар гаргаж ирээд тэгээд ингээд нийгмээр нь түрүүлээд яллуулдгийг Шүүхийн ерөнхий зөвлөл юу гэж үзэж байна? Энэ хулгайч юм байгаа юм гээд ингээд нийгэмд гарч ирээд зарлачихдаг. Тэгээд нийгмээр жигшүүлээд.

Энэ 2.8 сая социал медиа хэрэглэгчийн 1.1 сая нь хуурамч хаяг нэг ёсондоо тролл гэсэн үг. 49 мянган бүртгэлгүй утас, гадаад сервер дээрх тролл. Гадаадын дугаартай утас гэсэн үг. Энэ хүмүүс чинь ингээд энэ троллууд чинь хэлэх, хэлэхгүйгээр доромжилж, доромжилж, доромжилж, нийгмээр жигшүүлж, жигшүүлж байгаа додоо та нар яаж шийдэхийг чинь шүүхийг та нар яаж шийдэхийг чинь харна, эд нар ялт ч үгүй ингээд гэмт хэрэгтний шүүхээр ингээд зарлачихаж болдог юм уу? Тэгээд Улаанбаатар чуулгад шүүх хурлыг нь хийгээд тэгээд нэг худаг руугаа ачих уу? Ийм байдлаар хийж байгаа нөгөө

шүүхийн хараат бус байдалд нөлөөлөхгүй байна уу? Та нар энэ дээр нэг юм хэлээч. Бид нар чинь нөгөө гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно гээд байдаг. Чи хулгайчийн хүүхэд учраас ингээд хулгайлсан мөнгөөрөө бид нарт тийм юм авч өг гээд ингээд үр хүүхэд ингээд ах дүүсээр нь ингээд шүүхээс өмнө ингээд шийдээд байж болох юм уу, ийм юм ингэж явж болох юм уу, шөнийн баривчилгаа явж болох юм уу, шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад байж болох юм уу гэж асуух гээд байгаа юм.

Хоёр дахь нь нөгөө Чимгээ, Содномдаржаа хоёр яасан бэ? Гарчихсан уу? Тэгээд энэ хүмүүс чинь буруугүй болчихсон уу? Энэ чинь Зориг агсныг амь нас энэ санаатайгаар егүүтгэсэн ийм ноцтой гэмт хэрэгт ороод шоронд ороогүй билүү? Тэгээд би энэ тайлан дээрээс хараад байна л даа. Хяналт шинжилгээгээр 23 байгууллагын хүрээнд гүйцэтгээд 1954 хүнээс асуумж аваад, 49 ажилтантай уулзаад үзэхэд 2016, 2023 он оны 3 сар хүртэлх хугацаанд эрүү шүүлтээс ангид байх 225, хууль бусаар баривчлах 63, хууль бусаар цагдан хорих 321 буюу нийт 609 тохиолдол гарсан байна шүү дээ. Ингэж болох юм уу бид нар? Ийм байдлаар цаашидаа ингээд иргэдийгээ ингээд яллаад, айлгаад, дарамтлаад, шүүгээд ингээд байж болох юм уу? Энэ цаашидаа Монгол Улсын төрийн дархлаанд нөлөөлөхгүй юу? Энэ цаашидаа Монгол төрийн оршин байх энэ асуудалд нөлөөлөхгүй юу? Энэ цаашаа энэ өнгөт хувьсгалын суурь болох.../минут дуусав./

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүний эхний асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Баасанжав 1 номерын микрофонд хариулъя. Хоёр дахь асуултад Улсын ерөнхий прокурорын орлогч бэлдэж байгаарай.

Н.Баасанжав: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Баасанжав гишүүн. Асуултад хариулъя. Шүүхийн тухай хуулийн 73 дугаар зүйл буюу шүүгчийн хараат бус байдлыг, ашиг сонирхлыг хамгаалах гэсэн энэ зохицуулалтын хүрээнд бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчээс гаргасан нөлөөллийн мэдүүлгийг нэн даруй горимоор бид нар хэлэлцэж зохих арга хэмжээг авч байгаа. Энэ хуулийн зохицуулалтын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлд нөлөөллийн мэдүүлгийг хэлэлцэн шийдвэрлэхээс гадна нөлөөллийн мэдүүлэг гаргаагүй ч аливаа бусад хэлбэрээр шүүхийн бие даасан болон шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулах гэж оролдсон, нөлөөлөх гэж оролдсон аливаа үйлдлүүдийг таслан зогсоох, хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ буюу тэр дотор хүсэлт гаргах, гомдол гаргах, нэхэмжлэл гаргах, мэдэгдэл гаргах зэрэг арга хэрэгслүүд дээр бид нар шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах арга хэмжээ авахаар хуулийн зохицуулалтын хүрээнд ажиллаж байгаа.

Энэ хүрээнд шүүгчдээс гаргасан нөлөөллийн мэдүүлгийг эхний ээлжид бид нэн яаралтай авч хэлэлцэж байна. Түүний дагуу цагдаагийн байгууллагад тухайн шүүгчид нөлөөлөх гэж оролдсон тэр арга хэрэгслүүдийг судлаад, тэрийг мөрдөөд, хянаад, шалгаад, зохих арга хэмжээ авхуулахаар ханддаг. Нэмээд бид нар энэ сошиал медиа буюу элдэв account-тай тэр нь бол үнэн зөв биш биш зарим тохиолдолд, эсвэл редакцтай, редакцгүй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээр гаргасан, энэ олон нийтийн сүлжээнд гаргасан тэр мэдээллүүд дээр бид нар тухайн редакцтай хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тодорхой мэдэгдэл гаргадаг. Мөн тэнд шаардлага хүргүүлдэг. Энэ мэдээллээ устгах түүнийгээ залруулах, уучлалт гуйх, хэрвээ тэр нь тодорхойгүй мөн цагдаад ханддаг. Мөн түүнээс гадна Цахим хөгжлийн яам буюу энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд бол энэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн зарим

тохиолдолд үүнийгээ эргээд тэр зөвшөөрөл өгсөн бол зөвшөөрлөө эргэж хараач, худлаа үнэн, зөв мэдээлэл үнэн зөв байдалтай нийцэхгүй, бодит бус байдалтай нийцэхгүй мэдээлэл гаргаад байгаа бол эрхийг нь цуцлаач гэдэг хүртэл арга хэмжээг бид авах гэж байгаа.

Мөн түүнээс гадна бид нар цахим хуудсаараа дамжуулаад зүгээр мэдэгдлүүдийг бас гаргаж байгаа. Тэр мэдэгдэлдээ ийм бодит бус мэдээлэл гарсан байгаа нь үнэнд нийцэхгүй энэ талаар шалгуулах арга хэмжээ авсан. Эргээд энэ шүүгчид нөлөөлөх гэж оролдсон иргэн түүнд арга хэмжээ авагдсан байгаа шүү гэдэг бас мэдээллүүдийг авч байгаа. Энэ нь бол бас 100 удаа ингээд үүргээ гүйцэтгээд энэ байдал засагдчихсан гэж хэлэхгүй Бид нар энэ дээр үргэлжлүүлээд бас энэ арга хэмжээгээ улам сайжруулах илүү хурдтай байх үр дүнтэй байхад чиглээд ажиллаж байгаа. Манайд хараат бус байдлыг шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах нэгж байна. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүдээс дотроо зохион байгуулалтын хувьд яг шүүгчийн хараат бус байдлыг хариуцсан бас хороо ажиллаж байгаа. Мөн нөгөө талдаа шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбоотой бас хороо бас ингээд ажиллаж байна.

Мөн бас нэг Шүүхийн тухай хуулиар орсон нэг зүйл бол шүүгч нь өөрийнхөө гаргасан шийдвэртэй холбоотой олон нийтэд тухай бүр нь ийм ойлгомжтой байдлаар тойм гаргана гэсэн ийм чиг үүргийг бол хэрэгжүүлж байна. Тэр нь бол процессын болон эцэслэн шийдвэрлэгдсэн шийдвэртэйгээ холбоотой. Энэ бол бас нэлээдгүй үр дүнтэй байгаа гэж харж байгаа. Тухайлбал, энэ прокуророос таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ирүүлчихсэн тохиолдолд цагдан хорих арга хэмжээ авлаа эсвэл түүнийг нь татгалзлаа гэсэн энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой.

Б.Энхбаяр: Хоёр дахь асуултад Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат хариулъя. 9 байна уу, 10 байна уу? 10 Номерын микрофон.

М.Чинбат: Их Хурлын гишүүн Энх-Амгалангийн асуултад Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат хариулъя. Энэ Хүний эрхийн үндэсний комиссоос оруулсан 22 дахь илтгэлтэй холбогдуулж гишүүд асууж байна. Хууль хяналтын байгууллагаас жилд Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дотроос 20 орчим мянган сүүлийн 3 жилийн статистик мэдээллээр бол сүүлийн 3 жилд 20 мянга орчим гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Энэ хэрэгт мөн төдий тооны хүнд хүнийг яллагчаар татаж, үүнийхээ 94-98 орчим хувьд нь бол цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээ авсан байгаа.

8-10 хувьд нь зарим онд бол 10 хувь байна. 8-10 онд нь буюу 1400 орчим хүнд жилд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэжээ. Энэ нь бол хуульд заасан цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийнхээ журмын дагуу прокурорын хяналтын доор мөрдөгч санал гаргаж, прокурор, шүүхэд саналаа хүргүүлж шүүхийн зөвшөөрлийн дагуу цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Үүнээс гадна сэжигтнийг баривчлах ажиллагаа явуулсан байдаг. Сэжигтнийг баривчлах ажиллагаа бол шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүйгээр гэсэн 2 ийм төрөлд энэ үйл ажиллагаа явуулж байгаа. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж байгаа гэдэг нь бол хууль зөрчиж хийгдэж байгаа ажиллагаа биш юм. Энийг бол анхнаас нь бас нийгэмд буруу ойлгуулж өгсөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр.

Яагаад гэвэл шүүхийн зөвшөөрөлгүйгээр буюу хойшлуулиггүй тохиолдолд баривчлах энэ мөрдөгчийн үйл ажиллагаа бол хууль бус гэж ингэж нийгэмд нийтэд мэдээлж ингэж явсан.

Энэ нь бол хууль бус үйл ажиллагаа биш, хуулийн дагуу хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа арга хэмжээ.

Энэ шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилж байгаа энэ тохиолдол бол ямар хэрэг дээр голцуу гараад байна гэхээр хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг буюу хүнийг санаатай алах гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, мөн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, энэ төрлийн гэмт хэргүүдэд бол хүнийг хойшлуулиггүйгээр баривчилж байгаа. Энэ баривчилж байгаа хойшлуулиггүй тохиолдлын сая Сайнзориг дарга ярилаа. Яах аргагүй хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах сэжигтэн ялагдагч оргон зайлах, ул мөрөө эд зүйлээ арилгах, устгах, нуух, үрэгдүүлэх тийм бодит аюул тохиолдсон нөхцөлд бол энийг бол зайлиггүй прокурорын хяналтын доор авч байгаа юм.

Тийм учраас шүүхийн зөвшөөрөлгүй авч энэ явуулж байгаа энэ баривчилж байгаа үйл ажиллагаа бол хуульд заасан яах аргагүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан энэ журмын дагуу явуулж байгаа. Үүнийгээ хуулийг боловсронгуй болгох, шүүхийн хяналтад хэрхэн яаж оруулах вэ гэдэг энэ зохицуулалт бол бас бид эргэж харж үзэх, хуулийг боловсронгуй болгох ийм шаардлага бол зүй ёсоор байгаа юм.

Яах аргагүй энэ 24 цагаар шүүх ажилладаггүйтэй холбоотойгоор хүн баривчилдаг ажлын бус ажлын бус өдөр цагаар баривчилдаг тэгээд баривчилсан хугацаа дуусах энэ зайлиггүй нөхцөлд бол хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд прокурор болон цагдан хорих байрны дарга энэ сулладаг ийм үйл ажиллагаа явагдаж байгаа юм.

Б.Энхбаяр: Тэр Чимгээ, Содномдаржаа 2 юу болсон бэ хэрэг нь яасан бэ гэж Энх-Амгалан гишүүн асуусан. Тэрэнд хариулъя.

М.Чинбат: Өнгөрсөн 7 хоногт Нийслэлийн прокурорын газраас эрүүгийн хэрэгт ялагчаар татагдсан байсан Чимгээ, Содномдаржаа нарын үйлдэл холбогдлыг прокурорын тогтоолоор хүчингүй болгосон, хэрэгсэхгүй болгосон байгаа. Үндсэн.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гүйцээгээд хариулчихъя. 10 номерын микрофон. Сая микрофон хаагдаад таны яриа.

М.Чинбат: Тийм эрүүгийн хэрэг дээр Зоригийн амь насыг хохироосон хэрэг дээр ялагчаар татагдсан Чимгээ, Содномдаржаа нарын үйлдлийг бол Нийслэлийн прокурорын газраас хэрэгсэхгүй болгосон байгаа. Тэгээд үндсэн хэрэгт нь мөрдөн шалгах ажиллагааг ажлын хэсгээс үргэлжлүүлж явуулж байгаа.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Б.Энх-Амгалан: Би Шүүхийн ерөнхий зөвлөлөөс л маш тодорхой асуусан л даа. Энэ яллагдагчтай тогтоосон тогтоолтойгоо танилцаж амжаагүй байхад хавтаст хэрэг зохиол болоод хэвлэл дээр гарчихдаг чинь зөв юм уу, буруу юм уу гэж. Хууль хяналтын байгууллага гарч ирээд хэвлэлийн байгууллага ирээд мэдээлэл хийгээд хэргийн эзэн холбогдогч нарыг ийм хүмүүс ийм хүмүүс байгаа гээд ингээд нийгмээр шүүлгээд байх нь зөв юм уу, буруу юм уу гэж.

Дээр нь энэ асуудлыг шүүх яахыг нь харъя гээд ингээд хуулийн байгууллага чинь мэдээлэл хийгээд байх нь зөв юм уу, буруу юм уу гэж. Энэ чинь шүүхэд нөлөөлж байгаа гэж үзэж байгаа юм уу, үзэхгүй байгаа юм уу? Ийм маш тодорхой юм асуусан шүү дээ. Энэ дээр та нэг хариулаад өгөөч.

Б.Энхбаяр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Баасанжав 1 номерын микрофон.

Н.Баасанжав: Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед эцэслэн шийдвэрлэгдэж байгаа үед шүүгчид аливаа хэлбэрээр хэнээс ч нөлөөлөх нь буруу. Түүнийг шүүгч ч болон тэр Шүүхийн ерөнхий зөвлөл ч гэсэн буруу гэж үзэж байгаа. Тийм учраас тэр нөлөөлөх гэж оролдож байгаа оролдлого бүрийг таслан зогсоох, мөн тэр оролдлогын тэр нөлөөлөх гэж оролдсон арга хэмжээ болгонд нь бид нар зохих арга хэмжээ авахаар ажиллаж байгаа. Тэгэхээр энэ тал дээр тантай санал нэг байна.

Энэ оролдлого өөрөө хийж байгаа нь аливаа оролдлого нь бүгдээрээ болон байж болохгүй тэр нь. Тийм учраас энэ дээр харин шүүгчээс нөлөөллийн мэдүүлэг ирүүлэхэд нэг ажиллагаа хийдэг, мөн илүү нөлөөллийн мэдүүлгийг хүлээлгүйгээр сошиал орчинд юм уу, аливаа байдлаар жагсах цуглах шүүхийн.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Сандаг-Очир: Бид ч ер нь их мэдээлэл багатай байдаг юм байна. Тэгээд энэ Хүний эрхийн үндэсний комиссын энэ тайлан, илтгэл энэ жил анх удаа ингээд Байнгын хороон дээр орж ирээд олон нийтэд нээлттэй болоод ингэж хэлэлцэгдэж байгаа нь их талархууштай байх шиг байна. Ингээгүй бол ер нь тэгээд нэг тайлан гаргадаг ирүүлдэг, сонссон болоод өнгөрөөд л байдаг ийм л байдлаар явж ирсэн. Тэгээд энэ жил ингээд цаашидаа энийг ер нь улам боловсронгуй болгож, мэдээллийг ер нь олон нийтэд өгөх асуудал их чухал юм байна. Хүний эрхтэй холбоотой асуудлаараа. Энэ 20-22 онуудад нийтдээ 2674 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан. Үүнээс 1079 буюу 40.3 хувийг нь шүүх, прокурор баривчлах байрны даргын шийдвэрээр сулласан байна. 40 хувийг нь суллагчид байсан байна.

Тэгэхээр мөрдөн байцаагчийн тэр хойшлуулигүй ажиллагаа гэж

үндэслэлээр гаргаж ирж баривчилсан шийдвэрийг нь цуцалж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ 40 хувь нь гэхэд хойшлуулшгүй ажиллагааны үндэслэл нь тогтоогдохгүй байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр мөрдөн байцаагч нарын энэ хойшлуулшгүй гэдгээ ер нь юу гэж ойлгож байна? Энэ их том үүд хаалга, энэ их том ийм уут сав байдаг юм байна. Тэгэхээр энэ Сайнзориг дарга та энэ хуулийн бодлого, энэ хуульдаа хойшлуулшгүй ажиллагаа гэдэг нэрийн дор хавтгайруулж юуг ч хамаагүй хийж, хүний халдашгүй байх эрхэд халдаж байгаа энэ тоо баримтуудаа та бүхэн хараарай. Арай л хэтэрхий байна шүү дээ. Тэгээд л ерөөсөө хойшлуулшгүй ажиллагаа нэрийн доор та нар хар л даа. Энэ бүртгэлгүй жагсаал, цуглаан зохион байгуулж, цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй, биед нь халдсан, албан тушаалаа урвуулан ашигласан, эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан, нүүрсэн яндан хулгайлсан энэ асуудлуудыг заавал ингээж зөвшөөрөлгүйгээр баривчлаад ингээд шалгах асуудал мөн үү үнэхээр. Сая тэр прокурор ярьж л байх шиг байна, Хүний эрхийн комиссынхон ярьж л байх шиг байна. Зайлишгүй ийм хойшлуулшгүй ажиллагаа байдаг юм байна. Хэргээ нуух, хаах, булзааруулах, баллуурдах гээд. Хүний амь насыг аврах.

Гэхдээ энэ дотор чинь бол заавал баривчлахгүйгээр шалгаж болох ийм асуудлууд саяын миний нэр дэвшсэн асуудлууд байж л байна. Энийгээ та бүхэн цаашидаа энэ хойшлуулшгүй ажиллагаа гэдгээ ер нь маш нарийн болгож маш тодорхой болгохгүй бол энэ нэрийн доор хавтгайруулж, хэнийг ч, хэзээ ч, хэзээ ч энэ тоо баримтаар хараарай. Бүүр нөгөө хар баасан гараг чинь байгаа л юм байна шүү дээр хугацаагаараа. Нийт 20, 21, 22 онд баасан гарагт 20 онд 114, 21 онд 32, 22 онд 38 амралтын өдрөөр гэхэд бараг 288, 232, 214 гээд бүүр тэр дундаа бүүр амралтын өдөр тэгээд бүх нийтийн амрах баярын болон тэмдэгт өдрүүдэд 44, 9, 22 гээд. Ингээд баярын өдрүүдэд

гэр бүлтэйгээ, үр хүүхдүүдтэйгээ баяр тэмдэглээд сууж байхад нь баривчлаад явна гэдэг тухайн хүний эрх, тухайн гэр бүлийн, үр хүүхдүүдийн, эцэг эхчүүдийн яаж хэрхэн тусах юм бол? Тэгээд та бүхэн энэ тоо баримтуудад энэ Хүний эрхийн үндэсний комиссоос гаргаж ирсэн энэ судалгаанууд маш их дүгнэлт хийх цаг болсон юм байна.

Үнэхээр энэ хүний эрхийн асуудал энэ Монгол хүү гэнэ, Мөнх-Эрдэнийг хорилоо цагдлаа л гээд л ингээд л яриад байдаг цаанаа бас асуудал байна шүү. Заавал хорьж цагдахгүйгээр тэр бусад нөхцөлөөр.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сайнзориг дарга хариулъя. 11 номерын микрофон.

П.Сайнзориг: Сандаг-Очир гишүүнтэй санал нэг байна. Бид хэд бас аливаа зүйлийг бас яг өргөс авсан юм шиг бүх зүйлийг сайжруулж чадахгүй байгаа. Алхам алхмаар хууль, эрх зүйн орчныг нь сайжруулж байна. Энийгээ дагаад хандлага, ур чадварыг өөрчлөх, нэмэгдүүлэх асуудал яригдаж байна. Мэдээж энэ хойшлуулшгүй тохиолдол буюу ялангуяа тэр хүний амь нас эрүүл мэндэд хохирол учруулж болишгүй гэдэг ийм өргөн уутыг бас нарийвчлан хуульчлах гэдэг дээр бас санал нэг.

Ер нь аливаа гэмт хэрэг бас амралтын өдөр гардаггүй ч юм уу эсвэл юу гэдэг юм хагас бүтэн сайнд бас гэмт хэрэг гардаггүй гэж хэлж болохгүй. Зайлишгүй хүний амь насыг хохироож байгаа этгээд байх юм бол баривчлаад л явна. Гэр бүлийнхээ орчинд гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд хохирогчийн амь насанд халдах гэж байгаа хүмүүсээ баривчлаад л явна. Энэ өөрөө эргээд нөгөө талдаа бас энэ энэ гэмт хэргийг бас үйлдэж байгаа этгээдийн асуудал боловч нөгөө талдаа бас хохирогчийн эрх ашгийг бид нар бас орхигдуулж ерөөсөө болохгүй. Энэ асуудлаасаа хохирогчийн амь нас цаашилбал амь насаа алдаад ийм тохиолдлууд бас амьдрал дээр цөөнгүй байдаг.

Тэгэхээр бид хэд бас аливаа зүйлийг мэдээж хүний эрхийг хангаж дээрдүүлэх талаас нь авч үзэх ёстой гэдэг дээр тантай 100 хувь санал нэг байгаа. Өнгөрсөн цаг хугацаанд бол гэмт хэргийг юу гэдэг юм шалгаж шийдвэрлэх гэхээсээ илүүтэй урьдчилан сэргийлэх чиглэлдээ бас хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг тэргүүн чиглэл болгож хуульчлах асуудал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийг батлуулах явцад гаргасан. Бид хэд аль болохоор аливаа гэмт хэргийг гаргахгүй байх, үүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ боловсрол зэргийг нэмэгдүүлэх нөгөө талдаа бас хууль сахиулагчдынхаа хандлага, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлдээ анхаарч байгаа.

Цаашидаа бас Засгийн газраас эрүүгийн түрүүн Пүрэвдорж гишүүний асуултад хариулж байсан шиг энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахаас гадна бид нар бас шүүх байгуулах хуультай, зөвшөөрлийн шүүхийн асуудлыг цаашидаа бас шийдвэрлэх бололцоо юу байна гэдгийг судалж байна.

Хоёрдугаарт бас мөрдөх байгууллагуудын асуудлуудыг бас цэгцэлж, ер нь цаашидаа үндэсний мөрдөх албыг байгуулж явах уу, үгүй юү гэдэг асуудал энэнтэйгээ уялдах юм бол Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад юу гэдэг юм, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль тогтоомжийг сайжруулах асуудал иж бүрнээр яригдах ёстой.

Мөн нөгөөтээгүүр хууль сахиулах байгууллагуудын бас үйл ажиллагаатай хүний эрх зөрчсөн гэдэг юм уу ийм дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа явж байгаа боловч энийг нь бас хөндлөнгийн этгээдээр шалгуулдаг буюу магадгүй цагдаагийн байгууллага зарим хууль сахиулах байгууллагын дэргэд яг дотоод хяналт шалгалтаар шийдэгдэж байгаа зарим хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг Хуульчдын холбоо,

Хүний эрхийн үндэсний комисс, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1, 1 төлөөлөл гэсэн ийм 3 хүний бүрэлдэхүүнтэй ийм комиссоос шалган шийдвэрлэдэг. Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой юмыг нь хуулийн байгууллагад шилжүүлэхээс гадна яг энэ ажлын байран дахь дарамт байдаг юм уу, нөлөөллийн энэ үйл ажиллагаа дээр нь бас хяналт шалгалтыг явуулдаг шинэ механизмыг оруулж ирэх асуудлаар бас бид нар бас судалж байна. Тэгээд Цагдаагийн хуулийн бас нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсэг гарчихсан бид хэд бас ажиллаж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Хоёрдугаарт мэдээж сургалтын асуудал байгаа. Сургалтыг бид нар ерөнхийдөө хуулийн үзэл баримтлалыг боловсруулж батлуулсан яам нэгдсэн байдлаар бас сургалтын агуулгаа зөв тодорхойлж өгөхгүйгээс багш болгон өөр өөрийнхөөрөө тайлбарладаг, хууль хэрэглээний асуудал дээр зөрчилдөх, багшийн юу хийсэн байдлаар ханддаг ийм бас хууль сахиулагч нар байдаг юм байна лээ. Бас оюутнууд маань ч гэсэн, сонсогчид маань ч гэсэн ингэж бэлтгэгдэж гарч ирж байгаа. Тэгэхээр бид хэд Улсын Их Хурлаас баталж өгч байгаа хуулиудын яг үзэл санаа болон хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж сургалтын нэгдсэн платформыг бий болгож энэ дээр эрүүгийн болон эрүүгийн процессын болон хууль хэрэглээний бүх хуулиудыг яг нэг агуулгаар бас ойлгож хэрэглэх, хэвшүүлэх энэ ажлыг бас хийх дээр Хууль зүй, дотоод хэргийн яам сургалтын нэгдсэн платформыг бас хийж байна. Одоо бас контент болон дотор нь ямар хичээлийн хөтөлбөрүүд оруулах вэ гэдэг зүйлүүдийг бас эргээд бид нар асуудлыг судлаад бас тодорхой ингээд контентуудыг бэлтгээд удахгүй бас энийг хэрэглээнд оруулна. Тэгээд аль болохоор цагдан хорих, баривчлах биш бас тодорхой түвшиндээ бас зорчих эрхийг нь хязгаарлах байдаг юм уу ийм чиглэлдээ бас анхаарна гэдэг зүйлийг бас

танд хэлье. Тэгээд бас.../минут дуусав./

Б.Энхбаяр: Би нэг хэдэн асуулт асууя. Тэгэхээр халдашгүй чөлөөтэй байх эрхэд хамгийн их халддаг асуудал бол нууц мөрдөн шалгах ажиллагаа буюу гүйцэтгэх ажил байдаг.

Тийм учраас энэ нууц мөрдөн шалгах үйл ажиллагаа хуулийн хүрээнд байх. Тэгж байж бид энэ халдашгүй, чөлөөтэй байх эрхийг илүү баталгаажуулах хэрэгцээ шаардлага үүсэж байгаа. Цагдан хорих буюу хорьж мөрдөн шалгах гэсэн үг. Сонирхол тэгээд юу хөтлөөд байна вэ гэхээр хорьж байгаад тэнд нь гүйцэтгэх ажил хийх, цагдан хорих байранд нь гүйцэтгэх ажил хийх сэдэл нь өөрөө мөрдөх байгууллагуудыг хүнийг илүү их цагдан хорьж байгаад шалгах сэдэл рүү түлхээд байгаа юм.

Тийм учраас цагдан хорьж байгаад тэр цагдан хорих байранд хийх гүйцэтгэх ажлын хүрээ хязгаарыг хумих хэрэгцээ шаардлага байгаа юм биш байгаа гэсэн асуултыг би Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Энхболд гишүүнээс эхлээд асууж байгаа юм. Өөрөөр хэлбэл тэнд үндсэндээ үндэсний аюулгүй байдлын эсрэг буюу тагнуулын байгууллагын харьяаллын хэргийг л үлдээгээд гүйцэтгэх ажил хийхийг нь зөвшөөрөөд бусад энэ ахуйн шинжтэй ер нь хэргүүдийг ер нь болих ёстой юм биш үү гүйцэтгэх ажил хийдэг юм гэсэн ийм нэг асуудал байгаа юм. Энэ дээр Хүний эрхийн үндэсний комисс ямар санал бодолтой байна вэ гэсэн эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь асуулт нь мөн яг энэтэй холбоотой сая Хөгжлийн банкныг шалгах Улсын Их Хурлын түр хорооны тайлан дүгнэлттэй Улсын Их Хурал танилцаад тогтоол гаргасан. Энэ тогтоолын 3 дахь заалт дээр гүйцэтгэх ажилд тавих парламентын хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт

бэлтгэхийг Хууль зүйн байнгын хороонд даалгасан байгаа. Энэ чиглэлээр Хууль зүйн байнгын хороо, Засгийн газар холбогдох байгууллагатай хамтарч санал бэлтгэн. Энэ хүрээнд Улсын ерөнхий прокурорын орлогчоос асуух гэж байгаа юм. Гишүүд бас асуугаад байна. Энэ одоо дөнгөж шалгаж байгаа хэрэг юм уу эсвэл дөнгөж гүйцэтгэх ажлын мэдээ баримтууд энэ яагаад хэвлэл мэдээллээр түрүүлээд гараад байгаа юм бэ? Хүнийг урьд өдөр нь барилаа гээд л тэгэнгүүт зураг нь гаргаад л, хэвлэлээр шууд цоллоод л энэ чинь гэмт хэрэг шүү дээ.

Тэгээд хуулийн байгууллагынхан өөрсдөө ийм эрүүгийн төлөөлөгч нар хаанаас гаргаад байгаа юм? Хүний дөнгөж шалгаж байгаа хэргийн зураг, мэдээлэл гаргадаг. Хүний гэм буруу яригдаагүй байгаад байгаа шүү дээ. Тэгээд энэ хуулийн байгууллагынхнаас л гараад байгаа шүү дээ. Тэгээд энэ чиглэлээр Улсын ерөнхий прокурор дээр хэрэг үүсгэчихэж байгаа хуулийн байгууллагынханд шалгаж байгаа, тогтоож байгаа ийм нөхцөл байдал байна уу? Та бүхэнд юу дутаж байна? Би сүүлийн үед энэ мөрдөх байгууллагууд прокурорын хяналтаас гарах асуудал арай хэтрээд байна гэж бодож байгаа. Арай хэтэрч байна. Ингээд энэ хулгайчтай гээд ингээд Авилагтай тэмцэх газар хулгайчтай ч гээгүй л дээ олон түмэн шахаж байна гээд нэр зарлачхаж байгаа. Би бол Улсын прокуророос зөвшөөрөл аваагүй гэж ойлгосон шүү. Хуульд зааснаар мөрдөх байгууллагууд прокурорын байгууллагаас зөвшөөрсөн хүрээнд хэвлэл, мэдээллээр мэдээлэл өгөх үүрэгтэй байгаа, эрхтэй. Прокуророос зөвшөөрөл авахгүйгээр ингээд олон нийтэд нэр ус зарладаг ийм юм байна уу, үгүй юү? Энэ чинь арай давраад байгаа юм биш үү? Энэ чинь өөрөө гэмт хэрэг шүү дээ. Тэгээд намайг хэн гэх юм, нохой хүн саах юм гэдэг рүүгээ орж байгаа юм биш биз дээ арай. Нөгөө хуулийн мафи чинь дахиад мөрдөх байгууллагуудаа одоо ингэж данхайж эхэлж байгаа юм биш биз дээ? Тэгэхээр прокурор энэ дээр ямар дүгнэлт хийж

байна? Ийм мөрдөн шалгах үйл ажиллагааны эсрэг үйлдсэн энэ тусгай субъектийн үйлдэж байгаа хэргүүдийг шалгаж байгаа зүйл байна уу, үгүй юү гэсэн хоёр дахь асуулт байгаа юм.

Гурав дахь асуудал тодорхой асуулт асууна. Сая Сайнзориг дарга хэлж байна Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг бас боловсронгуй болгоно гэдэг дээр бас бодож байгаа санал. Энэ Сайнзориг дарга энэ гүйцэтгэх ажил хийж байгаа юмнуудыг зорилгоор нь салгамаар байна. Жишээлбэл, Авлигатай тэмцэх газар цагдаа 2 тодорхой гэмт хэрэг илрүүлэх зорилгоор хийж байгаа нууц мөрдөн шалгах ажиллагаа. Өөрийнх нь цуглуулсан баримтууд бол гэмт хэрэгтэй холбоотой учраас шүүх дээр нотлох баримтаар үнэлэгдэх, үнэлэгдэхгүй тухай асуудал.

Тийм учраас энэ ажлууд прокурорын бүрэн хяналтад хийгдэж байх ёстой. Харин тагнуулын байгууллагын хувьд зорилго нь өөр шүү дээ. Энэ чинь үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хийгдэж байгаа ажил дээр бол прокурорын хяналт гээд л ингээд л юм болгон дээр тийм байх болохгүй ер нь бол. Энэ хязгаарлалт нь өөр байдаг байхгүй юу энэ. Аль ч улсад ер нь тагнуулынхаа байгууллагын үйл ажиллагааг хүрээ хязгаар тавиад хязгаарлаад байдаг зүйл байдаггүй байхгүй юу. Нэг уутанд ингээд гүйцэтгэх ажлын хууль гээд хэлчихээр наад шүүх дээр нотлох баримт цуглардаг, гэмт хэрэг шалгадаг, Авлигатай тэмцэх газар, цагдаа 2 чинь тагнуулын араар гэх юм уу даа тэр юунд яагаад энэ прокурорын хяналтаас гараад байна шүү дээ.

Тийм учраас энэ зааг, ялгааг нь, энэ онцлогоор нь ер нь хуульчлах хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юү гэсэн ийм зүйлийг Сайнзориг даргаас асуух гэж байгаа юм.

Дөрөв дэх асуулт нь би тодорхой нэг асууя. Сая Хөгжлийн банкны би бас энэ түр хороог ахалсны хувьд энэ шүүх

хурлыг бас шууд явж байгааг үзээд байгаа юм. Их Хурлын гишүүн Алтанхуяг нэг ийм зүйл ярьсан байна өчигдөр юм уу, өчигдөр уржигдар. Манай гэр бүлийн хүн дээр гүйцэтгэх ажил хийсэн байна гэж. Эхнэр дээр нь.

Тэгэхээр халдашгүй чөлөөтэй байх эрх гэдэг Улсын Их Хурлын гишүүний хувьд бол гэр орон, захидал харилцаа, утсан харилцаа, албан өрөө, унаа гэсэн энэ объектууд дээр гүйцэтгэх ажил нэвтрэхгүй объектууд байгаа. Тэгэхээр эхнэр дээр нь хийж байна гэдэг чинь ер нь тэгэхдээ эхнэр дээр нь хийж байсан зорилго нь болохоор 10 жилийн өмнөх Хөгжлийн банкны юмтай холбоотойгоор эхнэр дээр нь гэж тайлбарлаж байгаа юм. Бас өөрийнх нь хэлж байгаагаар шүү. Шүүх хурал дээр хэлсэн үгээр. Энэ хэрэг дээрээ шууд Алтанхуяг гишүүнийг шалгаж байгаа хэрэг шүү дээ. Эхнэр дээр нь гэдэг нэрээр тэгээд. Энэ ямар ч энгийн ухамсраар бодоход тэр эхнэрээс нь Хөгжлийн банкны 10 жилийн өмнөх юм ярьж байна уу, үгүй юү гээд хийгээд байдаг тэгээд гэр оронд нь болдог юм уу ингэж? Өөрийг нь шалгаагүй, эхнэрийг нь шалгаж байгаа тэгсэн чинь харин нөхөр нь хажуугаар ороод юм яриад байсан байна лээ гэх гэж байгаа юм уу? Тэгээд тэрийгээ шүүх дээр нотлох баримт болгож байгаад хусах гэж байгаа юм уу? Энэ хүрээ, хязгаар юу болж байна? Энэ халдашгүй чөлөөтэй байх эрх дээр чинь ер нь ямар ч цензур байхгүй болчихсон юм уу? Тэгэхээр би энэ асуултыг Авлигатай тэмцэх газраас асууж байгаа юм. Энэ хууль ном үйлчилж байна уу, үйлчлэхгүй байна уу? Эсвэл тусгай субъектийн асуудлыг ер нь Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба чинь татан буугдчихсан юм чинь бид нар бол ер нь хэнд ч хянагдахгүй, бид нарыг ер нь хянадаг байгууллага байхгүй болчихсон гэж бодоод байгаа юм биш биз дээ? Хуулийн хүрээ рамаас гарч байгаа юм биш биз дээ гэсэн ийм хэд хэдэн асуулт байна.

Эхлээд Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Энхболд 7 номерын микрофон хариулъя.

Б.Энхболд: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Халдашгүй чөлөөтэй байхтай холбоотой яах аргагүй хөндөгдөж байгаа асуудал энэ нууц мөрдөн шалгах ажиллагаа. Тэгэхээр Монгол Улс нэгдэж орсон иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад халдашгүй чөлөөтэй байх эрхийг ганцхан хуулиар хязгаарлана гэсэн ийм маш тодорхой ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр өнөөдөр нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг юм уу энэ холбоотой асуудлуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зохих эсэхийг нь хуульчилсан боловч яг тэрийг нарийвчлан зохицуулсан харилцаануудыг бол дандаа холбогдох байгууллагын дарга, бусад баталсан тушаал шийдвэр, журмаар бол хэрэгжүүлээд байгаа нь энэ бол өөрөө хэт өргөн агуулгатай эрх хэмжээг бол шүүхийн бус субъектүүдэд олгожээ гэдэг ийм дүгнэлтэд Хүний эрхийн үндэсний комисс бол хүрч байгаа. Тэгэхээр цаашдаа бол энэ цагдан хорих байранд гүйцэтгэх ажил явуулах нууц мөрдөн шалгах ажиллагааны энэ үндэслэл журмуудыг бол хуулиар нэг бүрчлэн, нарийвчлан сайн зохицуулах шаардлагатай гэсэн ийм байр суурьтай байгаа. Энэ ч гэсэн бас таны 4 дэх асуудалтай бас бас холбогдох ийм асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр бол түрүүн хэлээд байдаг хууль бус ажиллагаа дур зорго гэдэг 2 үгийг бол олон улсын хүний эрхийн байгууллагуудаас их ярьдаг. Тэгэхээр тэр дур зорго гэдэг бол тэр хуульд байгаа зүйлийг өөртөө ашигтай байдлаар гэдэг юм уу, өөрөө тайлбарлах маягаар үндэслэл журмуудыг бий болгож эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах энэ эрсдэлийг бол бас дур зорго гэдэг ойлголтод оруулаад байгаа учраас энийг бол хаах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Б.Энхбаяр: Улсын ерөнхий прокурорын ордогч Чинбат 10 биш хэд байна? 10 номерын микрофон.

М.Чинбат: Мөрдөн шалгах ажиллагааны нууц задруулах нь өөрөө эрүүгийн гэмт хэрэг. Тэгээд энэ саяын таны хэлдэгтэй би санал нэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа эхэлж байх үед юм уу, тодорхой эрүүгийн хэргийн талаар мэдээлэл гарсны дараа шалгадаг, баривчилдаг энэ асуудлууд зүгээр амьдрал дээр зүй тогтлоороо нэг их таарчихдаггүй л юм. Ерөнхийдөө бол ийм мэдээлэл гараад байгаа юм. Тэгэхээр энэ прокурорын байгууллагын зүгээс энэ дээр онцгой анхаарч ажилладаг. Ерөөсөө мөрдөн шалгах ажиллагааны явц, мэдээлэл, хэргийн талаар мэдээлэх л юм бол прокурорын зөвшөөрлөөр, зөвшөөрсөн гэж боломжтой гэж үзсэн хэмжээний мэдээллийг л олон нийтэд мөрдөх байгууллага мэдээлэх ёстой. Сая бид бас прокурорын байгууллага энэ онд судалж үзсэн. Мөрдөн байцаах мөрдөн байцаалтын нууц задруулсан энэ байж болзошгүй 10 гаруй тохиолдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаж байгаа. Энд мөрдөх байгууллагууд, Тагнуул, Авлигатай тэмцэх, цагдаагийн байгууллагууд мөрдөх, эрүүгийн хэрэг мөрдөж болох эрхтэй байдаг. Энэ дээр харьяаллын асуудал бас бидний бас анхаарлыг бас татаж байгаа юм. Үндсэндээ энэ цагдаа, тагнуулын байгууллагын хамтарсан ажлын хэсэгч шалгадаг, дагнаж эрүүгийн хэргийг ч шалгаж байгаа. Тэгэхээр тэр эрүүгийн хэргийн зарим мэдээлэл яагаад олон нийтэд ингэж ил тод, бүүр нарийн үйлдэл холбогдолтой нь тодорхой мэдээлэлтэй гараад байгаа энэ асуудлыг энэ үйлдлийг шалгах асуудал нь бас өөрөө төвөгтэй байгаа юм. Ер нь энэ тусгай субьектийн, энэ бол тусгай субьектийн байгууллагаас л гарч байгаа мэдээлэл шүү дээ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хэдийгээр нарийвчилж олж авлаа авлаа гэж үзэхэд энэ бол яг л яг мөрдөх байгууллагын үйл явцтай гарч ирж байгаа мэдээлэл. Тэгэхээр энэ дээр энэ шалгадаг, тогтоодог, энэ харьяалан

шалгах энэ асуудлыг бас авч хэлэлцэх ёстой. Энэ цаг нь бол болсон гэж прокурор үздэг.

Б.Энхбаяр: Сайнзориг дарга хариулъя 11 номерын микрофон.

П.Сайнзориг: Асуултад хариулъя. Ерөнхийдөө үндэсний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр тагнуулын үйл ажиллагаа хийх, тодорхой гэмт хэрэг, зөрчилтэйг таслан зогсоох, илрүүлэх энэ үйл ажиллагааны нууц мөрдөн шалгах ажиллагааг нэг хуулиар буюу Гүйцэтгэх ажлын хуулиар холилдож явж байгааг бол зааглах цаг нь болсон гэдэгтэй тантай санал нэг байна. Энэ үйл ажиллагаа үндсэндээ бас тодорхой түвшинд эхлэлийг 17 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нэлээн оруулахыг хичээсэн байдаг. Тэгэхдээ бид хэд бас тодорхой хэмжээний энэ дээр дутагдалтай зүйл бий. Эргээд энийг нэлээн тийм сайн процессжуулж өгөх асуудал байгаа. Ерөнхий зарчмуудыг тогтоож өгсөн боловч түрүүн бас Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Энхболдын хэлж байгаагаар бас тодорхой хэмжээний байгууллагын даргын шийдвэрээр батлагдаж байгаа дүрэм, журмын хэмжээнд байдаг. Эргээд энэ дүрэм, журмууд бас нийтлэг байдлаараа бас тийм нууцлаг гэдэг юм уу бас яг хуульчид бас тэр болгон олж үзэх хязгаарлалттай, дээрээс нь энийг нь хязгаарлалттай байгаа учраас бас энэ үйл ажил дүрэм, журмаас хуульд нийцэж байгаа эсэх асуудал дээр бас дүгнэлт өгөх гэдэг юм уу, бас тодорхой гомдол, мэдээлэл гаргахад бас ийм хязгаарлалттай зүйлүүд байна.

Тэгэхээр бид хэд энэ асуудлыг бас яг хуульчлан сайжруулах чиглэлдээ бас онцгой анхаарах ёстой гэдэг зүйл дээр тантай санал нэг байна. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар бол ажлын хэсэг гарсан. Бид бас тодорхой хэмжээнд бас суурь судалгаануудыг бас хийхээр бас төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ хүрээндээ бас Мөрдөх албаны

тухай хууль болон Гүйцэтгэх ажлын тухай хуулиудыг бас хамтад нь, цугт нь боловсруулж бас өргөн барих ажлыг бас намрын чуулганаар оруулна гэсэн ийм төлөвлөгөөтэйгөөр Хууль зүй, дотоод хэргийн яам ажиллаж байгаа гэдэг бас зүйлийг бас танд хэлье.

Б.Энхбаяр: Дөрөв дэх асуулт дээр Авилагтай тэмцэх албаны Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар. Та тэр цаана нь 8 номерын микрофон дээр суучих. 8 номерын микрофон дээр хариулъя.

Ч.Жаргалбаатар: Асуултад хариулъя. Тэгээд миний хувьд бол гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаа хариуцсан тухайн ажлыг эрхлэх эрх бүхий албан тушаалтан биш учраас би энэ дээр тайлбар хэлэх боломжгүй байна. Гүйцэтгэх ажил болон нууц мөрдөн шалгах ажиллагаанд зохих ёсны зөвшөөрлийг олгож байгаа эрх бүхий албан тушаалтнуудаас энэ ажиллагааг явуулдаг, явуулж байгаа, хэрэгжүүлж байгаа албан тушаалтнуудаас энэ талаар мэдээлэл авах нь зүйтэй байх. Хэрэг нь өнөөдөр хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа энэ хэрэг дээр тухайн хүн ямар мэдээ баримтад үндэслээд энэ мэдээлэл хийснийг хэлж мэдэхгүй байна. Энэ нь үнэхээр нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бол тухайн хүнд өөрт нь баримтуудыг нь танилцуулдаг, хууль бусаар явагдсан бол хүчингүй болгох байх. Тухайн баримтыг нотлох баримтаас хасах хүсэлтээ гаргах ёстой. Ийм процессууд бол зүгээр ил явагдаж байгаа шүүх хуралдааны явцад харагдаагүй учраас би энийг зүгээр тухайн хүний таамаг байсан юм болов уу гэж зүгээр хувь хүний хувьд дүгнэснээ хэлье.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо халдашгүй чөлөөтэй байх эрхийн хэрэгжилттэй холбоотой Хүний эрхийн үндэсний комиссын тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө

үү. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн үг хэлье.

Б.Энх-Амгалан: Хүний эрхийн үндэсний комиссын судалгаанд хамрагдсан шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан 864 сэжигтний асуудал хууль бус, дур мэдэн саатуулах үйлдэл бөгөөд гарцаагүй хүний эрхийн зөрчил мөн гэдэг ийм дүгнэлт байна. Би ном дээрээс уншиж байгаа шүү. Хоёр дахь нь тайлангаас авч үзэх юм бол эрүү шүүлттэй холбоотой 225, хууль бусаар баривчлахтай холбоотой 63, хууль бусаар цагдан хорихтой холбоотой 321 буюу нийт 609 гомдлын тохиолдол ирүүлсэн байна гэж байна. Энэ маань ингээд хүний эрхийн эрх чөлөөний байдлаарх илтгэл дотор байгаа зүйлийг харахад хүний эрх зөрчигдөж байгаа ийм нөхцөл байдлууд ийм тоо баримтаар гарч ирж байна шүү нөхдүүд ээ.

Би Үндсэн хуулийн заалт уншиж өгье. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд төрөл саданд нь халдааж хэрэглэхийг хориглоно. Гэтэл одоо энэ дээр ингээд Монгол Улсын нийт 3 сая хүн амын хэд нь тэтгэврийн насны билээ, хэд нь хөдөлмөрийн чадваргүй билээ, хэд нь насанд хүрээгүй билээ, хэд нь хөгжлийн бэрхшээлтэй билээ, хэд нь асрамжид байдаг билээ, хэчнээн нь гадаадад хөдөлмөр эрхэлдэг билээ, хэчнээн нь ажилгүй билээ гээд тэгээд ажил хөдөлмөр эрхэлж байгаа нэг нийгмийн идэвхтэй цөөхөн хэсэг дээрээ ингээд хууль зөрчөөд байвал энэ чинь юу болох вэ? Цаашдаа яах вэ?

Ингээд шөнөөр баривчлаад, баяр ёслолын үеэр баривчлаад, шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад, нэгжээд байвал юу болох юм бэ? Хууль шүүхийн өмнө бүгд тэгш эрхтэй гэдэг энэ зарчим чинь юу болох вэ? Тэгээд энэ яллагдагчаар тогтоогдсон тогтоолтойгоо бараг танилцаж амжаагүй байхад энэ хавтаст хэрэг чинь

тэр чигээрээ зохиол болоод хэвлэл дээр гарч ирээд тэгээд хуулийн байгууллага энийг чинь гаргачихсан учраас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хэвлэлийн бага хурал хийчихсэн учраас ард түмэн энийг чинь бол гэмт хэрэгтэн л гэж харж байна шүү дээ. Тэгээд нийгмээр яллуулж яллуулж, баахан тороолдож тороолдож, би хэлээд байна шүү дээ 1.1 сая хуурамч хаяг байгаа. 49 мянган бүртгэлгүй дугаар байгаа. Гадаад сервер дээрээс халддаг халдлага байгаа. Тэгээд ингэж нийгмээр баахан яллуулж яллуулж яллуулчаад тэгээд одоо яахыг шүүхээс шүүх яахыг нь харна гэдэг чинь шүүхэд нөлөөлж байгаа хэрэг биш үү хөндлөнгөөс? Тэгээд хууль хяналтын байгууллагын цаг гэж авчхаад, тэр цаг дээр ингээд гэмт хэрэг яриад байж болдог юм уу? Шалгаж байгаа хэрэгээ яриад байж болдог юм уу? Энэ маань өөрөө бид нар нөгөө жоомоо алахдаа гэрээ шатаана гэдэг шиг гэмт хэрэгтэнтэй тэмцэх гэж байгаад энэ төрөө татаад унагаачих вий дээ. Төрөөрөө тоглочих вий дээ. Монгол төрийн дархлааг алдагдуулчих вий дээ. Гаднын тусгай албадын болон гаднын зохион байгуулалттай энэ технологийн золиос болчих вий дээ. Болгар улс ингэж ийм байдлаар ингэж явсаар байгаад парламентаа татаж унагаагаад, засгаа татаж унагаагаад 4 удаа сонгууль хийгээд 4 удаа засгаа байгуулах гээд чадахгүй байна шүү дээ. Энэ бид нарт байж байгаа энэ дэлхийн хогийн сав руу орчихсон улс орнуудын чинь гашиун турилага байна шүү. Шүүх, хууль хяналтын байгууллагууд энэ хүний эрхийн асуудал дээр нэлээн онцгой сайн анхаарахгүй бол дуулианаар, дүйвээнээр хандаж болохгүй юм байна шүү гэдгийг би бас энд та бүхэндээ хэлэх гээд байх юм. Энийг цааш нь бол ингэж нийгмээр яллуулдаг явдлаа жоохон болихгүй бол болохгүй нь байна шүү. Энэ бол хүний эрхийн зөрчил, цаашдаа яваад Үндсэн хуулийн зөрчил болох нь байна шүү. Энийг анхаараарай гэж би та бүхэндээ хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. Халдашгүй чөлөөтэй байх

эрхийн сэдвийг хэлэлцэж дууслаа. Гишүүд яах уу түр завсарлах уу, үргэлжлүүлэх үү? Одоо иргэний оролцооны эрх, тэгээд хүний эрхийн хамгаалагч, тэгээд эрүүдэн шүүлт. Гурван эрхийн асуудал байгаа. Одоо хүний эрхийн асуудал ярьж байна бас цайны завсарлагагүй явчихвал бас эрхийн зөрчил болох гээд байна тийм ээ. Тэх, 2 цаг хүртэл. 14 цагаас үргэлжлүүлье. Цайны завсарлага.

Б.Энхбаяр: “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулах сэдвийн талаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Ганбатын Нарантуяа танилцуулна. 6 номерын микрофон өгье.

Г.Нарантуяа: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Монгол Улс дахь хүний эрх чөлөөний төлөв байдлын 22 дахь илтгэлийг хариуцлагатай ажил хэрэгчээр хэлэлцэж байгаа Хууль зүйн байнгын хороо өнөөдөр цаг заваа зарцуулаад, асуудалд санаа зовоод ирсэн оролцогчдод талархал илэрхийлье.

Тэгэхээр “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” гэдэг илтгэлийн хоёрдугаар бүлэгт бол бид бас хүний эрхийн зөрчил жагсаал цуглаантай холбоотой, хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой, эвлэлдэн нэгдэж байгууллага байгуулах эрх чөлөөтэй холбоотой эрх зүйн зохицуулалт дээр бол хүний эрхийн зөрчил ийм байна, нөхцөл байдал ийм байна гэдэг асуудал төвлөрөхөөсөө илүүтэй шийдэл нь ийм байна, хуулиа ингэж сайжруулъя гэдэг энэ өнцгөөс харж, хандахыг хичээж бичсэн юм.

Тэгэхээр иргэний оролцоо гэж ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох боломжийг бүрдүүлэгч хүчин зүйлсийг тодорхойлсон. Энэ нь бол мэдээж эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, тайван хуран чуулах эрх чөлөөний асуудал юм. Тэгэхээр ер нь дэлхийн улс орнуудад, олон улсад ардчилсан ёс, улс төрийн эрх чөлөөний газрын зураг ямар байна вэ гэдэг асуудал бол өнөөдрийн бид нарын ярилцах асуудалтай шууд холбоо

хамааралтай. Тэгэхээр сүүлийн 10 жилд бол дүрвэгсдийн асуудал, террорист халдлага, янз бүрийн улс орнуудын эдийн засгийн хямралаас улбаатай 1990-ээд оны дунд үеэс бол дэлхийн хэмжээнд ардчилсан орон зай хумигдах энэ үйл явц процесс эхэлсэн. КОВИД-19 цар тахал, Украины дайн түүгээр дамжин илэрч байгаа, энүүгээр дамжиж даамжирч байгаа дэлхийн улсуудын хуваагдал, геополитикийн хурцадмал асуудлууд бол дээрээс нь үнийн өсөлт, эдийн засгийн зогсонги байдал бол энэ ардчилсан чөлөөт орон зай хумигдах ийм эрсдэлийг үүсгэж байгаа. Энэ процессыг бас зарим талаар бол хурдасгах ийм шинж тэмдэг ажиглагдаж байна гэж дэлхийн улс орнуудын судалгаанд харагдаж байгаа.

Гэхдээ сүүлийн 2 жил КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор дэлхийн тэргүүлэх их сургуулиуд судалгааны хүрээлэнгүүдийн хийсэн судалгааны үр дүнд бол төлөвшсөн эрх чөлөөт иргэдтэй, тогтвортой ардчилсан улс орнууд урт хугацаандаа хямралыг даван туулах тэр боломж бололцоо илүү байна гэдэг судалгааны үр дүнгүүд харагдаж байгаа.

Тэгэхээр Хүний эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд сүүлийн 2 жил дэлхийн тэргүүлэх их сургуулиудаас хийсэн судалгааны ажлуудыг бас энэ дээр хавсаргасан байгаа. Та бүхэн танилцах боломжтой.

Тэгэхээр ер нь яагаад энэ процесс ажиглагдаж байна вэ гэхээр сорил, хямрал нь энэ улсуудын улс оронд төр иргэний итгэлийг бэхжүүлдэг, төрийн болон зах зээлийн удирдлага зохицуулалтыг сайжруулдаг, инновац шинэ бүтээлийг бий болгож дараагийн хямралыг даван туулах хамтын дархлааг суулгадаг гэдэг утгаараа ардчилсан чөлөөт орон зай бол урт хугацаандаа тогтвортой хөгжлийг бий болгодог гэдэг энэ судалгааны үр дүн бол бас гарсаар байна гэдгийг хэлэх нь зүйтэй.

Дэлхий нийтэд тулгамдаад байгаа уур амьсгалын өөрчлөлт, ундны усны хомсдол, цөмийн зэвсэг зэрэг хүн төрөлхтний оршихуйд заналхийлж байгаа эрсдэлийг дэлхийн улс орнууд яриа хэлэлцээ, хамтын зүтгэл, хэвшмэл бус сэтгэлгээ, технологийн хөгжил, тэдгээрийг нөхцөлдүүлэгч ардчилсан төр, бүтээлч хүнгүйгээр шийдвэрлэх боломжгүй.

Тийм учраас Монгол Монгол Улс ардчилсан засаглалтай, хүмүүс нь улс төрийн эрх чөлөөтэй орших нь үндэсний аюулгүй байдлын баталгаа, иргэний оролцоог дэмжих нь түүний тулгуур. Тэгээд энэ суурийг бэхжүүлэхүйц эрх зүйн орчныг бий болгоход Хүний эрхийн үндэсний комиссын байр суурь, саналыг энэ бүлэгт илэрхийлсэн.

Бүлгийн гол дүгнэлтийг танилцуулъя. 5 үндсэн асуудал байна. Тэгэхээр том зургаар нь харах юм бол хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуулийн зорилго үнэт зүйлсээ Монгол Улс тууштай сахиж байгаа, тууштай, тогтвортой сахиж байгаа. Ардчилсан эрх чөлөөт байдлыг хэмждэг индексээр бол ер нь 5 төрлийн гол индекс байдаг. Дэлхийн хүн амын 10 орчим хувь нь бүрэн эрх чөлөөтэй улс орнуудад амьдарч байгаа гэдэг дүр 6-ийг илэрхийлж байгаа. Монгол Улс бол бүрэн, эсвэл хязгаарлагдмал эрх чөлөөтэй улс орон ямартай чиг эрх чөлөөтэй, үзэл бодлоо илэрхийлдэг, үгээ хэлдэг, тайван хуран чуулдаг ийм боломжтой улс орон гэдэг энэ дүр зураг бол байгаа.

Тэгээд энэ дээр бол эдийн засгийн судалгааны байгууллагаас гаргадаг ардчиллын индекс байна, видэм индекс байна, Фрийдом Хаусын индекс байна, иргэний нийгмийн байгууллагуудын, сивикус индекс байна гээд энэ олон үзүүлэлтүүдээр бол Монгол Улсын улс төрийн эрх чөлөөний том зураг бол ийм байгаад байгаа юм.

Гэхдээ ерөнхий дүр зураг эерэг боловч нийгмийн сэтгэлгээ, эрх зүйн зохицуулалтын ужиг доголдлын зэрэгцээ дээр өгүүлсэн дэлхий нийтэд болоод улс орнуудын хэмжээнд тулгарч байгаа эдийн засаг нийгмийн нөхцөлийн улмаас иргэний оролцооны орон зайд шинэ эрсдэл үүсэж байна гэдэг дүгнэлтийг хийж байна. Монгол Улсын тухайд иргэний оролцооны эрхт улсын 3 чулуу бол тайван хуран чуулах эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, эвлэлдэн нэгдэж байгууллага байгуулах эрх чөлөөний асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг зохицуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль бол иргэдийн идэвхтэй оролцоог дэмжих, ардчилсан төр улсыг төлөвшүүлэхэд түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Гэхдээ эдгээр хуулиуд маань бүгдээрээ тунхаглалын шинж чанартай. Эрх чөлөөний үндсэн үзэл санаа, концепцыг бол бас дутуу суулгасан ийм шинжтэй байгаад байгаа. Тэгэхээр Монгол Улсын ардчилсан улс улс төрийн эрх чөлөөний орон зай бол өнөөдөр бид тунхаглалаасаа балчир хүүхдийн ийм байдлаасаа насанд хүрэх шаардлагатай байна гэж үзсэн учраас бид энэ эрх зүйн зохицуулалтыг санал болгож байгаа юм.

Тэгэхээр ямар шаардлага үүс байна вэ гэхээрээ улс төрийн эрх чөлөөний үндсэн ойлголтуудыг гүйцэд нутагшуулах шаардлагатай байна. Эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал, хууль тогтоомжийн хоорондын зөрчлийг засах хэрэгтэй, цаг үе нийгмийн өөрчлөлтийг тусгаж, энэ хуулиудыг сайжруулах шаардлагатай байна.

Тэгэхээр Хүний эрхийн үндэсний комисс ямар өнцгөөр улс төрийн эрх чөлөөний асуудлыг харж байна вэ гэж. Улс төрийн эрх чөлөө бол ардчилсан улсын маш чухал иргэн төрийн үйл хэрэгт шууд оролцох боломж, бололцоог олгодог. Төр хүндээ ойрхон байх тэр боломж нөхцөлийг бүрдүүлдэг чухал

суваг, үндсэн нөхцөл. Үүний хажуугаар бол улс төрийн эрх чөлөөг хууль ёсны бусад эрх ашиг, ашиг сонирхолтой зохистой тэнцвэрт хэрэгжүүлэх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл журмыг хууль тогтоомжид тодорхой тусгах, эрх чөлөөг дур зоргоос ялгах, эрх чөлөөг мөн чанар зорилгоор нь бус улс төр эдийн засгийн амин сонирхолд урвуулан ашиглах эрсдэлийг бууруулах. Ингэхдээ эрх чөлөөг хязгаарлаж байгаа тэр үйл явцыг хөндлөнгийн шүүхийн болоод хүний эрхийн үндэсний байгууллагын хяналтыг бий болгох. Энэ өнцгөөс харж өөрөөр хэлэх юм бол эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ энэ улс төрийн эрх чөлөө бол олон нийтийн орон зайд хэрэгждэг энэ хязгаарлагддаг эрх, эрх чөлөө. Энэ хязгаар нь ямар байх ёстой юм бэ, тэр баланс зохистой тэнцвэр нь ямар байх ёстой юм бэ гэдэг эрх зүйн шийдлийг бид санал болгохыг хичээсэн.

Эхний асуудал хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал байна. Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөөний ямар байдалтай байна вэ. 22 оны байдлаар 686 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол ажиллаж байгаа. Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлт дотоод, гадаадын судалгааны үр дүнд хангалтгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд, улс төр, эдийн засгийн нөлөөлөл, бас хараат байгааг харуулж байгаа. Хэвлэл мэдээлэл хараат бус олон ургалч дуу хоолойг хянах, эдийн засгийн болон бусад аргаар нөлөөлөх сонирхол их байна. Эргээд эдийн засгийн нөхцөл байдал хэвлэл мэдээллийн байгууллага санхүүгийн чадамжгүй байгаа нь бол энэ нөлөөлөлд бол эмзэг эрсдэлтэй болгож байгаа юм.

Энэ нөхцөл байдал өөрөө хэвлэл мэдээллийн байгууллагуудын эзэмшил хэт төвлөрсөн, үйл ажиллагаа нь ил тод бус байхад хүргэсэн. Хэвлэл мэдээлэлд үл итгэх олон нийтийн хандлагыг нэмэгдүүлж байгаа юм. Хэвлэлийн эрх чөлөө хэлбэрийн хувьд оришиж байгаа боловч хараат бус, хариуцлагатай, мэргэжлийн сэтгэл сэтгүүл зүй мөн

чанарын хувьд бэхжээгүй байна гэж дүгнэж байна.

Тэгэхээр шийдэл нь ямар байх юм бэ гэхээрээ Хүний эрхийн үндэсний комисс энэ илтгэлийн 580 дугаар хуудсанд бол Хэвлэлийн эрх чөлөөний загвар хуулийн төслийг боловсруулж хавсаргасан байгаа. Тэгэхдээ 1 зүйлийг анхаарах хэрэгтэй. Энэ бол Хүний эрхийн үндэсний комисс хууль боловсруулагч биш, хууль санаачлагч биш. Энэ эргээд юу гэдэг юм ардчилсан улсыг бий болгох гэж байгаа бид нар бүгдээрээ л бидний юу гэдэг юм түүгээмэл бүгдийнх нь асуудал зовлон учраас энэ диалогийг цааш нь өрнүүлэхийн тулд бид ийм өнцгөөр харж байна гэдэг ийм бодитой гэх үү, яриа эхлүүлэх ийм эрх зүйн зохицуулалтын хувилбарыг санал болгосон юм.

Энэ дээр хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалт байгаа. Юу гэвэл гэхээр олон ул ургалч байдлыг нь дэмжих ийм зохицуулалтууд байгаа. Хэвлэл мэдээлэл өөрөө ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байх энэ нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн, зохицуулалтуудыг санал болгосон 3 үндсэн асуудал байгаа юм.

Хоёрдугаар асуудал тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөний асуудлаар.

Тэгэхээр цагдаагийн байгууллагын мэдээллээр 20-23 онд нийт 736-гийн удаагийн жагсаал цуглаан зохион байгуулагдсаны 649 нь бол нийслэл Улаанбаатар хотод, 89 нь хөдөө орон нутагт зохион байгуулагдсан байгаа. Төрийн захиргааны байгууллагаас авсан мэдээлэл бол энэ дээр арай зөрүүтэй байгаа. Улаанбаатар хотын хэмжээнд 566 удаагийн жагсаал цуглаан зохион байгуулагджээ гэсэн ийм бүртгэлийг авагдсан байна лээ.

Тэгэхээр жагсаал цуглаан ер нь цахим технологийн хөгжил, олон нийтийн сүлжээний хөгжилтэй холбоотойгоор жагсаал цуглаан

түгээмэл зохион байгуулагдаж байгаа арга хэлбэр, төрөл нь өөрчлөгдөж байгаа. Энэтэй холбоотойгоор бол хүний эрхийн нэлээдгүй зөрчил бүртгэгдсэнийг энэ илтгэл дээр тусгагдсан баримтууд Хүний эрхийн үндэсний комиссын өнгөрсөн 2 жилд олон нийтийн анхаарлыг татсан жагсаал, цуглаанд хийсэн дүгнэлтүүдийг бас хэсэгчлэн оруулсан байгаа. Энэ дээр үзэх боломжтой.

Тэгэхээр тайван жагсаал цуглааныг албадан тараах, оролцогчдыг албадан саатуулах, эрүү, зөрчлийн хэрэгт шалгах зэргээр айдас төрүүлэх, жагсаал цуглааныг сааруулах, намжаах үр дагавартай шууд бус арга хэмжээ авсан зөрчил хэвлэл Хүний эрхийн үндэсний комисст цөөнгүй бүртгэгдсэн. Нотолж зөрчлийн шийдэл оногдуулсан тохиолдол цөөн боловч, тайван жагсааж цуглах эрх чөлөөг эдийн засаг, улс төрийн аминч сонирхолд урвуулан ашиглах эрсдэл байна. Ингээд энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтад бол бид нар 11 үндсэн асуудлаар жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд тусгаж шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзсэн асуудлуудаа бол нэг бүрчлэн тайлбарласан байгаа.

Гуравдугаар асуудал эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй холбоотой асуудал.

23 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар Монгол Улсад нийт 1882 сан, 620 шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд 5, үндэсний хүмүүнлэгийн байгууллага 1, 28964 холбоо үйл ажиллагаа явуулж байна гэсэн бүртгэлтэй байгаа.

Хэвлэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай төстэй нь бол эвлэлдэн нэгдэх нам олон нийтийн байгууллага байгуулах, Монгол Улсын иргэний үндсэн эрх чөлөө хэлбэрийн хувьд бий боловч тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд харьцангуй цөөн, ихэнх нь орон тооны ажилтангүй, төлөвшсөн байгууллагууд

нь 2-4 ажилтантай, төрийн бус байгууллага тогтвортой ажиллах эсэх нь тухайн байгууллагын санхүү, хүний нөөц удирдлагын чадавхаас шууд хамааралтай байгаа. Төрийн бус байгууллагуудын 80 орчим хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа.

Монголын иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагууд цомхон боловч өнгөрсөн хугацаанд ардчилсан ёсыг бэхжүүлэхэд маш үнэ цэнтэй хувь нэмэр оруулж ирсэн. Гэхдээ төрийн бус байгууллагын хувь нэмрийг зохих ёсоор хүлээн зөвшөөрдөг, үйл ажиллагаа, байр суурийг нь ажил хэрэгч, хариуцлагатайгаар сонсдог, хүлээн авдаг, тусгадаг, тусгаагүй эсэхээ эсвэл тайлбарладаг ийм төрийн хандлага төлөвшөөгүй байгаа.

Засгийн газраас боловсруулж 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд нь хуулийн этгээдийг ангилах, үйл ажиллагааг нь зохицуулж, журам, дүгнэлт, эрх зүйн зохицуулалтыг санал болгосон. Энэ бол захиргааны шинжтэй хууль бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний өнцгөөс хандаагүй байна гэж комисс дүгнэсэн.

Тэгэхээр Монгол Улсын иргэний эвлэлдэн нэгдэх үндсэн эрх чөлөөг хангах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төрөөс хараат бус үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн өмнө хариуцлагаа хүлээдэг, ил тод төрийн бус байгууллагуудыг төлөвшүүлэх зарчим зохицуулалт дутагдалтай байна гэж үзсэн. Тэгээд энэ хүрээнд бол 3 үндсэн асуудлаар төрийн бус байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх. Энэ нь бол үүсгэн байгуулах, гишүүнчлэл, засаглалын хараат бус байдлыг нь хангах, үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс зүй бусаар нөлөөлөх, механизмыг төрөөс бүрдүүлэхгүй байх, хоёрдугаар үндсэн асуудал бол төрийн бус байгууллагыг

бүртгэх, татан буулгах, хариуцлага оногдуулах зохицуулалтыг эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний шаардлагад нийцүүлэх, Тэгээд төрийн бус байгууллага Монгол Улсад яг улс орны санхүү, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор төрийн бус байгууллага бие даан иргэдээс санхүүжиж хараат бус санхүүжилт авч үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа учраас төрийн бус байгууллагыг дэмжих санхүүжилтийн зохистой тогтолцоог хараат бус байдалд нь халдахгүйгээр ийм зохистой тогтолцоог бий болгох шаардлагатай байна гэсэн эрх зүйн зохицуулалтыг комисс санал болгож байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Нарантуяа гишүүнд баярлалаа. Иргэний оролцооны эрхийн тайлантай холбоотой асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Нарантуяа гишүүн сая би таны дүгнэлтээс 680 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байгаа юм байна. 500 орчим оо? Энэ хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагууд улс төр, эдийн засгаас хараат байна гэж та сая дүгнэх шиг боллоо. Энэ дүгнэлтийг юунд тулгуурлаж, ямар тооцоо судалгаанд тулгуурлаж, ямар эдийн засгийн тооцоо судалгаанд тулгуурлаж хийсэн бэ? Бүгд тэгж улс төр эдийн засгаас хараат байгаа юм уу? Хэрвээ үнэхээр улс төрөөс хараат байгаа гэж байгаа бол энэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа энэ мэдээллийн мөн чанар, үнэн бодит байдал, хариуцлагатай байдал, ёс зүйтэй байдал ер нь хэр баталгаатай вэ? Дандаа захиалгатай мэдээ мэдээлэл хэрэгслүүд явж байна гэж ойлгож болох уу? Нэг нэгнийгээ намнах гэсэн улс төрийн намуудын, улс төрчдийн захиалгаар мэдээ мэдээллийг тавьдаг, нийтэлдэг ийм байна гэж үзэж болох уу? Хараат байна гэдэг нь. Жинхэнэ төрийн 4 дэх засаглалынхаа мэдээ мэдээллийг

иргэд олон нийтэд түргэн иуурхай, ёс зүйтэй, үнэн бодит мэдээллийг дамжуулах тэр үндсэн чиг үүргээрээ Монгол дахь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ажиллаж чадаж байна уу, үгүй юу? Таны энэ дүгнэлт бас нэлээн эргэлзээ төрүүлэхээр ийм дүгнэлт байна л даа. Тэгээд бодвол бас нэлээд тооцоо, судалгаатай юман дээр л дүгнэж ингэж хэлж байгаа байлгүй дээ.

Ер нь энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудын санхүү ер нь, төсөв санхүүгийн асуудал хэр нээлттэй байдаг юм, шилэн байдаг юм? Төрийн байгууллагууд л шилэн байх ёстой, орлого зарлага бүгд ил тод нээлттэй байх ёстой гээд байдаг. Энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудын энэ төсөв, санхүүг нээлттэй болгох асуудлыг ер нь ярьж болох уу, болохгүй юу? Бас энэ хэвлэл мэдээллийн хэрэгслийн ил тод, нээлттэй байх, хараат бус байх, юуны үйл ажиллагаанд нь оролцсон, нөлөөлсөн үйл ажиллагаа болж хувирах уу? Тэрний цаана яагаад гэхээр гол нь энэ Монгол Улсын нийгмийн хөгжлийн зүй тогтлын мэдээ мэдээлэл, төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэл энэ бүх асуудлын чинь цаана энэ хэвлэл мэдээлэл олон нийтийг мэдээллээр хангаж байгаа асуудал зайлшгүй чухал байгаа байхгүй юу. Тэгээд энэ үнэхээр хараатай байгаа бол үнэн бодит мэдээлэл явагдаж байна гэж үзэх үү, үзэхгүй юу? Энэ их чухал дүгнэлт байна. Тэгээд энэ дээр та бүхэн ямар тооцоо, судалгаан дээр энэ дүгнэлт хийсэн хариулж өгөөч.

Б.Энхбаяр: Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Нарантуяа Хариулъя. 6 номерын микрофон.

Г.Нарантуяа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр сүүлийн 3 жилд бол яг хэвлэл мэдээллийн хараат бус байдлын талаар Монгол Улсын нөхцөл байдлыг судалсан 5 судалгааны ажил, олон улсын хэмжээнд бол Хил хязгааргүй сэтгүүлчид гэдэг Францад төвтэй олон улсын байгууллагууд бол жил болгон хэвлэлийн

эрх эрх чөлөөний индексийг гаргаж улсуудад танилцуулдаг.

Тэгэхээр энэ бүх эх сурвалжуудыг Хүний эрхийн үндэсний комисс хянаж үзсэн. Үүнээс гадна бол энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулах ажлын хэсэг комисс дээр бид жил хагас ажиллаж энэ дүгнэлтүүдийг хийсэн юм. Тэгэхээр олон улсын судалгааных нь үр дүнгээс эхэлье.

Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний байдал бол 2021 онд энэ Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын индексээр 5 байраар урагшилсан. Гэхдээ 22 онд бол 20 байраар ухарсан ийм үзүүлэлт гарсан байгаа. Энэ дээр нэг талаасаа бол энэ индексийг боловсруулдаг аргачлал өөрчлөгдсөн. Нэлээн өргөн хүрээтэй асуудалд ханддаг болсон байна лээ. Аргачлал өөрчлөгдөхдөө бол өмнө нь индекс гаргаж байсан энэ шкал гэдэг юм уу, хэмжүүрээ тохируулж өөрчлөх ийм оролдлого хийсэн. Тэгээд үүнээс гадна бол КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор улс орнуудад үүссэн улс төрийн эрх чөлөөний нөхцөл байдал дээр дүн шинжилгээ хийгээд ийм дүгнэлтүүдийг хийсэн байгаа юм. Энэ дээр би чанарын дүгнэлтийг нь та бүхэнд уншиж танилцуулъя товчлоод.

Тэгэхээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил хэт төвлөрсөн, ил тод бус байна. Ихэнх хэвлэл мэдээллийн байгууллага улс төрийн намд харьяалагддаг нь нууц биш. Хэвлэл мэдээллийн салбар, Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбар хоточ нохойн үүрэг гүйцэтгэх боломж улс төрчдийн нөлөөгөөр хязгаарлагдаж байна гэж энэ бол Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын хийсэн дүгнэлт. Энэ дээр энэ байгууллага энэ индексийг гаргахдаа бол тухайн улс орнуудын хэвлэл мэдээллийн салбар, сэтгүүлчидтэй шууд холбогдож, мэдээлэл авч гаргадаг байгаа.

Хоёрдугаар асуудал бол хэвлэл мэдээллийн эзэд хэвлэл мэдээллийн

байгууллагыг улс төрийн сонирхол, эдийн засгийн эрх ашгаа хамгаалах хэрэгсэл болгож байна. Сэтгүүлчдийн цалин бага, ажлын ачаалал их байгаа нь энэ зорилгод үйлчилж, улмаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг алдагдуулж байна.

Гуравдугаар асуудал. Гүтгэх, доромжлох хэргийн талаас илүү нь сэтгүүлч хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг байгаа. Өндөр торгууль, төлбөр нь тэднийг өөрийгөө цензурдэх, хараат бус эрэн сурвалжлах хэвлэл мэдээллийн хөгжлийг хязгаарлахад хүргэж байна. Монголын олон сэтгүүлчид ажилтай нь холбоотой ямар нэгэн байдлаар заналхийлэл, дарамт шахалтад өртсөн хүчирхийллийн хэд хэдэн тохиолдол бүртгэгдсэн гэсэн ийм дүгнэлтийг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага танилцуулсан байгаа.

Энэ дээр нэмээд Монголын хэвлэлийн хүрээлэнгээс бол бас хэд хэдэн судалгааны ажлыг хийсэн нь улс төр, эдийн засгийн хамаарал сэтгүүл зүйн салбарт байгаа учраас нэгдүгээрт сэтгүүл зүй хараат бусаар ажиллаж чадахгүй, ажиллахгүй ийм нөхцөл байдал үүсэж байна.

Нөгөө талаасаа хэвлэлийн салбар бол бас зах зээлийн хуулиар зохицуулагдах ёстой салбар. Хэрэглэгч байж байж хэвлэл мэдээллийн байгууллага ашиг орлого олох боломжтой байж байж тэр хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломж бололцоо бүрдэнэ. Тэгэхээр Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор энэ боломж бололцоо хомс байгаа.

Нөхцөл байдал ийм байгаа гэдэг нь Монгол Улсын хэвлэл мэдээллийн байгууллагаар явж байгаа мэдээлэлд бид итгэх ёсгүй юу гэсэн асуудал бол биш, олон нийтийн итгэл буурч байгааг бол судалгааны дүн харуулж байгаа.

Гэсэн хэдий боловч хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн ёс

зүйтэй, хариуцлагатай ажиллах, олон ургалч дуу хоолойг төлөөлж ажиллах ийм санаачилга бол бас салбарын хүрээнд явж байгаа гэдгийг бол бас Хүний эрхийн үндэсний комисс тэмдэглэн хэлэхийг зорьж байна. Тэгэхээр нэг талаасаа.../минут дуусав./

Б.Энхбаяр: Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор бас оролцож байгаа энэ албан тушаалтныг нэмж танилцуулъя. Ц.Энхбат Хэвлэлийн хүрээлэнгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Ганзориг Хэвлэлийн хүрээлэнгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Боргилмаа Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч, Батхүү Монголын сайтын холбооны ерөнхийлөгч, Нямтайсанжаа Монголын сайтын холбооны Хяналтын зөвлөлийн дарга, Баярбат Монголын телевизүүдийн холбооны тэргүүн гэсэн албан тушаалтанд бас оролцож байгаа юм байна. Тийм учраас бас гишүүд тодорхой энэ албан тушаалтнуудаас тодруулж болно. Сая Сандаг-Очир гишүүний асуултад Хэвлэлийн Хүрээлэнгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Энхбат нэмж хариулах уу? Энхбат байхгүй байна уу? Ганзориг нэмж хариулах уу? Ганзориг хариулъя. Хэдэн номер? 10 номерын микрофон.

Б.Ганзориг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь Монголын хэвлэл мэдээлэл бол юу гэдэг юм, индексээрээ хойшоо ухарсан гэдэгтэй санал нийлж байгаа. Мөн энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль сая нөгөө энэ дээрээ энэ хэвлэл мэдээллийн эздийг тодорхой болгоё, зарлая, олон нийтэд нээлттэй болгоё, хөрөнгө оруулагч нь хэн юм бэ гэдгийг бид нар энэ Сайнзориг дарга сууж байна Засгийн газраас оруулж ирсэн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй асуудал дээр ажлын хэсэг дээр бид нар энийгээ яриад явж байгаа. Энэ бол юу гэдэг юм, горимын санал болоод явж байгаа.

Ер нь хэвлэл мэдээллийн байгууллагууд маань яг үнэнийг хэлэхэд бол юу гэдэг юм, редакцтай сая гишүүний хэлж байгаа таны хэлж байгаа редакцтай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бол ёс зүйгээ бариад ажиллаж байгаа. Энэ дээр нэг юм байгаа. Олон нийтийн сошиал сүлжээ буюу фэйсбүүк, твиттер, цахим хуудаст олон дагагчтай хүмүүсийг бас энэ дээр бас андууруулж бас болохгүй нэгт. Нөгөө талдаа бас харьцуулж болохгүй. Нөгөө талдаа бол юу гэдэг юм, энэ Хил хязгааргүй сэтгүүлчид билүү энэ хэвлэл мэдээллийн байгууллагын судалгаа өөрөө яг манай хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа 3000 сэтгүүлч, 500 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд яг хүрч судалгаа авдаггүй байгаа. Энийг бас албан ёсоор хэлье. Зарим нэг юмандаа юу гэдэг юм, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэлийн хүрээлэн, Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо, Сайтын холбоо гээд энэ салбарын байгууллагуудаа та нөхөд маань бас урьж оролцуулаа, бид нар урихад яваад очно. Бид нар эсвэл өөрсдөө та нарыг урихад та нар маань хүрээд ирдэг байгаач. Тэгээд иймэрхүү хэлэлцүүлэг Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаан ийм чухал чухал юман дээр болохоор нөгөө л хойд талын хар овоохой гэдэг шиг хэвлэл мэдээллийнхэн буруутай гээд. Яг үнэндээ манай салбарт биш яг мөнчгөрөөрөө ажлаа хийгээд явж байгаа, татвараа төлөөд явж байгаа, татвар дээрээс хар бүх юмнууд нь байж байгаа ийм хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бол байгаа. Яах вэ тодорхой хэмжээний тэр улс төрчтэй байгаа шүү дээ Улсын Их Хурлын гишүүн эзэнтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл энд байгаа, улсын сайд, дарга, улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамааралгүй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байгаа. Энийгээ тэр хүмүүс маань бүгд өөрсдөө тэр Авилагтай тэмцэх газарт өгдөг хөрөнгө орлого дээрээ зарлачихсан, улсын бүртгэл дээрээ байж байгаа шүү дээ.

Тийм болохоор юу гэдэг юм Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний тухай энэ

асуудал дээр та нөхөд нь бас жоохон анхааралтай хандаарай бас. Хэтэрхий нэг талыг барьсан яг тооцоо судалгаандаа хүрдэггүй, үнэн манай салбарын цалин пүнлүү нь бага нь үнэн. Тэгэхдээ энийгээ юм л бол улс төрчидтэй аваачиж наадаг ийм асуудал байж болохгүй гэж хэлмээр байна. Тийм, тэр улс төрчидтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тодорхой байдаг шүү. Сандаг-Очир гишүүн өөрөө бас мэдэх байх гэж бодож байна.

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Би мэдэхгүй ээ. Би хэн, хаана, аль телевизийн цаана, аль сайтын цаана ямар улс төрч байдгийг нэг ч мэдэхгүй, би өөрөө тийм хэвлэл мэдээлэл ч байхгүй, нэг ч хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулдаггүй. Харин энэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг цаашидаа ер нь ямар улс төрч нартай гэрээ байгуулсан байна вэ гэдгийг мэдэх тэр бололцоо, боломж харин байдаг юм уу, үгүй юү? Улс төрчид, улс төрийн намуудтай, төрийн байгууллагуудтай нууцлалын гэрээ хийдэг, хаалтын гэрээ хийдэг, хийдэггүйг нь аваачиж улс төрөөр янз бүрийн байдлаар гүтгэдэг ийм юмнууд ил далангүй л байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Хийснийгээ болохоор хамгаалдаг, хийгээгүйг нь болохоор янз бүрийн мэдээ мэдээллээр гөвдөг ийм л байгаа шүү дээ хэвлэл мэдээллүүд дээр. Нууц биш шүү дээ. Тэгэхээр би бас түрүүн асуултдаа асуусан энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудын энэ санхүүгийн тайлан балансаа хэзээ, хэнд, яаж тушаадаг юм, улс төрчид.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч Боргилмаа хариулъя. 8 номерын микрофонд.

З.Боргилмаа: Сайн байцаана уу? Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Миний ажил жоохон буруу зарлагдаад байна. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Хууль, мэргэжлийн ёс зүй хариуцсан дэд

ерөнхийлөгч гэдэг статустай байгаа. Өмнөх хийж байсан хугацааны юугаар зарласан байна шүү. Тэрийг залруулъя.

Хэвлэл мэдээлэл бол яг зах зээл дээр бол нэг тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нь 500 орчим байгаа юм. Дийлэнх нь бол цахим сайт байгаа юм. Өнөөдөр Монголын эдийн засгийн нөхцөл байдал дотоодын нийт бүтээгдэхүүний 40 орчим хувь нь улсын төсвөөс бүрдүүлж байгаа юм. Тэгэхлээр энэ нийт эдийн засагт төрийн оролцоо ийм том байхынхаа хэрээр яг хэвлэл мэдээллийн зах зээл дээр бол гол худалдан авагч нь, ханган нийлүүлэгч нь, харилцагч нь, төр болон төрийн оролцоотой байгууллагууд болчихоод байгаа нь үнэн. Үүнд бол бас нөлөөлсөн зүйл нь цар тахлын жилүүдэд.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гүйцээгээд хариулчихъя. 1 минут. Нэмэлт хариулт бол 1 л минут байдаг дэгтэй.

З.Боргилмаа: Эдийн засаг хүндэрсэнтэй холбогдуулаад бас аж ахуйн нэгжүүд бол хэвлэл мэдээлэлд зар сурталчилгааны орлого гэдэг тийм эх үүсвэр бол бүүр илт хумигдсан. Дээр нь цахим орчинд энэ үнэгүй сошиал дээрх түгээлтийн систем бол хэвлэл мэдээлэл дэх зах зээлийн бусад орлогыг үнэхээр хаасан учраас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ерөнхийдөө бүх л үйлчилгээгээ төрийн байгууллагад, улс төрд худалдаж, борлуулж байгаа нь бол үнэн. Энэ хэрээрээ тухайн байгууллагын сурталчилгаа зөвхөн нэг талын эх үүсвэртэй, нэг эх сурвалжтай мэдээ мэдээллүүд бол агуулга дээр бас давамгайлж байгаа нь ажиглагдаж байгаа.

Нөгөө талаар Сандаг-Очир гишүүний асуусан хэвлэл мэдээлэлд үнэхээр энэ улс төрчдийн захиалга их байна гэдэг нь үнэн үү гэдэг асуулт байсан. Тэрэнд ингээд яг тодорхой судалгаа байхгүй ч гэсэн дөхүүлсхийгээд хариулахад ялангуяа энэ Засгийн газраас бас.../минут дуусав./

Б.Энхбаяр: Би нэг хэдэн асуулт асууя. Нэгдүгээрт бас энэ ер нь энэ Хүний эрхийн үндэсний комиссын итгэлүүд бүхэлдээ бас их дэлгэрэнгүй гарсан юм байна шүү. Бас ажил хэрэгч хандсан байна. Бас холбогдох Хэвлэлийн эрх мэдэл, эрх чөлөөний тухай хуулийн төсөл гээд өөрсдийнхөө бас хувилбарыг санал болгосон байна. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газар энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг боловсруулах, өргөн барих дээр ямар бодлого, ямар үе шаттай явж байна вэ? Талуудын оролцоо, санаа бодлыг хэр хангаж байгаа вэ гэсэн ерөнхий асуулт. Энэ дотор нь мэдээлэгчийн нууцлалын асуудлыг бас энэ төсөлдөө бас хөндсөн байна. Тэгэхээр энэ Пүрэвдорж гишүүн ч хөндөөд байгаа. Сая ч гэсэн хөндөгдөөд энэ хэвлэл мэдээлэл сэтгүүлч нар их зөрчлийн хуулиар ял шийтгэгдээд байна гэдэг асуудал байгаа. Энэ бол хоёр талтай мэдээж. Нэгдүгээрт бол энэ КОВИД, цар тахал бас энэ иргэдийн амыг үдэх ийм санаархал мэдээлэгчийг ялангуяа, эх сурвалжаа хэлчих л гэж байгаа шүү дээ. Хэлүүлэх гэж хуулийн байгууллагыг зэвсэг болгож байгаа ийм зүйл байна уу, үгүй юү?

Нөгөө талдаа сая бас хэлж байна. Засгийн газар Улсын Их Хурал бол Төрийн хэмнэлтийн хууль гаргасан, төрийн байгууллагууд төрийн өмчийн компаниудыг энэ хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийдэг энэ явдлыг хязгаарлачихсан байгаа. Бүүр хуулиар. Ингээд гэрээ хийхгүй болсон. Тэгэхээр энэтэй холбоотойгоор энэ олон 500, 600 хэвлэл мэдээллийн хэрэгсэл чинь бас нэг амьдрах ёстой шүү дээ. Ингээд би хашилтад хэлж байгаа шүү. Ингээд амьдрахын тулд яах вэ нөгөө улс төрчдийг шантаажилдаг, бизнесийг шантаажилдаг ийм байдал байна уу, үгүй юү? Тэгээд түрүүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудал дээр бас их яригдсан. Энэ мөрдөх албануудаас чиг энэ гүйцэтгэх ажлын мэдээлэл гараад байна. Сэтгүүлчдээр дамжиж. Энэ бол

ер нь явж явж сэтгүүлч ял эдэлнэ шүү. Эх сурвалжаа хэлэхгүй байсан ч гэсэн төрийн болон албаны нууц задруулсан гэдгээр шууд ял шийдэгдэнэ. Эрүүгийн гэмт хэрэг юм чинь. Эх сурвалжаа хэлэхгүй байлаа гээд тэр хүн цагаатгахгүй. Төрийн болон албаны нууц ил болсон уу, болсон, хэн болгосон, болгосон. Факт хангалттай. Тэгээд л ял шийдэгдэнэ. Тэгээд энийгээ ер нь хэр мэдэж байна? Хүний зэвсэг болоод л эсвэл шантаажны хэрэгсэл болчихно гэж андуураад байгаа юм биш байгаа. Харин миний анзаарч байгаа бол хуулийн байгууллагынхан их уян хатан хандаад байх шиг байна лээ шүү. Маши олон тохиолдол дээр. Улаан цагаан шууд ял шийтгэгдэхээр хавтаст хэргийн материалаас гаргаад байгаа шүү дээ. Бүүр Улсын Их Хуралд нууцын тэмдэгтээ дарчихсан хавтаст хэргийн материалаас гаргаж байгаа шүү дээ. Энэ шууд улсын нууц задлах гэмт хэрэг шүү дээ. Тэрний эх сурвалж ерөөсөө надгүй, гарсан факт дуусаа, 2-8 жилийн хорих ялтай гэмт хэрэг шүү дээ. Сэтгүүлчид маань энэ ийм аймаар эрсдэлтэй шүү дээ энэ чинь яг. Ийм эрсдэлтэй орчинд дэнжгэнээд явж байна шүү дээ ерөөсөө ингээд. Тэгэхээр энэ дээр Хууль зүйн яам бас энэ нэг талаасаа хэвлэл мэдээллийн энэ эрх чөлөөг хамгаалах, нөгөө талаасаа энэ хуулийн байгууллагынхны нууц, далд аргаар олж авсан мэдээллийг сэтгүүлчээр дамжуулж олон нийтэд гаргадаг, тэгээд сэтгүүлчтэйгээ шантайж хийж мөнгөө хувааж авдаг юм уу, яадаг юм? Хэдэн тэрбумаар нь. Энэ бол шүгэл үлээлт биш. Энэ бол шүгэл үлээлт биш шүү дээ. Хулгайч хийж, шантайж хийж авч байна гэдэг чинь өөрөө авлигынх нь мөнгөнөөс хумсалж байгаа, хуваалцаж байгаа хэрэг байхгүй юу. Энэ чинь авлигач болж байгаа хэрэг шүү дээ өөрөө. Хулгай мөнгө гэдгийг нь мэдсээр байж өөрөө шантаажилж мөнгө авч байна гэдэг энэ бол авлига. Энэ чинь бас гэмт хэрэг шүү дээ дахиад. Тэгэхээр ийм эрх зүйн орчин ийм байгаа факт дээр мэдсээр байж байж ямар дүгнэлт хийж байна Хууль зүй, дотоод хэргийн яам

ямар бодлого барьж байна гэсэн ийм асуулт байна. Сайнзориг дарга 13 номерын микрофон. 11 номерын микрофон.

П.Сайнзориг: Хэвлэлийн эрх чөлөөний асуудал бас Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулан бэхжүүлсэн бас чухал эрх чөлөөний асуудал байгаа. Эргээд энэ төрд хяналт тавих бас үндсэн арга механизмын нэг. Энийг бол бэхжүүлж хараат бусаар ажиллах энэ нөхцөл болзлоо юу гэдэг юм, хууль, эрх зүйн болоод бусад баталгааг бүрдүүлэх чухал байгаа. Энэ хүрээндээ бас хэвлэлийн эрх чөлөө буюу энэ мэдээлэл олж авах, бас олон нийтийн мэдээллээр хангах энэ асуудал дээр бас сэтгүүлчдийн ажиллах орон зайг бас тодорхой хэмжээнд бас хангах үүднээс Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар маш олон мэдээллийг бид нар төрд хуучин, хаалттай, хязгаарлалттай хийсэн мэдээллийг ил тод тавьж байгаа. Мэдээллийг бид нар нь нээлттэй өгөгдөл болгож бас шилэн ажиллагааг зарцуулж байгаа. Энд ч гэсэн сэтгүүлчид маань бас иргэдийг бас тодорхой дүгнэлт хийж, тодорхой шийдэл болон бас засаж, залруулах асуудал дээр дүгнэлт хийсэн ийм сэтгүүл зүйг бас цаашидаа хөгжих болов уу гэсэн үүднээс бас энэ ажиллагааг бид нар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өнгөрсөн хугацаанд дэмжиж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт мэдээж энэ хууль сахиулах байгууллагын тодорхой албан тушаалтнуудаас хэвлэл мэдээллийн байгууллагатай бас тодорхой эрх ашгаар холбогдож байгаа байж болзошгүй байдал байгаа. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын хэвлэл мэдээллийн ажилтнууд бас бид нар, би бас цуглуулж бас тодорхой уулзаж байсан. Бас хүний эрх эрх чөлөө талаас ерөөсөө юу гэдэг юм эцэслэн шийдэгдээгүй хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага түрүүлж өгдөг.

Сүүлийн үед бол бараг хүн амины хэрэг үйлдэгдсэн хэргийн газар дээр сэтгүүлч давхиад оччихсон тохиолдлууд ч бас байсан. Энийг бид нар бас энэ бас хууль сахиулах байгууллагын албан хаагчид бас тодорхой хэлж байгаа. Энэ нөхцөл байдлууд бараг тодорхой түвшиндээ, удирдлагадаа мэдээлэл очоогүй байж байхад хэвлэл мэдээллийн байгууллага хүрдэг энэ асуудал тодорхой түвшинд байгаад байх шиг байгаа юм. Бид хэд бас энийг дотоод хяналт шалгалтын явцад бас Цагдаагийн ерөнхий газар дээр бас шалгуулж үзсэн бас яг бас тогтоогдож байгаа зүйл бас байж өгөхгүй байгаа юм. Тэгээд бас хардах гэдэг юм уу ер нь бид нарын бас урьдчилан сэргийлэх чиглэлдээ бас алба хаагч руугаа хандуулж байгаа зүйл байна гэдэг зүйлийг бас хэлье.

Хоёрдугаарт ер нь Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг боловсруулаад бас сүүлийн 4 жил боловсруулсан. Хүний эрхийн үндэсний комиссоос санал болгож байгаа хууль бол ерөнхийдөө Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан хуулийн төслийг ерөнхийдөө суурилсан байна лээ. Хүн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг юм уу тодорхой зүгээр бас яах вэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль дээр тусаагүй зарим зүйлүүд орох нь оржээ.

Нөгөө талдаа энэ чиглэлийн эрх зүйн орчныг бас олон нийтийн радио телевизийн болон Өргөн нэвтрүүлгийн хууль, Зар сурталчилгааны хууль ч гэдэг юм уу бас иж бүрнээр нь авч үзэх зайлшгүй шаардлага байгаа. Засгийн газраас хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийг зайлшгүй шинэчлэх шаардлага байна. Ингэж байж бас сэтгүүлчдийн бас ажиллах нөхцөл, баталгаа. Энэ нь өөрөө эргээд санхүүжилт болон улс төрч болон төрийн байгууллагаас аливаа нэг цензур, хараат бус байдлаар ажиллахаас гадна редакцын хараат бус байдал, хэвлэл мэдээллийн энэ хэрэгслийн төвлөрлийн асуудлыг саармагжуулах.

Дээрээс нь эздийн ил тод байдлын асуудал бас чухалчилж байгаа. Тэгэхдээ

ерөнхийдөө Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасны дагуу эздийн ил тод байдал аль хэзээ 18 оноос хойш нээлттэй болсон. Энэ өөрөө эргээд хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч нь хэн бэ, үүсгэн байгуулагч нь хэн бэ, эцсийн өмчлөгч нь хэн бэ гэдгийг улсын бүртгэл дээр мэдүүлдэг болсон. Энэ хүрээндээ бас тодорхой зүйлүүд ил тод болсон.

Өнөөдрийн бас яг хэвлэл мэдээллийн энэ салбарт бас тулж байгаа гол асуудал юу вэ гэхээрээ нөгөө ёс зүйн хариуцлагын асуудал. Ёс зүйн хариуцлага нь үндсэндээ soft буюу тодорхой хөшүүрэг, механизм байхгүй учраас иргэд тийшээ ханддаггүй шууд хууль хүчний байгууллагад ханддаг ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр бид хэд бас энэ дээр яг сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг өнөөдрийн явж байгаа Хэвлэл мэдээллийн зөвлөл шиг бас энэ европын загвар байж болно. Хэвлэл мэдээллийн арбитр гэж бас байдаг юм байна лээ, хэвлэл мэдээллийн омбозмэн гээд маш олон ийм загваруудаас Монголд тохирох энэ зүйлүүдийг нь.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Иргэний оролцооны эрхийн тайлантай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Хүний эрхийн комисст хандаж хэлэхэд бас сүүлийн үед эрх барьж байгаа хүчин гэдэг юм уу, төр засаг ер нь хүний эрхийг хааж боосон, үг үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө хорьж, барьж цагддаг гэсэн нэг ийм хандлага мессеж юмнууд нэлээн газар авах шинжтэй болсон. Энэ дээр ер нь бас Хүний эрхийн комисс бас тодорхой байр сууриа илэрхийлж бас дуугарч байх ёстой юм болов уу? Та бүхэн бол яг энэ хүний Үндсэн хуулиар олгогдсон эдлэх ёстой эрхүүдийг яг салбар салбараар нь гаргаад ирсэн байна. Тэгээд өөр өөрсдөд нь дүгнэлтээ хийсэн байна. Тэгээд энэ дүгнэлтүүдийг нэгтгээд үзэхэд ер нь бас хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулах, хүний эрх, эрх чөлөөг

хангах энэ чиглэлээр ер нь бас энэ төр засгаас явуулж байгаа бодлого яг тэгж нийцэж байна уу, нийцэхгүй байна уу? Нийт дүнгээр нь авч үзвэл. Бас нийт дүнгээр нь авч үзэж, дүгнэлт хийх бас олон нийтэд бас нэг танилцуулах ийм хэрэгцээ шаардлага байгаа юм болов уу гэж би хувьдаа үзэж байгаа юм.

Үнэхээр үзэл бодлоо жагсаал цуглаанаа хийх гээд хийснийх нь төлөө хорьж цагддаг болчихоод, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө хорьж цагддаг болчихоод ийм дарангуйлсан ийм нийгэм болчихоод байгаа юм уу, тэр лүү яваад байгаа юм уу, аль эсвэл орох гээд байна уу гэдэг ийм бас олон нийтийн дунд эргэлзээтэй байгаа гэдэг юм уу мэдэхийг хүсээд байгаа энэ мэдэх ёстой эрхийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комисс яг энэ дээр бас дуу хоолой болж, бас тодорхой байр сууриа илэрхийлээч. Би уг нь түрүүнд асууя гэж бодсон бас амжихгүй юм. Энэ 4-хөн минутад. Манай Монгол Улс хүний эрхийн чиглэлээр хаашаагаа явж байна вэ? Ардчилсан улс болж байна уу, тийм дарангуйлсан улс руу явж байна уу гэдэг энэ дүгнэлтийг нь та бүхэн нэг гаргаж хараач. Том утгаар нь. Тэгэхгүй бол хүний эрхийг хааж боосон, жагсааж цугласан хүн болгоныг хорьдог цагддаг, ийм л ойлголтыг төрүүлэх л ийм юм л яваад байна шүү дээ. Ер нь хаа сайгүй, аль ч хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр.

Тэгээд энэ худлаа юмыг гэдэг юм уу мянга дахин ярихаар үнэн болдог гэдэгтэй адилхан энэ мэдээллүүдийг олон дахин давтамжтайгаар явуулбал тэгээд л ийм л нийгэм рүү явж байгаа юм байна гэдэг. Багаасаа авхуулаад том настай хөгшин хүн болгон л ийм л ойлголттой болох нь байна шүү дээ. Тэгээд нөгөө ардчиллын чинь үндсэн зарчим амин сүнс хаа байна? Энэ тал дээр Хүний эрхийн үндэсний комисс яг одоо ямар нэг улс төрөөс хараат бусаар яг бодит дүгнэлтийг хийх ёстой шүү. Бодит дүгнэлтийг. Аль эсвэл нэг шүүх цагдааг нь буруутгаад байдаг, аль эсвэл хэвлэл мэдээллийг нь буруутгаад байдаг, аль

эсвэл төрийн яамнууд бодлогын яамнуудыг нь буруутгаад байдаг. Ингээд асуудлын гол нь хаанаа байгаа юм эсвэл бүх юмнуудыг болохгүй байна гээд хууль руугаа чихдэг. Бас нөгөө талаасаа иргэн хүний үндсэн үүрэг бас хэдийгээр эрхтэй, эрх чөлөөтэй гэж байгаа боловч нөгөө талаараа бас үүргээ хүлээх ёстой, журамт үүргээрээ хүлээх ёстой. Ардчилсан нийгэм чинь өөрөө хүний эрх, үүргийн нэгдэл байх ёстой. Ингэж байж бүрэн утгаараа хэрэгжих байх гэж боддог. Энэ тал дээр бас хараат бусаар ийм дүгнэлт гаргах, дүгнэлт хийх тал дээр Хүний эрхийн үндэсний комиссыг бас бодитой ажиллаасай гэж би хүсэж байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” сэдвийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын тайлантай танилцаж дууслаа.

Одоо Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын талаар 22 дахь илт илтгэлийн “Хүний эрх, хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт” сэдвийн талаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Сангишаравын Дондов танилцуулна. 2 номерын микрофон.

С.Дондов: Өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт оролцож байгаа та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Монгол улс дахь хүний эрхийн эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг олон талыг оролцуулан хэлэлцүүлж байгаа явдалд тун талархаж байна.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль 21 оны 7 сарын 1-нээс үйлчилж эхэлсэн цагаас эхлээд хүний эрхийн хамгаалагчийн шинэ механизм ажиллаж эхэлсэн. Үүнтэй холбогдуулаад хүний эрхийн хамгаалагчийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор комисс 20 аймаг, мөн 6 дүүргийн хүний эрхийн хамгаалагчдыг хамруулсан судалгаа хийж энэ судалгаан дээрээ тулгуурлан хүний эрх хамгаалагчийн өнөөгийн нөхцөл

байдал, хүний эрх хамгаалагчийн эрхийн зөрчлийн хэлбэрүүд, мөн хүний эрхийн хамгаалагчийн цаашидын асуудлын талаар тодорхой дурдсан илтгэлийг бэлдэж Улсын Их Хуралд хүргүүлээд байгаа.

Энэхүү хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын өнөөгийн нөхцөл байдлыг тодруулахдаа бид хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, дүгнэлтүүдийг удирдлага болгосон. Мөн комисст хандаж хүний эрхийн хамгаалагчдын асуудлаар ирсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Мөн дээр дурдсан энэ хүний эрхийн хамгаалагчийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулсан энэ судалгааг удирдлага болгон хийсэн юм. Хүний эрх хамгаалах чиглэлээр ажиллахад хүний эрхийн хамгаалагчид болон хамтран ажиллагсад, түүний эргэн тойронд байгаа хүмүүсийн эрх, эрх чөлөөнд халдаж буй хэлбэр, тэдний эрх, эрх чөлөөнд халдах, хохироох тохиолдлын давтамж, мөн хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл шийдвэрлэлтийг судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 36.19 хувь нь хүний эрх хамгаалагчдын хувьд болон өөрийнх нь эргэн тойронд байгаа хүмүүст ялгаварлан хад гадуурхалт өндөр байна гэсэн ийм судалгаа гарсан байгаа.

Мөн сэтгүүлч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид ялгаварлан гадуурхалтад хамгийн их өртдөг гэсэн ийм дүн гарчээ. Энэ нь тодорхой байгууллага газар нутгийн бүсчлэлээр хязгаарлагдахгүй нийтлэг байгаа явдал бол өнөөдөр Монгол Улсад ялгаварлан гадуурхалтын хэм хэмжээ дээгүүр байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчид хүний эрх хамгаалагчдын эрх халдаж буй байдалд нь эрх мэдэл, албан тушаалаар дарамтлах, үндэслэлгүйгээр эрх зүйн хариуцлага тооцох энэ явдал бол 15.84

хувь байна гэсэн ийм судалгааны дүн гарсан. Энэ бүхэн нь бол төрийн байгууллага эрх бүхий албан тушаалтнаас шүүгч, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр, гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад нөлөөлөх, ятгах, айлган сүрдүүлэх замаар хууль бус шийдвэр гаргуулахыг оролддог байдал хэвээр байна гэж дүгнэсэн байна.

Мөн сүүлийн үед хүний эрхийн хамгаалагчтай холбоотой хэвлэл мэдээлэл болон цахим орчинд хөндөгдөж буй асуудалд баримтжуулалт, дүн шинжилгээ хийж үр дүнг нь тус илтгэлдээ тусгасан болно. Тухайлбал, зарим хүний эрхийн хамгаалагчдын гэм бурууг шүүхээр эцэслэн тогтоогдоогүй байхад нотлогдоогүй үйлдлийн талаар нийгмийн сүлжээгээр мэдээлэх, түгээх, айлган сүрдүүлсэн мэдэгдэл, ярилцлага өгөх зэрэг хүний эрх хамгаалагчийг ялгаварлан гадуурхалтад өртөх нөхцөлийг бүрдүүлж, улмаар эрүүл мэнд, сэтгэл санаа, амь насанд нь аюултай байдал хүртэл бий болгох болзошгүй нөхцөл байдлууд гарсаар байна.

Хүний эрхийн хамгаалагчийн тогтолцоог бэхжүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо хууль сахиулах байгууллагын алба хаагчид болон хүний эрх хамгаалагч иргэн, сэтгүүлч, хуульч, өмгөөлөгч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтан, идэвхтнүүдийн хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад нь тулгамдаж буй асуудлыг тус тусад нь судлан үзэж үнэлэлт, дүгнэлт өгсөн гэж болно. Тухайлбал, судалгаанд оролцогчдоос хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал ямар байгааг тодорхойлоход 23.72 хувь нь муу, маш муу, мөн 54.8 хувь нь дүн дунд зэрэг гэж үнэлсэн байна.

Түүнчлэн хуульч өмгөөлөгчдийн 25 хувь прокурор, прокурорын байгууллагын ажилтны 14.15 хувь, сэтгүүлчдийн 17.24 хувь, үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажилтан идэвхтнүүдийн 15.62 хувь нь

иргэд олон нийтийн шүүмжлэл, буруу таашаа ойлголт нь эрсдэл бодит байдлыг тодорхой байдлаар гуйвуулж, олон нийтэд мэдээлэл өгсөн нь эрсдэл дагуулж байна гэж хэлсэн байна.

Түүнчлэн судалгаанд оролцогчид цахим орчин нийгмийн харилцааны нэг хэсэг болсон төдийгүй асуудлыг дэвэргэх, нотолгоо баримтгүйгээр хэн нэгэн эсвэл байгууллагыг буруутгах хандлага түгээмэл болсон нь ажлаа хэвийн явуулахад сэтгэл зүйн дарамт ачаалал болдог талаар дурдсан байна. Хүний эрх хамгаалагчийн тогтолцоо бүрдсэнээр цагдаагийн байгууллага нь аюул эрсдэлд өртсөн, өртөж болзошгүй хүний эрхийн хамгаалагч, түүний хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан хэдий ч хамгаалалтын арга хэмжээнд шаардагдах зардал төсөвт тусгагдаагүй байна.

Иймээс Цагдаагийн ерөнхий газрын гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн орон тоог нэмэгдүүлэх асуудлыг судалж, хамгаалалтын арга хэмжээний зардлын тооцооллыг гарган улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна гэсэн ийм саналыг хүргүүлж байна.

Хоёрдугаарт Зөрчил шийдвэрлэх тухай хуульд 5.20-д заахдаа хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд зөрчил үүсгэн шалгана гэж зохицуулсан боловч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд ямар, хэн, яаж, хэрхэн шалгах харьяаллыг нь тодорхой заагаагүйгээс хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдөж зөрчлийн хэрэг нээгдэхэд хууль зүйн дагуу шийдвэрлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Иймд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд харьяаллыг тодорхой хуульчлан зохицуулах шаардлагатай байна гэсэн саналыг оруулж байна.

Мөн эрүүгийн хэрэг үүсгэх зөрчил шалган шийдвэрлэх тухай үгээ хэлж үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүсийн эрхийг зөрчиж, зөрчсөн эсэх нь ойлгомжгүй байдлаар эрүүгийн хэрэг үүсгээд тэр тэр чигтээ болох энэ асуудал дээр Улсын ерөнхий прокурор анхааралтай хандаж, тухайн хэргүүдийг татаж, хянаж олон нийтэд хэргийн асуудал хэрхэн яаж эцэслэн шийдэгдэж байгаа талаар нийтлэг мэдээлэл өгвөл илүү сайн гэсэн ийм 3 саналыг оруулж байна.

Баярлалаа та бүхэнд. Асуух зүйлд нь хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа Дондов гишүүнд. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт сэдвийн хүрээнд асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Дараагийн асуудал бас горимын санал хураах гэж байна. Эрүү шүүлтээ ярьчихаад тэгье.

14.58 цаг

Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан болон Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсээс тус тайланд хийсэн шинжилгээг гишүүдэд тараасан байгаа.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн танилцуулна.

Бусад хууль хяналтын байгууллагынхан үлдээд бусад оролцож байгаа хүмүүс иргэний нийгмийн байгууллагын хүмүүс явж болно. Баярлалаа. Цэлмэн байгаа юм уу? Мөн энэ асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн үндэсний комиссын дарга Хунан, Цэлмэн Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Эрдэнэбилиг Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Түвшинтөр Хүний эрхийн үндэсний комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах референт, Нэнсэндэн Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн референт, Дэлгэрбаяр Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, Оюун-Эрдэнэ Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, Улсын Ерөнхий прокурорын орлогч Чинбат, Мөрдөн байцаах газрын дарга Батсуурь. Өөр хэн орж байна? Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Баянжаргал, Улсын Ерөнхий прокурорын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор Золжаргал, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, хурандаа Энхтөр, Авиалгалтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга, хурандаа Нэргүй нар бас оролцож байна.

Ийнхүү анх удаа Хүний эрхийн үндэсний комисст анх удаа бие даасан

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн бие даасан гишүүн хуульчлагдсан. Анх удаа Улсын Их Хуралд энэ гишүүн маань Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажлын тайлангаа хэлэлцүүлж байгаа гэдгийг бас тэмдэглэе. Ингээд Цэлмэн гишүүнийг урьж байна. 3 номерын микрофон. 15 минутад багтааж танилцуулъя.

Я.Цэлмэн: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны эрхэм дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд, хуралдаанд оролцож буй Төрийн болон төрийн бус иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилье.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хэрэглэсэн гишүүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ гэж хуульчилсан билээ.

Иймд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн томилогдсон 2022 оны 6 сарын 2, түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжийн албан хаагч томилогдсон 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдрөөс хойших хяналт, шинжилгээ, сургалт сурталчилгаа, хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын албан ёсны статистик судалгаа, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт болон бусад эх сурвалжид үндэслэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайланг 2023 оны 4 дүгээр сар хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамааруулан боловсруулж, 2023 оны 3 дугаар сарын 30-нд Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдэд хүргүүлсэн.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022 оны буюу анхны тайланг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль

эрх зүйн орчны шинэтгэл, эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын онцлог статистикт хийсэн дүн шинжилгээ, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, эрүү шүүлтээс сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажил, дүгнэлт, санал гэсэн бүтэцтэйгээр бэлдэж тайлагнаж байгааг хүлээн авч танилцана уу.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 87 оны 6 сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэн орж соёрхон баталсан бөгөөд энэхүү конвенцод нэгдэн орсон оролцогч улсуудад эрүү шүүлттэй тэмцэх, түүнд өртсөн хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг билээ.

Улмаар Монгол Улсын Их Хурлаас Эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, Эрүү шүүлэгт урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүрэг хүлээсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, чиг үүрэг, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан билээ.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд Монгол Улсаас конвенцын хэрэгжилтийн талаар хүргүүлсэн ээлжит 3 дахь удаагийн 2020 оны тайланд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын бүтцэд бий болгох эрх зүйн үндсийг тавьсан нь тус улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан хараат бус механизм бий болгох эрх зүйн орчныг бүрдүүллээ. Монгол Улсын Засгийн газар Эрүү шүүлтийн эсрэг конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах тал дээр хүчин чармайлт гаргаж байгаа болно гэж тусгагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.12-т хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ гэж заасан. Эрүү шүүлтийн эсрэг конвенц түүний нэмэлт протокол Монгол Улсын хүний эрхийн комиссын тухай хуульд заасан зарчимд нийцүүлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны алсын харааг эрүү шүүлтгүй Монголын төлөө гэж тодорхойлон эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судалж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч нь байх эрхэм зорилгыг тавьж дараах стратегийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

Урьдчилан сэргийлэх, хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагаа бүхий тогтолцоог бэхжүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хяналт

шинжилгээг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэх, хүн бүрд эрүү шүүлтээс ангид байх эрхийг нь мэдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хэргийн хэрэгжилтийг хангуулах зэрэг болно.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд заасан бүх газар буюу хүн өөрийн хүслээр гарч явах боломжгүй нөхцөлтэй нийт 843 газарт давтагдсан тоогоор жилд 144942 иргэн урт, богино ямар нэг хугацаагаар байрлаж байгаагаас нэн тэргүүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн ойролцоогоор 37000 гаруй хүнд тогтмол хүрэлцэж, хяналт шинжилгээ урьд урьдчилан сэргийлэх ажлыг хууль олон улсын гэрээнд зааснаар хийх шаардлагатай байгаа бөгөөд энэхүү урьдчилан сэргийлэх ажлыг шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын удирдлага, тэдгээрийн албан хаагчдын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжтой юм.

Ялангуяа эдгээр 843 газрын удирдлага, алба хаагчдын манлайлал, хүний эрхийн мэдрэмж, хандлага, хэлбэрийн төдий бус үйл ажиллагаа туйлын чухал байгааг онцлох нь зүйтэй. Бид тайлангийн хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хийсэн ажлууд удаас товч хураангуйлан танилцуулбал, 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдрөөс хойш нэгжсийн 5 албан хаагчтайгаар Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Шүүх, сэтгэц эмгэг судлалын клиник, асрамжийн тасгууд, ахмад настны үндэсний төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв орон нутагт байрлах хорих анги, цагдан хорих хаалттай 461 дүгээр анги, баривчлах байр, цагдан хорих байр, Цагдаагийн ерөнхий газрын харьяа цагдаагийн газар, хэлтсүүдийн эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр, сургуулийн дотуур байр зэрэг нийт 23 газар орон байршилд батлагдсан

удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийж, тэдгээр газар төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрийн хүсэлтээр гарч явах эрхээ хязгаарлуулсан хүмүүсийн эрхийн хэрэгжилт мөн алба хаагчдын хөдөлмөрлөх нөхцөлд эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийн асуудлыг судаллаа.

Хяналт шинжилгээний хүрээнд нийт 10614 километр зам туулан өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй нөхцөлд байгаа 1954 хүнээс олон улсын жишиг стандарт, өөрийн улсын хууль эрх зөв орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж авч, хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон, баривчлагдсан 411 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж, 48 ажилтан алба хаагчтай өөрсдийнх нь хүсэлтээр уулзаж, 209 хүн зөвлөгөө өгч харьяаллын дагуу 6 гомдлыг шилжүүлэн шалгуулсан байна.

Үндэсний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй нөхцөл байдлыг арилгуулах, урьдчилан сэргий хийлэх зорилгоор байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд 11 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг тооцон ажиллалаа.

Мөн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын албан хаагч зорилтот бүлгийн иргэд буюу 3357 хүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх болон хүний эрхийн асуудлаар сургалтууд хийж, сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах төрийн албан хаагч, хуулийн этгээд, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үүрэг гүйцэтгэх үйл ажиллагаанд хийх мониторинг, аливаа хэлбэрээр хүүхдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, эс үгүй бол

тухайн хүүхэд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй төрийн болон төрийн бус байгууллагууд хийх хяналт шинжилгээ мониторинг сэдэвт тусгайлсан гарын авлагуудыг эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор бүтээж, эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 8 удаа, цахим мэдээллийн хэрэгслээр 32 удаа, олон давтамжтайгаар сурталчлан ажилласан бөгөөд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар тухай бүр цахим хуудсаараа олон нийтэд мэдээлж ирлээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааныхаа чиг үүргийн хүрээнд зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаа, эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн явуулахад анхааран ажиллаж бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагатай олон талт түншлэлийг хөгжүүлэх үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагуудын бүсийн уулзалтад оролцох, ялангуяа хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдсан газруудад хяналт тавих аргачлалын талаар харилцан туршилага солилцоход чиглэгдсэн олон улсын уулзалт, үйл ажиллагаануудад идэвхтэй оролцох бодлогыг баримталж байна. Тухайлбал, Эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протокол болон олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн Монгол Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад нэгжийн алба хаагчдыг чадавхжуулах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэхээр Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо, эрүүл шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж эхлээд байна.

Эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протокол батлагдсаны 20, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан нэмэлт протоколд нэгдэн орсон оролцогч улсуудын үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны ололт амжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар санал бодлоо солилцох нэмэлт протоколыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд улс орнуудын үндэсний ажиллагаанууд сайн туршилагаасаа хуваалцах, цаашид хамтран ажиллах боломжийг олгох мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмын үүрэг, ирээдүйг тодорхойлогдох чиглэгдэх зорилготой Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 2 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан хуралд Монгол Улс үндэсний урьдчилан сэргийлэх механизмаа байгуулагдсантай холбогдуулан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг биечлэн оролцохыг урьсан нь манай улсыг олон улсын өмнө хүлээсэн гэрээний үүргээ нэр төртэйгөөр биелүүлж байгааг онцолсон үйл явдал юм.

Тус хуралд Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Элчин сайд НҮБ-ын Женев дэх Байнгын төлөөлөгч Гэрэлмаа Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, уг арга хэмжээнд уг хэлсэн бөгөөд Монгол Улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баримталж байгаа бодлого, стратеги болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаа түүний үр нөлөөг цаашид хэрхэн сайжруулах арга зам, бодлогыг дурдаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо бусад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг улам өргөжүүлж байгаа талаар танилцуулж, Монгол Улсын Засгийн газрын зүгээс эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг улам чадавхжуулах, бэхжүүлэхэд анхаарч бие даасан хараат бус байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг сайжруулахад дэмжин ажиллахаар зорьж байгаа тухай

илтгэлдээ дурдсан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос манай улсыг үндэсний урьдчилан сэргийлэх механизмаа байгуулан бэхжүүлж, дэлхий нийтийн хүний эрхийг хамгаалах үйл хэргийг тогтмол дэмжиж, идэвх санаачилга, гаргаж буй явдлыг тухайлан сайшаасан юм.

Харамсалтай нь эрүү шүүлт тулгаж хүнлэг бусаар доромжлон харьцаж, хууль бусаар мөрдөх нотлох ажиллагаа явуулж олон жилийн ял шийтгэсэн үйл баримт олон нийтэд дэлгэгдэж, нийгмийг айдаст автуулж, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг үгүйсгэсэн үйлдэл, эс үйлдэл өнгөрсөн цаг хугацаанд гарч, түүний сүүдэр одоог хүртэл арилахгүй байна.

Монгол Улсынхаа Үндсэн хууль олон улсын гэрээгээр хамгаалсан хүний эрхийн төлөө иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, эрсдэлээс үл айн зориг гарган зүтгэж байгаа олон олон шударга төрийн албан хаагч, хүнлэг хүмүүсийн идэвх санаачилга, бодит үйл ажиллагаа, олон нийтийн дэмжлэгийн үр дүнд бид хүний халдашгүй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн аймшигт зөрчлийг мэдэж, хожуу ч гэсэн хор хохирлыг засаж залруулах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх боломж гарлаа.

Дахин ийм харамсалтай хүний үнэт зүйл мөн чанарыг үгүйсгэсэн харгис хэрэг гаргуулахгүйн тулд бид эрүү шүүлтийн эсрэг хамтдаа чин сэтгэлээсээ үр дүнтэй тэмцэж үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг тогтолцооны хувьд цаг алдалгүй улам бэхжүүлэх нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хууль Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн чухлыг эргэн санаж Нэгдсэн Үндэстний

байгууллагын хүний эрхийн механизм, тэдгээрийн хараат бус шинжээч, ажлын хэсгийн зөвлөмжийг гарцаагүй хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарч, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад шинээр бүрэлдэн бий болж байгаа эмзэг цаг үе гэдгийг мэдэрч, маш олон хаалттай албаны цаана байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахыг чухалчлан хууль тогтоогч, улс төрч, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хүний эрхийн болон нийгмийн зүтгэлтэн, судлаачид, иргэдийн оролцоо, дэмжлэг нэн хэрэгтэй байгааг тодотгон Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгарч буй сорил бэрхшээлүүдийг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан түүнд тусгасан асуудлын хүрээнд холбогдох шийдвэрийг гаргаж өгнө үү. Анхаарал хандуулсан та бүхэд баярлалаа. Танилцуулж дууслаа.

Б.Энхбаяр: Цэлмэн гишүүнд баярлалаа. Эрүүдэн шүүхийн шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлантай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Би асуулт асууна тэгвэл.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хэн ч болов эрүү шүүлт тулгахаас ангид байх үндсэн эрхтэй байгаа. Эрүүдэн шүүлтийн асуудлыг бол яах вэ сүүлийн үед энэ Зориг агсны амь нас бүрэлгэсэн хэрэгтэй холбоотой 3 шатын шүүхээс ял шийтгэгдсэн хүмүүс энэ хэргийг түрүүн хэлсэнчлэн прокуророос хэрэгсэхгүй болгосон тухай танилцуулсан. Энэ бол манай бүхэлдээ хууль шүүхийн байгууллагад асуулт, дараа нь анхаарлын тэмдэгтэй өгч байгаа ийм зүйл болж байгаа. Эрүүдэн шүүлт байна. Энэ ер нь ардчилсан Монгол Улсад хүний эрхийг хуульчилсан

Үндсэн хуульд тогтолцоог бэхжүүлээд 30 гаруй жил болж байхад энэ ер нь арилах болоогүй юу гэдэг зүй ёсны асуулт гарч ирж байна. Тэгээд энэ чиглэлээр түрүүн бас олон Хүний эрхийн үндэсний комиссын гишүүд мэдээлэл өгсөн.

Тухайлан хэд хэдэн асуулт байгаа юм. Нэгдүгээрт энэ хаалттай хорих ангид ял шийтгэж байгаа хүмүүст нэг улаан шугам гэдэг ойлголт байна. Ингээд улаан шугам хэтрэх ч болохгүй гээд суулгадаг. Энэ бүүр 10-12 цагаар суулгадаг. Ингээд улаан мах нь эргэдэг хоригдлуудын, нуруу өвддөг тэгээд удаан суулгаад бие засах гэхээр нь босгодоггүй энэ бол эрүүдэн шүүлт. Тэгэхээр энэ хорих ял эдэлж байгаа хорих ангиудад энэ улаан шугам гэдгийг энэ ямар эрх зүйн акт, дүрэм журмаар зохицуулж ингэж хэрэглээд байна вэ? Энэ асуудал дээр эрүү шүүлтийн гишүүн судалж үзсэн үү? Ямар арга хэмжээ авч байна вэ гэсэн эхний асуулт байна.

Хоёр дахь асуулт би бас 2 жилийн өмнө Хууль зүйн байнгын хорооны хурал дээр хэлж байсан. Тэгээд энэ урьдчилсан саатуулах 461 дүгээр ангид камергүй нэг булан тохой байдаг. Тэгээд тэнд саатуулагдаж байгаа тэнд чинь гэм буруутай нь нотлогдоогүй, шүүхээр ороогүй, шалгагдаж байгаа хүмүүс байгаад байгаа шүү дээ. Гэм буруу нь нотлогдоогүй. Тэгэхээр тэнд хүнд ял хорих ялтнуудтай нэг камерт оруулдаг хөнгөн гэмт хэрэгтнийг, камер сэлгэдэг тэгээд тэр нөгөө камергүй булан тохойд очиж байгаад зоддог ийм тухай бас асуудлыг би хөндөж ярьж байсан. Тэгэхээр энийг үзсэн үү? Ийм камергүй булан тохой байна уу? Энэ асуудал дээр үзэж дүгнэлт өгсөн асуудал байна уу гэсэн хоёр дахь асуулт байгаа юм.

Гурав дахь асуудал нь энэ Нэгдсэн Үндэстний байгууллагын Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх комиссар Монгол Улсад ажилласан. Олон байгууллагуудаар орсон, олон албан тушаалтантай уулзсан. Тэр дотроо Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд

бас миний бие уулзсан. Чөлөөтэй ажиллах бололцоогоор хангаж ажилласан Монгол Улсын Засгийн газар. Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага дээр ажилласан байгаа. Одоо манайхан бол Шар хад гэж ярьдаг. 1980-аад онд энэ Шар хадны эмч нарын хэрэг гэж их том дуулиант хэрэг мандаж байсан. Өөрөөр хэлбэл онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг сэтгэцийн өвчтэй гэсэн худлаа дүгнэлт, магадалгаа гаргаж гэмт хэрэгтнүүдэд ял завшуулж байсан асуудал илэрч байсан. Энэ бол нэлээн дуулиан тарьж байсан. Одоо энэ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд ер нь эмчлүүлж байгаа хүмүүсийн асуудлыг авч үзсэн үү? Энэ хүмүүс дээр нийгмийн халамжийн тэтгэмж олгогддог. Энэ бол жилдээ 470 орчим сая төгрөгийн халамжийн тэтгэвэр улсаас өгөгддөг.

Тэгэхээр энэ хүмүүс сэтгэцийн өвчтэй гэдгээр энэ мөнгө нь тэр хүмүүстээ зарцуулагддаггүй, өмнөөс нь Сэтгэцийн эрүүл мэндийн удирдлагууд энэ мөнгийг нь завидаг тухай мэдээлэл авагдсан. Өөрөөр хэлбэл хүнийг сэтгэцийн өвчтэй гэдгээр эмнэлэгт эмчилж байгаа байлгаад. Ингээд энэ хүмүүсийн бас халамж, мөнгө төгрөгийг нь хувьдаа иддэг, уусдаг асуудал бол их ноцтой асуудал. Энэ цаашидаа ямар ч үр дагавар гаргаж болзошгүй. Хүнийг худлаа хүчээр өвчтэй болгож байна уу эсвэл өвчингүй хүнийг ингээд байлгаад байна уу ял завшуулаад? Тэгэхээр энэ асуудлыг нэг нухацтай авч үзэж, үзмээр юм шиг байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын олон улсын комиссарын гишүүний бас илтгэлд энэ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр бас ажилласан тухай хэсэг байгаа юм. Тэгээд энэ ямар журмаар энэ хүний эрхэд ийм хязгаарлалт хийж байна вэ гэсэн ийм асуулт байгаа юм.

Дөрөвдүгээрт энд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ бас хэрэглэгддэг. Шүүхийн шийдвэрээр албадлагын арга хэмжээ. Албадангаар хэвтүүлдэг. Тэгээд энд албадан эмчлэх

хугацаа нь дуусчихсан 7, хугацаа ерөөсөө байхгүй 13 хүнийг албадаад шийдвэргүйгээр тэнд ингээд албадаад байлгаж байгаа тухай бас мэдээлэл авагдсан. Ямар нэгэн шийдвэргүйгээр хүнийг албадаад өвчтөн гээд ингээд байлгаж байна гэсэн үг. Энэ ямар шүүхийн шийдвэрээр хүнийг ингэж шийдвэргүйгээр байлгана гэдэг энэ бол бас ноцтой асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр энэ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний гишүүн үзэж харсан зүйл байна уу, дүгнэлт хийсэн асуудал байна уу гэсэн ийм 4 асуулт байна. 3 номерын микрофон.

Я.Цэлмэн: Баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны даргын асуултад хариулъя. Нэгдүгээр асуудал хаалттай энэ хорих ангид энэ улаан шугамын асуудал гээд Энэ өөрөө бид нар судалж үзсэн хяналт шинжилгээнүүд яг энэ 23 объектын зарим хэсэг нь хаалттай хорих анги байсан өнгөрсөн хугацаанд. Энэ дээр ямар журам үйлчилж байгаа вэ гэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/192, /81 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлын тойрог тогтоох журам гэсэн энэ журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт энэ тухай заасан байдаг. Хорих байгууллага нь аюулгүйн тойргийн хэмжээ мөрдөгдөх боломжгүй газарт хорих байрны зохион байгуулалт онцлогт тохируулан хана, шалны хэсэгт хоригдогчийн хөдөлгөөнийг хориглосон тэмдэглэгээ хийнэ. Ингээд аюулгүйн тойргийг зөвшөөрөлгүй нэвтэрсэн хөдөлгөөнийг хориглосон тэмдэглэгээг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулна гэж. Энэ асуудал явсан, хяналт шинжилгээ хийсэн хорих ангиуд дээр нийтлэг зөрчил байдлаар гарч ирсэн.

Ялангуяа энэ хорих ангиудад яг асуумж авсан байгаа. Энэ хорих ял эдэлж байгаа хүмүүсээс. Энэ хүмүүсийн авсан асуумжаар яг энэ асуудал бол өөрсдийнх нь ялангуяа сэтгэгдэл дээр бичиж үлдээнэ үү гэсэн хэсэг дээр

тодорхой дурдагдсан байдаг. Удаан хугацаагаар суудаг, өглөө бослогын дараагаас оройны тоо хүртэл ингэж суулгаж байгаа. Яагаад ингэж суулгаж байгаа вэ гэхээр нь ажил хийх боломжгүй энэ хорих ял эдэлж байгаа хүмүүсийг ингэж суулгадаг гэсэн асуудлыг яах вэ хяналт шинжилгээний хүрээнд ярьдаг. Албан тушаалтнууд нь хорих ангийн зарим удирдлага бол ийм асуудал байхгүй гэдэг. Зарим удирдлага энэ асуудал яах вэ тодорхой цагийн хязгаарлалттайгаар байгаа. Энэ нь эргээд алба хаагчдын аюулгүй байдал мөн хорих ял эдэлж байгаа хүмүүсийн хоорондын аюулгүй байдлыг зохицуулах ийм зохицуулалттай гэсэн. Энийг зохицуулахад тодорхой чиглэл ийм саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд зөвлөмж байдлаар хүргүүлсэн байгаа. Энэ хорих ял эдэлж байгаа хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийн нөхцөлийг сайжруулах ийм гарцаагүй шаардлага байгаа. Тэгэхгүйгээс болоод энд ийм удаан хугацаагаар сууна гэдэг хүний тухай хорих ял эдэлж байгаа хүмүүсийн үндсэн бас эрхийг зөрчөөд, дээрээс нь эрүүл мэндийн байдалд ноцтой үр дагавар хүргэдэг гэсэн ийм дүгнэлтэд хяналт шинжилгээний хүрээнд хүрсэн байгаа.

Тэгэхээр энэ журам дээрээ бас эргэж харах шаардлагатай. Ер нь Улсын ерөнхий прокурортой бас уулзалт хийсэн. Энэ хүрээнд Улсын ерөнхий прокуророос ч бас яг энэ улаан шугамын асуудал, удаанаар суулгадаг асуудлыг болиулах чиглэлийг өгсөн гэсэн ийм мэдээлэл бас бид нарт харилцан солилцсон. Тэгэхээр энэ дээр тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй байгаа юм.

Дараагийнх нь болохоор 461 дүгээр ангид байгаа хяналт шинжилгээ, камергүй булан тохойны асуудал бас байсан. Та бас өмнө нь бас энэ асуудлыг дурдаж байсан. Тэрийг үзэж байсан. Тэгээд энэ дээр онцгой анхаарал хандуулж 461 дүгээр анги дээр бид нар бүтэн ажлын 5 өдрийн хугацаанд хяналт шинжилгээ хийсэн. Энэ хяналт

шинжилгээний хүрээнд нэлээдгүй хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд хяналт шинжилгээгээр илэрч, зөвлөмжийг бол хүргүүлсэн байдаг. Энэ камергүй булан тохойны асуудлыг нэг бүрчлэн тэр хорих ангийн дарга болон бусад холбогдох ажилтнуудын хамт явж бид нар шалгасан. Ийм хорих ийм камергүй булан тохойг бид нар түүнээс хойш засаж янзлаад, одоо камергүй булан тохой байхгүй гэсэн ийм хариуг бид нарт өгсөн. Бид нар хаана хаана, ямар байдалтай байсан гэдгийг бас биечлэн үзсэн байгаа.

461 дүгээр анги дээр нийтлэг хамгийн их анзаарагдаж байгаа зүйл бол тэнд гэм буруутай нь тогтоогдсон хүмүүс дийлэнх нь байхгүй, сэжигтнээр, сэжигтэн яллагдагчаар цагдан хоригдож, ингэж шалгагдаж байгаа хүмүүс байгаа. Энэ.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гүйцээгээд хариулаарай, товч хариулаарай. 3 номерын микрофон.

Я.Цэлмэн: Энэ дээрээс хамгийн нэг анхаарал татсан зүйл бол бид нарын судалгаан дээр энэ цагдан хорьж энэ шалгагдаж байгаа хүмүүс энэ шүүхийн шийдвэрээр буюу шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх хугацаанд цагдан хорих сунгаж байгаа асуудал бол анхаарал татсан байгаа. Одоогийн байдлаар 3 хүн байгаа. Хугацаа хэтэрсэн байдлаар мөрдөн байцаалтын шатанд цагдан хоригдож, шалгагдаж байгаа. Энэ нь болохоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан 18 сар тодорхой төрлийн 4 хэрэг байгаа. 6 сар өөр хүртэл хугацаанд сунгаж болохоор шүүхээс. Ингээд энэ 24 сарын хугацаа нь хэтэрсэн хүмүүс гэсэн үг. Гэтэл энийг болохоор юу гэж тайлбарлаж шүүхээс авч үзээд байдаг вэ гэхээр шүүгдэгчид шүүгдэгчийг яллагдагчид ингэж хамруулж ойлгохгүй зохицуулалттай гээд ингээд тайлбарлаад байдаг. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дээр болохоор энэ яллагдагчийн эрх, үүрэг

шүүгдэгчид нэгэн адил хамаарна гэгчихсэн байгаа.

Тэгэхээр энэ 24 сараас илүү хугацаагаар цагдан хорьж байгаа асуудлыг эргэн судалж энийг эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байгаа юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиараа. Одоо бол 461 дүгээр ангийн байдал сайжирсан. Яг зөвлөмжийн дагуу хийсэн. 461 дүгээр ангийн удирдлага солигдсоноос хойш дахин судалгаа хийсэн. Ингээд бид нар 461-ээс хүмүүс хүсэлт гаргахад бол 7 хоногтоо тогтмол бараг очдог болж байна. Одоо бол энд очиж цагдан хоригдож байгаа хүмүүсээс санал сэтгэгдэл авахад сүүлийн үед энэ 461 дүгээр ангийн нөхцөл байдал сайжирсан талаар тогтмол ийм судалгаанд ингэж бичиж тэмдэглэж үлдээгээд байгаа. Ярилцлагаар ч мөн тэгж тогтоогдож байгаа. Гомдлыг өдөрт нь шилжүүлдэг болсон. Түүнээс тэндээс яг над руу ирж байгаа гомдол бол бараг өдөртөө шууд ирдэг. Цахимаар, даргаар нь дамжаад ийм болсон байгаа.

Сэтгэцийн эрүүл мэндийн төвд хяналт шинжилгээ бид нар хийсэн. Энэ бол бид нарын анх хийсэн хяналт шинжилгээний энэ газар байсан. Энд болохоор 200 гаруй ийм асрамжийн тасагт нь ар гэр нь авч асран хамгаалах үүргээ биелүүлэхээ больсон, нэг ёсондоо эмнэлэгт нь ингэж үлдээсэн ийм асрамжлуулагчийн асуудал байгаа. Үүний хяналт шинжилгээний хүрээнд бол тухайн хүмүүсийн халамж, тэтгэврийн мөнгөний зарцуулалт бол бүртгэлгүй, судалгаагүй, тухайн тасгийг хариуцаж байсан эрхлэгчдийн хийсэн уулзалтаар бол өөрсдөд нь зориулдаг, сувилагч дагуулж явж авах авхуулж өгдөг гэсэн. Энэнтэй холбоотой гомдол, мэдээллийг Баянзүрх дүүргийн цагдаагийн байгууллага шалгуулаад Баянзүрх дүүргийн цагдаагаас Авилагтай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байгаа. Энэ 200 гаруй хүний тэр нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгө

байгаа. Тэгээд одоо бол зөвлөмж бас өгсөн. Өмнө нь бас Хүний эрхийн комиссын гишүүн Нарантуяа бас яг энэ газар ажиллаж ингэж энэ шалгалт хийсэн хүрээнд бас энэ асуудал тогтоогдсон. Мөн зөвлөмж өгсөн байсан. Тэгээд энэ асуудал удаа дараа ингэж биелэхгүй байгаа асуудлыг захиралд нь зөвлөмж өгч одоо нийгмийн ажилтнаар ингэж авхуулж байгаа гэсэн.

Гэхдээ энэ нь ч гэсэн хууль зүйн үндэслэл зохицуулалтгүй. Энийг шийдвэрлэх нэг боломж бас гарц гаргалгаа байна гэж харж байгаа. Энэ болохоор энэ төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэтгэвэр олгох журмынтай адилтгасан ийм журмыг асрамжийн тасагт нэгэнт бүх насаараа эмчлүүлж байгаа энэ хүмүүстэй бас хэрэглэж, энэ 70, 30 буюу энэ авч байгаа тэтгэмжийн 30 хувийг бол яах вэ тодорхой заасан энэ зүйлүүдэд зарцуулахаар зохицуулах нь зүйтэй юм болов уу гэсэн энэ саналыг бас хүргүүлсэн холбогдох яаманд.

Дараа нь энэ эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээний асуудал байгаа. Түрүүн Энхбаяр даргын яг дурдсан тоон мэдээтэй бид нар хяналт шинжилгээ хийхэд ийм хүмүүс байсан. Шүүхийн шийтгэх тогтоол дээр заримдаа хугацаа заадаг, заримдаа хугацаа заадаггүй. Тэгээд тодорхой нөхцөл байдлыг бас мөн зааж өгөхгүй.

Гэтэл энэ хүмүүсийн хугацаа дуусаад яг тэр албадан эмчлэгдэж байгаа энэ Сэтгэц эмгэг судлалын клиникийн тасгаасаа хаашаа явах нь тодорхойгүй байгаа журмаар. Тэгээд нэг ёсондоо үндсэндээ шүүхийн тогтоол дээр хугацаатай хожчихоод, хугацаа нь дуусахад бүх насаараа тэнд хоригдох ийм нөхцөл байдалтай байгаа юм.

Дээрээс нь тэнд бас захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх хүнийг бас эрүүгийн хэргээр албадан

эмчилгээ хийлгэж байгаа хүнтэй нэг дор яах вэ байлгасан асуудал гарсан. Мөн насанд хүрэгчид хүүхдийн бас тэнд албадан эмчилнэ ийм зөрчлүүд гарсан. Үүнтэй холбоотой зүйлийг засаж сайжруулах шаардлагатай гэдэг дээр энэ өмнө нь гаргасан энэ хамтарсан журам байдаг юм байна лээ. Яг энэ хүмүүс дээр эмнэлгийн чанартай албадлага арга хэмжээ хэрэглэсэн хүмүүс дээр хяналт тавих, эмчлэх ийм журам. Үүнийг шинэчлэх шаардлагатай гэсэн зөвлөмжийг бас Эрүүл мэндийн сайд Хууль зүйн сайдад бас хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлж дууслаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан хэлэлцэж дууслаа.

Одоо горимын санал миний бие гаргах гэж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.4-д энэ хуулийн 112.2.2, 112.2.8, 112.2.12-т заасан танилцуулга, мэдээллийг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасан байна.

Тийм учраас миний хувьд Хүний эрхийн үндэсний комиссын 2022 оны тайлан, илтгэл мөн Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах нь зүйтэй, шаардлагатай гэж үзэж байгаа.

Тэгэхээр нэгдсэн хуралдаанд танилцуулъя гэдэг горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хэн ирцэд ороогүй байна? Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье. Ирцээс гарчихсан байна Пүрэвдорж гишүүний карт. За сая карт нь.

Б.Пүрэвдорж: Сая миний карт ирцээс гарчихсан байна. Тийм учраас саналаа өгч чадсангүй. Дахин санал хурааж өгнө үү.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Энэ карт ажиллахгүй байгаа юм байна. Тэгэхээр дэгийн тухай хуульд заасны дагуу бас гараар санал хурааж болно. Тийм учраас санал хураалтыг гараар явуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. 10-аас 6 гишүүн 60 хувийн саналаар дэмжигдлээ. Тийм учраас санал хураалтыг гараар явуулъя. Саяын хэлсэн горимын саналаар Хүний эрхийн үндэсний комиссын 2022 оны тайлан, илтгэл болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан, илтгэлийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

10-аас 6, 60 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгалан танилцуулна. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Хууль зүйн байнгын хорооны өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа.

15.32 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

